

84p7
P-93



А. РЫБАКОВ

КРОШИЙН
ЗУНЫ
ТЭМДЭГЛЭЛ

ББК

84(2p)
P.931

84p7
P-93



А.РЫБАКОВ

КРОШИЙН
ЭЧНЫ
ТЭМДЭГЛЭЛ

ББК
84(2p)
P.931

АНАТОЛИЙ РЫБАКОВ

КРОШИЙН ЗУНЫ ТЭМДЭГЛЭЛ (Сургуулийн дунд, ахлах насныханд)

“БНМАУ. Ардын боловсролын яамны хэвлэл” Улаанбаатар хотноо 1974 онд эрхлэн хэвлүүлсэн номоос


Цогт охин тэнгэр сангийн захиалгаар Цагаан бамбарууш хэвлэлийн газарт 2021 онд цахим хэлбэрт хөрвүүлэв.



ЦАХИМ НОМЫН САН: www.e-nom.mn

-

Уг номыг “[Болор дуран](#)” шалгуураар шүүсэн болно.
Программтай танилцах бол сурталчилгаа дээр товшиж холбоос руу
орно уу.



БОЛОР ДУРАН 2.0
АЛДАА ШАЛГУУР

**“БОЛОР ДУРАН”
ЗӨВ БИЧИГ ШАЛГАХ
ПРОГРАМ**

- ✓ 60 сая үгийн сантай.
- ✓ Алдаатай үгсийг илрүүлж, зөв үгсийг санал болгоно.
- ✓ Хэлзүйн тайлбар тольтой.
- ✓ Хувийн үгийн сан үүсгэх боломжтой.

БОЛОР

-

АНАТОЛИЙ РЫБАКОВ

КАНИКУЛЫ КРОША

Орчуулсан Г. Аким

*«Хөвүүн алсыг ширтэнэ. Мэлмийд нь юу үзэгднэм бэ?
Жигүүртний донгодох дуун адил битүүлэг дүр хөвүүний
хүслийн үзүүрт тодорно уу? Ер санасан бүхэн сэтгэлчлэн
бүтдэг болгохын тулд бид юу хийв?»
«Ном барьсан хүүхэд» сийлбэр*

1

Манай байшинд болсон явдлыг бичье. Өөр газар болсон явдлыг ч гэсэн бичнэ л дээ.

Гэхдээ өөрөө хүүрнэх маягаар бичнэ. «Тэр» гэж хэлэхийн оронд «би» гэх, «түүний» шилэн хүзүү дундуур татлаа гэхийн оронд-миний шилэн хүзүү дундуур татаад авлаа гэхийг уран зохиолд хүүрнэх хэлбэр гэж хэлдэг.

Миний номыг найруулаад засчихна, тэгэхлээр уншигчид үүнийг жинхэнэ зохиолч бичиж дээ гэж бодог. Ингэж засахгүй бол зарим номыг уншаад заримыг нь уншихаа больчихно. Хэрэв засаж найруулбал бүгдийг нь дараалан уншиж, хэн хэндээ гомдолгүй байна.

Миний номд хэдэн баатар гарна. Эд цөмөөрөө манай байшинд суудаг юм. Байшингийнхныгаа би андахгүй, би ухаан суусан цагаасаа хойш, аравтайгаасаа энд байгаа билээ. Одоо би арван зургаан настай.

Ганц Костягийнх л өөр гудамжинд байдаг. Костя бол боксчин чөргөр хар залуу билээ. Хашаа дотуур чемоданаа барьчихсан гарч явна гэхээс л цаашгүй, зэгсэн дүнсгэр амьтан. Тэр чемоданд нь боксын бээлий байдаг юм.

Веэн, Игорь хоёрыг гадаа байж байхад би Костятай анх танилцсан юм. Би ч бас гадаа байж таарав. Веэний «Волга» машинаа арчиж байгааг харж зогссон юм. Игорь ч эрүүгээ илэн, Веэний машинаа арчиж байгааг харж байлаа. Үүний өмнө Игорь эрүү рүүгээ дулиулчихсан учир хавдаж уу үгүй юу гэж илж үзэж байсан нь тэр. Хэнд яагаад дулиулчихсаныг нь дараа яримз.

Веэн сэлбэг дугуйг зааж,
— Өргөлцөөч! гэв.

Игорь эрүүгээ илээд завгүй байв. Би дугуйг нь өргөлцөж өгөөд тогтоогуурын эргийг чангалав.

— Чамайг яагаад Крош гэдэг юм? гэж Вээн асуув.

Намайг Сергей гэдэг, Крашенинников гэдэг овгийг минь товчлоод Крош гэж дууддаг. Сургууль дээр нэрийг, тэр тусмаа минийх шиг урт нэрийг заавал товчилдог юм. Ингээд л Крош болчихсон юм даа.

Вээнд үүнийг тайлбарлаж байхдаа «Крошийн паян» туужийг лав уншаагүй юм байна, тэнд энэ тухай тодорхой өгүүлсэн байгаа шүү дээ гэж бодож билээ.

Тэгж байтал Костя ирж бид хоёр танилцсан юм.

— Жаахан давхих уу? гэж Вээн надаас асуув.

— Тэгье.

— Нора хаачив? гэж Вээний асуухад,

— Тэр л ирж явна гэж Игорь эрүүгээ илсээр хэлэв.

Нора хар оймс өмсжээ. Ийм хар оймс харахаас дургүй хүрэхийг минь яана. Нора бас тамхи татсаар байгаад хоолой нь сөөнгө болжээ.

Игорь над руу дохин

— Крош бас явах юм уу гэв.

— Чамаас юм хорогдчих гээд байна уу? гэж үгээр утахад минь, Игорь:

— Би сүйд болохоор юм хэлэв үү? Нора, би хэлсэн үү? гэлээ.

Нора мөрөө ёвгосхийлгээд буруу харав.

Нора Игорь хоёр үйлдвэрлэлд удаан жилээсээ хороох гэж аравдугаар ангиас завсардсан юм. Угтаа бол сурахаас хойш суусан хэрэг. Нора нь хар оймстой сэлгүүцэн, Игорь нь кинонд тоглож байгаа нь энэ гэж олны дотор зургаа авхуулан «Мосфильм» дээр эргэлдэж байгаа бөгөөд үүнийг яалаа гэж удаан жилд тооцох вэ?

Бид Цэцэрлэгийн тойргоор давхив. Троллейбусаар яваа улс биднийг харна. Ханцуйг нь шамласан цагаан цамц, нарийн өмд, хар шагайвч өмссөн, санчиг нь бууралтаж яваа Вээн залуу профессор шиг харагдана. Нора хажууд нь хатагтай аятай заларна. Костя намалдаглаж байхад далдирдаггүй боксчин хүний хүрлэгэр хэнэггүй царайтай ажээ. Ах нь москвичаа өөрт нь бэлэглэх гэж байгаа гэж Игорь бурна. Би л зүгээр явж байлаа.

Вээн урлаг судлагч хүн. Би урлаг судлагчдыг үзэж чаддаггүй юм. Тэд хөгжим сонсоход саад хийж, хамгийн сонирхолтой газар нь тасалчихна. Радиогоор хүн «Фредерик зочдын өрөөнд орж хэлсэн нь... Лаура толгойгоо гунигтайяа сэгсэрнэ. Фредерик...» гэж учир нь огт

олдохгүй юм бавтнаад байхлаар ном уншиж ч, хичээл хийж ч болдоггүй юм. Балай эд!

Гэтэл Везн дүрслэх урлаг судлагч хүн бөгөөд дүрслэх урлаг судлаачид хөгжим чагнахад саад болдоггүй болохоороо шал өөр л дөө. Түүнээс гадна Везн бол урлагийн бүтээл цуглуулдаг хүн. Тэр надтай гадаа л хальт тааралдаж байсан мөртөө нэг л сүрхий хүн шиг санагдаад байдаг юм. Игорь, Костя хоёр түүний ямар нэг даалгаврыг гүйцэтгэдэг бөгөөд түүнийгээ сүрхий юм болж нууцлаад байхад нь би мэдэх юм сан гэж хорхой хөдлөөд байсан юм. Нэг л учир жиг байна. Амьдралыг энэ талаар би мэдэхгүй. Амьдралыг бусад талаар сайн мэднэ. Энэ талаар тааруухан мэдэх учир танилцах гэсэн юм л даа.

Бид цэцэрлэгийн тойргоос гарч Горькийн гудамжны харалдаах нарийн гудамд зогсов. Везн эргэж Костя, Игорь хоёрыг харав.

Цаадуул нь ганц ч үг дуугаралгүй машинаас гарлаа. Везн над руу инээмсэглэв. Ингэж инээмсэглэсэн нь намайг үлд гэсэн дохио байлаа. Би ч хоцорлоо.

Везн, Нора бид гурав дуу шуугүй сууж байлаа. Тэгснээ Везн Нора хоёр хэд гурван үг солив. Тэд аяархан ярилцсан тул би чагнаа ч гэсэнгүй.

Нораг 9 дүгээр ангид байхад нь дагшаа чуулгын жүжигчин эргүүлж сургуулиар л нэг бөөн хэрэг мандаж билээ. Норагийн эмэг эх, олон нийтийн гавьяат зүтгэлтэн комсомолын байгууллагын товчоог дуудаж билээ. Би тэгэхэд товчооны гишүүн байсан юм. Бид очихгүй байя уу гэсэн боловч эмгэний нас дээр гарсан, олон нийтийн өмнө гавьяа байгуулсныг бодоод очсон юм.

Бид эмгэний өмнө гэм хийчихсэн юм шиг гэлбэлзэж зогслоо. Нора зөөлөвчит вандан дээр суучихсан, янжуур савсуулан үнсийг нь цэцгийн сав руу үлээнэ. Хүн замаа алдвал бурууг нь хамт олон хүлээх хэрэгтэй. Яагаад гэвэл сайн харж хандсангүй гэж эмээ ярив. Эмээг залуу байхад өөр байсан юм байх... Бидний хүмүүжлийн ажил сул, бид Нораг сайн харж хамгаалж байсангүй гэнэ... Үүнээс л дагшаа чуулгын жүжигчин гэдэг яриа гарлаа. Жүжигчин, эхнэр хүүхэдтэй хүн. Тэгэхдээ нэг ч биш хоёр хүүхэдтэй шиг билээ дээ...

— Нора, жүжигчин хэдэн хүүхэдтэй сэн билээ?

— Нэг ээ гэж Нора үнсээ цэцгийн сав руу сэгсрэн жишим ч үгүй хариулав.

Норагийн аав, ээж гавьяат жүжигчин. Зав чөлөө муутай улс бөгөөд эмээ өөрөө ч Станиславский зэрэг алдарт хүмүүсийн тухай дуртгал бичээд ажил ихтэй байгаа гэнэ. Дуртгал өсвөрийн үеийг хүмүүжүүлэхэд лут ач холбогдолтой. Нораг хүмүүжүүлэхгүй байгаагаараа бид өсвөр үеийнхнийг хүмүүжүүлэхэд нь эмээд саад болж байна гэнэ. Эмгэн биднийг ингэж урт авсан юм даа.

Гэхдээ дагшаа чуулгын даргыг эмгэн бүр ч лут бангадаж, хөөрхий жүжигчнийг Ферган муж руу удаан хугацааны тоглолтод хөөлгөжээ.

Энэ өвөл Нора ингэж хөглөсөн юм.

Игорь Костя хоёр буцаж ирээд, машиндаа хар цагаан дуугүй сууцгаалаа. Веэн машинаа асааж, бид цэцэрлэгийн тойргоор гэдрэг гэр рүүгээ давхив.

Хашаандаа очоод Веэн:

— Манайд оръё гэлээ.

Хаашаа л харна вэ, хөрөг зураг байна...Торон манжлага, торон нударга бүхий жийрэг цамцтай хэргэмтнүүд, туж алтан саа болсон дүрэмт хувцастай хааны жанжид, үсээ овойлгож самнасан хатад, нэлмэгэр дээл, чихэвч өмссөн эмгэд, жүжгийн их зохиолч Островскийтой төстэй, үстэй дээлтэй худалдаачид, үсэндээ тууз цэцэглэж зангидсан охид, хилэн хувцастай жаалуудын зураг байна...

Шүүгээ, хорго, морин ширээ, тавиур, зөөлөвчит вандан, хөзрийн ширээг хооронд нь шахан тавьжээ. Адраас цэцэглэг дэн унжина. Энэ бүхнийг хуучин цагийн үнэтэй цайтай эд гэж Веэн тайлбарлав. Музейд байдагчлан хүн суулгахгүй гэж хоёр ч олбогт сандлаас олс татаж уяжээ. Тийм нэг үнэтэй вандан дээр Нора, Игорь, Костя гурав суусанд би хачирхав. Нора тэр ч байтугай хөлөө дээр нь тавьчихлаа. Энэ тавилгын дээр сууж болохгүй гэж би бодсон юм. Гэтэл болох ажээ. Олс уясан сандал дээр л сууж болохгүй, эвдэрхий юм гэнээ.

Нора тамхи баагиулна. Игорь соронзон бичлэгийн тууз үзэж, Костя ном эргүүлнэ. Яриа байхгүй догь тухлан авч.

Шилэн нүүртэй шүүгээнээ тавиур дээр мод, чулуу, шаазан жижиг дүрс байна. Энэ бол нэцкэ, японы жижиг баримал. Дорно дахины соёлын музейд иймэрхүү юм байхыг би үзсэн юм.

— Миний цуглуулгад хосгүй зүйл бий

Веэн ингэж хэлээд хэд хэдэн сийлбэр, тавиураас авч ширээн дээр тавив. Тариачин, гэлэн, морьтой хүн, хүүхэд, баг, цэцэг, шувуу, ан амьтан, загасны дүрс байлаа.

Би уран зурагт даанч авьяасгүй. Аятайхан юм, тусгүй юм гэж ялгахаас л цаашгүй. Чухам яагаад аятайхан, яагаад тусгүй байна вэ? гэдгийг хэлж чаддаггүй юм. Судалбар зураг, байгалийн зураг, элдэв хийсвэр зургийн учрыг би ер олноо гэж байхгүй. Хүнийг харж зурсан зураг л аятайхан санагддаг. Третьяковын галерейд байдаг миний дуртай зураг бол Репиний «Загалмайн аян» билээ. Таяг тулсан жаал хүүг санаж байгаа биз дээ? Царайд нь хэчнээн баяр хөөр, итгэл найдвар тодорч, хөвчин бие нь урагш тэмүүлсэн байхыг харахад одоохон ид шидтэй явдал болж энэ хүүгийн бөгтөр нуруу тэнийж, хүү таягаа чулуудаад хүн шиг эрүүл болно гэмээр... Энэ л надад сайхан

санагддаг юм даа. Харин будгийг нь яаж тавьж, гэрлийг хэрхэн тааруулсныг би огт мэдэхгүй.

Везн хонгорцоглосон үстэй, урт шингэн сахалтай өвгөний дүрсийг авав. Өвгөн өрөөсөн гараар дээлийнхээ хормойг барьж өрөөсөндөө хуйлаастай бичиг атгажээ. Энэ сийлбэр ердөө л соруулын дайтай боловч энэ өвгөн их номтой хүн гэдэг нь харсаар илт.

Түүний царай, урт урт атираа, эцэж турсан биеийг нь харахад нэг л мөнх байх гам шиг бодогдоно. Тэнэгэр магнай монгол хүнийхэрхүү буландсан нүд нь амгалан цэцэн цэлмэг ухааныг илтгэнэ. Модоор ийм жижигхэн мөртөө утга төгс дүрс сийлэхэд тун их ажил ордог байж таарна.

— Эрдэмтэн үү? гэж асуухад минь, Везн сийлбэрийг эргүүлж тойруулан үзэж,

— Тиймээ,

— Эдо хотын агуу их уран сийлбэрч нэгдүгээр Мивагийн бүтээл, 18 дугаар зуун, интоорын мод... Юм мэдэхгүй хүн сийлбэр гэхээс цаашгүй, юм мэддэг хүн бол үүнийг үнэлнэ гэв.

Би юм мэддэггүй болохоор жаахан эвгүйцэв.

— Урлаг бол түүнийг хайрлаж, ойлгож хамгаалдаг хүнийх. «Игорийн цэрэглэсэн туужийг» манай үе хүртэл хадгалсан хүн бол түүнийг зохиосон хүнээс дутуугүй үйл бүтээжээ. Микенийг нээсэн Шлиман түүнийг барьж байгуулагчдаас ч илүү юм. Тэд шаардлагатай байсан учраас уг хотыг байгуулсан бол Шлиман урлагт дуртайдаа хөтлөгдөж түүнийг нээсэн юм. Ах дүү Третьяковынхныг байгаагүй бол Оросын уран зураг яах байсан бол оо?

Би хариуд нь, Пушкины:

Уянгын шүлгээрээ би

Уяхан сэтгэл төрүүлнэм

гэсэн үгийг хэлэв.

— Би эс хэл лүү? гэж Нора бах нь ханасан байртай хэлэв.

Энэ Нора намайг өөрсдийнхөө зэрэг дэвд тохирохгүй гэж Везнд урьд нь хэлж байсан гэсэн үгээ. Үүнд би гайхсангүй, Нора бид хоёр бие биеэ үзэж чаддаггүй юм.

— Крош чи хүнээс этгээд хүн байна гэж Игорь хэлэв.

— Гэхдээ Пушкин тэгж хэлсэн юм шүү дээ!

— Пушкин зуун жилийн өмнө амьдарч байсан юм. Балрын үеийн хүн!

— Хүүхдүүд ээ! Сургуульдаа явахаар зах, тахиа аль түрүүн дуугарчихсан гэж Нораг хэлэхэд.

— Хэрэлдэх нь үү? гэж Везн нэг таагүй хэлэв.

— Бид Крошт хайртай, Крошоо, аль вэ үнсэлцье гэж Игорийг хэлэхэд нь,

— Бүү сүржигнэ гэж би түүнд сануулав.

— Шалавхан хувцаслаач, нар цонхоор тусчихлаа. Ойд түлээчин мод цавчих нь дуулдсан гэж Нора үргэлжлүүлэв.

— Үерхэл ийм тоглоом даадаггүй, үерхэлгүй бол хүн байж чадахгүй. Ганц мод гал болдоггүй. Хүн хамт олныхоо дотор тэгширдэг. Гурвуул, дөрвүүл, тавуул нийлж байж ертөнцийг дагуулдаг гэж Везн хэллээ.

— Шадар гурван цэрэг... гэж намайг хэлэхэд Везн

— Ремарк! Ер нь Дюмагийн баатрууд ертөнцийг дагуулж, Ремаркийн баатрууд ертөнцөөс биеэ хамгаалж байна.

— Гурван танкчин, гурван хөгжөөнт анд гэж Игорь аялав.

— Сайхан сэтгэл бол үерхэл юм. Нөхөртөө итгэх нэг л итгэл, хүний гайхамшигт туурвилыг бишрэх нэг л бишрэл байдаг. Үзэл санаа, бодол суртал цөм улирч хувирдаг байхад энэ сийлбэр байж л байх болно. Үүнийг хаан, жанжин, зохиолч, гүн ухаантан барьж үзэж байсан биз дээ. Он жил улирч, хурууных нь ор арилчхаагүй бол үүгээр мөн ч олон их хүний хурууны хээний цомног хийж болох сон. Бид хурууны хээгээр баримал, хөрөг хийж чаддаг сан бол гавлын ясныхаас зөв байх сан гэв.

Чөтгөр ав, нээрээ энэ сийлбэрийг Наполеон ч юм уу, Бальзак ч юм уу, ямар нэг хуанди юм уу, ах дүү Гонкур ч юм уу барьж байсан байж юуны магад. Мундаг бодож олж! Энэ бүхнийг сонсож байхдаа Нора Игорь хоёр вандан дээр ингэж хэнэггүй сууж, Костя нь сэтгүүл тайван эргүүлж байгаа нь хачирхам.

— Хурууны нь ор үлдсэн ч юм бил үү? Маш өчүүхэн ажиглагдахгүй ор үлдсэн байвал хүчирхэг электрон дуран авайгаар яваандаа илрүүлж болно шүү гэхэд минь,

— Болох юм. Гэхдээ үүнтэй үүнгүй эртний зүйлийг үзээд их юм мэдэж болно. Урлагийн бүтээлийг цуглуулах нь сургамжтай, цуглуулна

гэдэг асар их хөдөлмөр ордог мөртөө сохор зоосны л орлоготой байдаг. Ер нь гээд Веэн намайг нэг л өөр харж

— Бид шинэ хувилахуй ухааны үед амьдарч байгаа учир зэс зоос заримдаа алт болох явдал байдаг гэж ярив.

— Юу хэлэх гэснийг нь би сайн ойлгосонгүй.

— Цуглуулах ажил бол уралдаан юм. Цуглуулагч бид бие биеэ андахгүй болохоор юу эрж байгаагаа нууц байлгадаг юм.

— Юу хэлэх гэснийг нь энэ удаа ойлгов.

— Дуулснаа донгосож явдаг нь би биш.

— Надад туслагч хэрэгтэй байна. Костя тусалж байна, Игорь ч гэсэн тэр. Чи надад туслах уу?

— Тэгье, тэгье.

— Урлагийн ертөнц ухааныг чинь тэлж, соёлт хүн болоход чинь тусална. Чи соёлт хун болох дуртай юу?

— Дуртай.

— Хорь алдаж нэг онож болно. Гэхдээ ойр зуур зарах мөнгө олох л байх.

Би лав час улайсан байхаа. Тусалж, тус хийсний шанд мөнгө авах гэж үү? Нөгөөтээгүүр ганц нэг мөнгө өгөөч гэж ээжээс шалж байж залхлаа. Надад бас магнитофон хэрэгтэй.

— Чи эцэг эхээсээ юм нуух ёсгүй, гэхдээ тэдэнд далан булчирхайгаа тоочих бас албагүй. Хүн бүр мөрөө хөөх эрхтэй байдаг.

Зүйтэй. Манай эцэг эх над юм болгоныг яриад байдаггүй шиг би тэдэнд бүгдийг тоочдоггүй. Хүн бүхэн мөрөө хөөх эрхтэй байдаг.

— Миний аав ээж миний хувийн амьдралд хөндлөнгөөс оролцдоггүй гэж би хэллээ.

Над бол үерхэл зүй ёсны зүйл. Би гурвуул, тавуул найзлах тухай бодож байсан удаагүй, олуулаа найзлах нь дэндүү нүсэр бөгөөд шуудайд хийчихсэн үхрийн эвэр шиг л байна гэсэн үг. Гурвуул, тавуул үерхэх нь юунд хэрэгтэй юм гэдэгт гол нь байгаа юм. Хамт олны дотор хүн тэгширдэггүй. Хамт олон бол ёс суртахууны ай мөн. «Хамт олон бол ёс суртахууны ай» гэж л хариулдаг байж. Гэвч ухаалаг санаа урьдын адил маргаан дууссан хойно толгойд орж ирэв.

Ганц тэгж хэлснээр нь Везнийг дүгнэж болохгүй гэдгийг би ойлгож байлаа. Хүнийг бүх сэтгэл бодол, наанадаж гол санаа бодлоор нь дүгнэх хэрэгтэй. Везний урлагт дуртайг нь авууштай. Нэг юмны мөр хөөсөн хүн бүрийн адил Везн нэлээд өрөөсгөл явцуу бөгөөд дурлаж сонирхсон тэр юм л гол зүйл гэж үзнэ.

Нораг ч бас хүлцэж өнгөрүүлэх талтай. Бүсгүй хүн юм даа, яая гэх вэ.

Игорийн тухайд гэвэл тэр ч яах вэ, чалчаа амьтан газар даа. «Пушкин балрын үеийн хүн» гэнэ. Үгүй мөн хэлэв ээ! Пушкинийг уншиж байхад зүрх гижигдэх шиг болдог юм, нээрээ шүү! «Өсөхөөс өдий болсны бүтээл, өрнөхөөс гандах болсны дурсгал, хашир суусан оюуны минь ажиглал, хал үзсэн зүрхний минь тэмдэглэл, эндээ ч инээдтэй, тэндээ ч гунигтай, эгэл байдалтай, илүү чимэгтэй заримдаг бүлгийн түүврийг барья, за яах вэ, таалан авна уу» гэсэн байдаг.

Хэн ингэж хэлж чадах юм бэ? Пушкинээс өөр хэн байх юм бэ!.. «Төөрөлдсөн хувь заяаныхаа эрхээр Москва чамаасаа хагацан одохгүйд, дотор сэтгэлээс минь чи хэзээ ч үл салнам» «Төөрөлдсөн хувь заяаны эрхээр»... гэж! Ямар байна даа!

Гэхдээ Игорь хошигнох дуртай хүн, хошигноно гэдэг бол гол зүйл. Хошин шоггүй бол хүн байж чадахгүй. Пушкиний зохиолын дараа миний хамгийн дуртай ном бол «Амьгүй албат», «Эрэлхэг цэрэг Швейк» «Алтан тугал» билээ. Би эдгээрийг уншаад, уншаад ханадаггүй юм. Чеховын зохиолыг бас хэчнээн л бол хэчнээн уншиж, бүүр инээдээ барчихдаг юм. Нээрээ шүү! Гэхдээ Чеховынх бол өгүүллэгүүд, гэтэл би романы тухай ярьж байгаа. Нэг удаа бид эзэнгүй арал дээр ямар арван роман авч очих байсан бэ гэсэн тоглоом тоглов. Би «Дайн ба энх» «Амьгүй албат» «Улааныхан, харынхан», «Эрэлхэг

цэрэг Швейк», «Дөлгөөн дон», «Алтан тугал» «Шадар гурван цэрэг», «Хоосон горьдлого», «Ундаассан бурхад», «Илгэн оймс» энэ арвыг нэрлэсэн юм. Хэрвээ надаас эзэнгүй арал дээр хэний түүвэр зохиолыг авч очих вэ? гэж асуусан бол би Пушкинийхийг гэж хариулах байсан. Александр Сергеевич Пушкиний түүвэр зохиолыг би эзэнгүй арал дээр авч очих сон.

Эдний дотроос Костя л над бусдаас овоо санагдав. Өдрийн турш хашаанд ч, машинд ч, Везнийд ч ганц ам нээсэнгүй боловч бусдаас илүү сэтгэлд нийцэв. Сайн залуу юм. Боксчин байж ихэрхдэггүй, хүчээрээ түрээ барьдаггүй, олон таван үггүй ийм хүүхэд сэтгэлд таардаг юм.

Хараажийн цагаан цайлган, цаана наана санаагүй эгэл жирийн хүн ч байдаг. Учир нь олдохгүй битүүлэг хүн ч байдаг. Тийм хүнийг би дотроо дандаа цэгнэдэг юм. Харахад битүүлэг юм шиг байтлаа халдаад үзвэл тэнэгээс тэнэг хүн ч бий. Гэвч энэ удаа тийм биш ээ. Костя харахад нэг л битүүлэг, тэр ч байтугай өрөвдөм байлаа. Гар чемодан барьчаад хашаа дотуур өнгөрч явахад нь би үүнийг мэдсэн юм. Огт дуугарахгүй байгаад нь энэ бодол маань улам лавшрав.

Маргааш нь Костятай Везний даалгаврыг биелүүлэх гэж гудамжаар хамт явж, метроны вагонд цуг сууж байхад сайхан байв. Түүнийг ердийн нэг туранхай залуу гэж цөм бодож байхад тэр нэгдүгээр зэргийн боксчин, хүний сүнс ч үлдэхгүй болтол дэлсэж чадах хүн. Вагоны хаалган тушаа хэсэг цадиггүй амьтан зогсчоод орж гарахад саад хийж нэг нь тэр ч байтугай Костяг мөрөөрөө ёвроод авав. Костя эднийг хэдэн тийш нь годройтуулна даа гэж бодсон чинь харин ажиггүй яваад өнгөрдөг байна. Тэгж биеэ барьж чаддагийг нь би гайхав. Хаалган дээр мөн л нэгдүгээр зэргийн боксчин, түүгээр барахгүй спортын мастер ч зогсож байж мэдэх юм биз дээ.

— Эртний түүхийн сурах бичигт элдэв ваар савны зураг байдаг сан. Ийм юмсаар хөөцөлдөнө гэж бодоогүй шүү гэж би үг үүсгэлээ.

Костя хариу дуугарсангүй. Лаглайн сууж байгааг нь харахад тэмцээний завсарлагаагаар амардаг шигээ хэнэггүй царайлан ингэж сууж сурчихсан нь илт.

— Хурууны хээгээр хүний амьд төрх байдлыг гаргана гэдэг сонин санаа шүү. Хурууны орыг судлах ухааны тухай ном чамд байхгүй биз?

— Гүйцэв үү?

— Юу гүйцэв үү гэж?

— Хэл амаа билүүдэж гүйцээгүй юу?

Ямар дүлий дүмбэ оргисон амьтан бэ? Үүнтэй ингэж байх ч тийм аятай юм биш байна. Больё, Везнээс толгой дааж гүйцэтгэх даалгавар авъя. Өнөөдрийнхийг Костятай биелүүлчихье. Дараачийнхыг дангаараа биелүүлнэ.

Арбатын талбайд метроноос гарч Гоголийн цэцэрлэгт гудамжаар явав. Костя хааяа «ийшээ, тийшээ, тийшээ, ийшээ» гэхээс өөр үг үл дуугарна.

Би зогсож:

— Чи наад «ийшээ тийшээ» гэдгээ боль. Бид хаачиж явна вэ? гэсэнд

— Сивцев Вражек руу гэж шүднийхээ завсраар сийгүүлэн хэлэв. Сивцев Вражек тэр надад саарал байшин зааж өгөв.

— Гуравдугаар давхарт гараад наймдугаар хаалганы хонхыг хоёр дар. Клена Сергеевна гэж эмэгтэй гарч ирнэ. Владимир Николаевич явууллаа гээ. Энэ боодлыг өг, тэр чамд өөр нэг боодол өгнө. Давтан хэл.

— Давтлага бол сурлагын эх мөн. Эцэг нь хэн юм бол оо?

Би түүний амыг тагласандаа додигор гэгч нь, боодлыг халаасандаа хийгээд байшингийн үүдээр оров. Боодол маш жижиг, дотор нь дугуйтай утас байгаа юм шиг санагдана. Гэвч энд сийлбэр байгааг би юу эс андах вэ.

Будмал үстэй, янжуур зуусан эмэгтэй намайг тасалгаандаа оруулаад хаалгаа янгинатал хааж, буруу харан боодолтойг үзээд шүүгээндээ далд хийснээ нэг боодолтой юм авч өгөв. Тэгээд намайг үүд хүргэж өгөөд шатан дээр хүн байгаа эсэхийг харав. Тэгэхдээ энэ зуур янжуураа амнаасаа авсангүй.

— Одоо хаачих вэ? гэж би гудамжинд гараад асуув.

— Плющих руу явна аа.

Плющихэд саравч зүүсэн залуухан бүдүүн эр надад хаалга онгойлгож өгөв. Эрүү нь үргэлж хөдлөөд байхлаар бохь зажилж байгаа юм байх даа гэсэн чинь гүдэлзсэнээ хэхэрснийг бодоход бохь зажлаагүй нь мэдээж. Өрөөндөө намайг оруулсангүй, боодлыг аваад хаалга хаачхав. Шат руу ч харсангүйг үзэхэд өрсөлдөгчдөөс айхгүй байгаа бололтой.

Би Костя дээр эргэж ирэв. Костя:

Одоо нэг байшингаар оръё. Би ярина, чи сонсож байгаарай гэв. Өөртэй нь ч, өрөөл бусадтай ч ярих дур алга гэж хэлмээр байв. Гэвч би юм хэлсэнгүй.

Комсомолын гудамжинд Игорьтай дайралдав. Костяг хяламхийснээ «Бүх юм бүтэмжтэй» гэв. Чухам юу бүтсэнийг би лавласангүй. Ер нь юу ч асуухаа больё гэж шийдсэн билээ. Тэгээд ч Костя, Игорь хоёр юм ярих дургүй байгаа нь үзтэл илт. Ер нь Игорь чалчаа хүн, тэгтэл одоо дуугаа хураачхаж.

Игорь гудамжинд хоцров. Костя бид хоёр шинэ байшингийн том хашаанд оров. Хашаа руу лав орвол зуны хуучирсан модон байшин байх бөгөөд хуучин байшин буулгасны дараа ийм байшин үлддэг билээ.

Бидний орсон тасалгаа бас л хуучирсан ажээ. Тааз нь учиргүй өндөр, хөшиг нь пад хар, нүсэр, гандаж онгосон бөгөөд тавилга нь элэгдсэн, уйтгар төрөм ажээ.

Харваас бүх юм нь доройтож өнгө зүс алдсан байлаа. Гэрийн эзэгтэй ч нас дээр гарсан лагс биетэй хүн ажээ. Тарган хөгшчүүл харахаас арчаагүй, өрөвдөлтэй байдаг. Эмгэний царайчилсан харц нэг л дорд байдалтай. Би гэм хийчихсэн юм шиг эвгүй оргив. Тэгэхдээ би ямар ч гэм хийгээгүй, Костя ч гэсэн гэм хийгээгүй. Мань хүн сийлбэрийг нь л үзэж байв.

Монгол байрын шанаархаг царайтай, буландсан нүд, навшгар хамартай хоёр ядуу хөгжимчний дүрс аж. Чүдэнзний хайрцгийн дайтай жижиг модон сийлбэр байлаа. Хөгжимчид салхи бороон дундуур ноорхой хувцсаа дэрвүүлэн явах бөгөөд шар царай нь наранд түлэгджээ. Нэг нь жижигхэн бөмбөр дээр гараа тавьжээ. Тэдний царай, ангайсан амыг нь харахад ямар нэг өрөвдөм, нэгэн хэвийн улиг домог болсон зүйл дуулж байгаа нь илт. Насан туршаа хэрэн тэнүүчилж, насан туршаа зовлон зүдүүр эдэлж яваа... Хөл нь богинохон, толгой нь том, хацар нь шалхайсан бөгөөд өрөөсөн гарыг нь хийгээд, тэдний сэтгэлийн хөдөлгөөнийг гаргах гэж нөгөөг нь зориуд хийсэнгүй ажээ. Модны ийм өөдсөн дээр энэ бүхнийг яаж ингэж гаргасан нь үнэхээр гайхалтай.

— Хэдээр өгөх гэсэн юм? гэж, Костя асуув.

— Тавин рубль байдаг гэж надад хэлсэн юм гэж эмгэн тээнэгэлзэнгүй хэлэв. Би гайхаж хоцров...энэ дүрс ийм үнэтэй байдаг юм гэж үү.

Костя сийлбэрийг ширээн дээр тавив.

— Үүнийгээ та үнэлүүлэх хэрэгтэй юм.

— Ховор юм үнэлдэг газар очих тэнхээ минь хүрэхгүй ээ.

— Хүн явуулчихгүй юу.

— Надад явуулчихмаар хүн байхгүй... гээд эмгэн өрөвдөм

царайчлангуй харснаа

— Та бол хэдээр авах вэ? гэв.

— Та ийм үнэтэй хэлж байгаа болохоор...

— Гэлээ гэхэд та хэдээр авах сан бол?

— Миний нэг найз зантай гоё сийлбэртэй хүүхэлдэйгээр сольж авсан юм даг. Үнэлдэг газар нь үнэлүүлбэл дээр байгаа.

— Би хаашаа гэж явж байх вэ?.. Та ямар үнэтэй гэж бодож байна.

— Сайн даа л арван таван рубль үүнээс ч... гээд Костя

сийлбэрийг дахин авч

— Томотадын буюу Томотадынхыг дуурайлгаж хийсэн зүйлийг цуглуулдаг болохоор л үүнийг авах гэж байгаа юм.

— Жинхэнэ өгөх нь гэж эмгэнийг ярьж өгүүлэхэд,

— Хэн нотлох юм бэ? гээд Костя сийлбэрийг ширээн дээр буцааж тавив.

— За яах вэ, арван таваар авбал ав... гэж эмгэн шүүрс алдан хэлэв.

Бид хоёрыг гудамжинд Игорь хүлээж байсан учир гурвуулаа шорлогын гуанзанд оров. Би эдний журмыг мэдэхгүйдээ хавчигдаад, хий гэснийг нь хийж, дуугүй байхаас өөр аргагүй байв. Хүн юм бүхнийг гайхаж шагшаад байвал маанаг амьтан болж харагдана шүү дээ.

Хөгжимчдийн сийлбэр арван таван рублиэс хэтрэхгүй ч байж болох юм. Гэхдээ үнэ хаялцаж байгааг харахад аягүй. Ингэж байх нь нэг л зээл дээр байгаа юм шиг, залилж дэвэргэж, хэн нь хэнээ шулахыг үзэх гэсэн байдалтай. Тэгвэл дэлгүүрт тийм юм үгүй. Үнэ цэн нь өлгөөтэй байж байна. Авбал аваад байвал байчихна. Мөнгөтэй нь бол авна, байхгүй бол больчихно. Их бага нь ямар хамаатай юм бэ? Гэтэл Костя үнэ хэлэлцэж байдаг. Тэгээд цаад хүн нь хэн бэ гээч. Очиж очиж ядарсан муу эмгэн шүү. «Үнэ нь ахдаж байна» гэх буюу «би бодож байж больё» гэсэн бол хамаагүй дээр байхгүй юу. Тэгээд л явчих хэрэгтэй. Эр хүн үнэ хэлэлцэж байх нь нэрд муухай.

Аавыг томилолтоор явахад ээж бид хоёр гуанзанд хоол иддэг. Би чанамал жимстэй шарвин л голдуу захиалдаг. Хүмүүс хөндий гоймонгоор хачирласан котлет захидгийг бий гайхдаг юм. Шарвин котлетоос хавьгүй амттай шүү дээ.

Гэвч Игорь тохуурхангуй:

— Чи цэцэрлэгийн хүүхэд үү? гэв. Тэгээд хавиргатай шөл, шорлог, «гурван одот» коньяк зуу зуун граммыг захив.

Согтохгүйн тулд би тос жаал цохиж авав. Тос гэдэс дотор архины уур нэвтрэхээргүй өнгөр тогтоодог юм гэнэлээ. Энэ тухай нэг уншсан юм. Зөвхөн юунаас уншсанаа санахгүй байна.

— Чи ч тос сайн гүвдэж байх шив гэж Игорь гайхав. Тос зүрхэнд хүрэн, эгээ л огиулсангүй боловч дотор маань сайн тослогдож ямар ч коньякт алзахааргүй болов. Би дүүрэн хундагыг хөнтөрчихлөө. Намайг хүүхэд гэж Игорь Костя хоёр бүү бодог.

— Коньякийг шимж уух хэрэгтэй. Гадаадад зөвхөн хоолны дараа кофе цайтай уудаг юм гэж Игорийг сургамжлангуй хэлэхэд нь,

— Чи Парисаас ирээд ууж байна уу? гэж би явуулав.

— Үгүй бас хавиргатай шөл өө? Үгүй мөн шорлог оо? Шөлийг вааран саванд хийж өгөх хэрэгтэй, шорлогийг кар маягаар хийх

хэрэгтэй гэж Игорийг мэдэмхийрэхэд,

— Лут мэддэг хүн юм аа гэж Костя догиов.

Костя хүнийг сайн таньж байна, үүнийг үгүйсгэх аргагүй.

Игорийн онгирох нь ч яах вэ, харин хажуугийнхаа хүнтэй яриагүй, хавийн улстай цөмтэй нь ярьж байгаа юм шиг дэндүү чанга чанга дуугарч байгаа нь эвгүй. Түүний яриаг сонсох нь хавийн хүмүүст сонин биш, хажууд нь хүн яриад байх нь тэдний юм бодоход саад болж байж магад шүү дээ.

Игорь ширээн доогуур гараа хийж сийлбэрийг эргүүлж тойруулан үзнэ.

— Ёстой эд байна! Чийдсэнийг нь ээ! Үгүй мөн өнгөтэй, нандин шүү!

Би дүрслэх урлагт авьяасгүй, үүнийгээ ч би түрүүн хэлсэн билээ. Юу ч ойлгохгүй байж, ойлгодог царай гаргаснаас ойлгохгүй байгаагаа шулуухан хэлчих нь дээр. Хүн урлагийн тухай ухаалаг дүртэй нь аргагүй, номчирхож гарахлаар ой гутдаг юм. Игорийг гэрэл, өнгө, төрөл гээд л сагаж гарахлаар дагз дундуур нь, өгчилгөөд авмаар байдгийг яана.

— Чи дахиад «өнгө» гэж дуугарах юм бол чинь дагз дундуур чинь байлгана гэж мэдээрэй гэж би Игорьт сануулав.

Мань эр хэнэггүй гэгч нь

— Чи бол бүдүүлэг хүн, Крош оо! Чамд сайхныг ойлгох сэтгэл байхгүй. Чи энэ сийлбэрийн сайхныг огт ойлгохгүй байна. Хосгүй эд мөн дөө.

— Чи яаж мэддэг юм бэ?

Мэдэхээр барах уу. Би даанч их юм мэддэг болохоор амьд явахаас ч дургүй хүрч байна гээч.

— Төгс номтой хүн юм даа! гээд Костя жуумалзав.

— Энэ сийлбэр хорвоогийн алгийг харуулж байна гэж Игорь мэдэмхийрэн: —Алдарт хөгжимчид байгаад гуйланчид болжээ. Сик транзит глориа мунди¹... Киото хотын Томотадын урлал. Томотада бол Японы хоёрт орох агуу их уран сийлбэрч байгаа юм.

— Хамгийн мундаг нь хэн бэ?

— Мива, Эдогийн нэгдүгээр Мива. Гэхдээ Томотада надад илүү аятайхан санагддаг юм. Энэ хөгжимчдийг харагтун: Ямар сийлсэн байна даа! Үнэ нь ч бардаагаар зуу хүрнэ ээ.

Зуун рубль гэнэ ээ! Ийм юм тийм их үнэтэй гэж үү? Тэгэхлээр Костя тэр эмгэнийг малласан байх нь ээ.

— Дурласан хүн бол зуун тавиар ч авна гэж Костя жишимгүй хэллээ.

Ингэж улаан цайм ярихад нь эгдүү хөдлөв.

— Чи эмгэнийг мэхэлжээ!

— Яалаа гэж! Хуучин юм үнэлдэг газар түүнийг их л базаавал арваар үнэлэх байсан хэмээн Костя хэнэггүй хэлэв.

— Тэгэхлээр бид эмгэнийг ивээсэн болж таарах нь уу?

— Нэг үгээр хэлэхэд тийм гэж Игорь хэлэв.

— Сонин юм аа.

— Сонирхдог хүн тааралдсан бол эмгэн хожих л байсан байх. Луйварчинтай дайралдсан бол яана? Эмгэнд юу хэрэгтэй юм бэ? Архи ууж тамхи татах биш. Намайг арваар авъя гэхэд хүртэл өгчихмөөр байдалтай байсан юм аа.

— Чи тэднийд бас орсон юм уу?

— Хэн энэ сийлбэрийг эрж олсон гэж чи бодов оо? гэж Игорь ханхалзана. Игорь үнийг нь бууруулж, Костя нь авч.

— Энэ чинь та нарт луйвар хийж байгаа гэж бодогдохгүй байна уу?

— Яалаа гэж. Энэ сийлбэр эмгэнд ямар хэрэгтэй байв аа? Ямар ч хэрэггүй, хэвтэж байлаа! Үүнийг хэн, хэзээ, хаанаас ямар үнээр авсныг бүү мэд. Үүнд эмгэн өөрөө хүч хөдөлмөр зарсан гэж үү? Жинхэнэ эхийг олтлоо ёстой цуглуулагч хүн хэдэн сар жилээр эрж сурвалжилж, өчнөөн төчнөөн цаг алдаж, гарлага гаргадаг. Тэгж зовчхоод их үнээр аваасай гэх гээ юу? Тэгсэнд орвол ховор зүйл худалддаг газар ороод л сийлбэрийн шилдэг цуглуулгыг худалдаад авчихсан нь амар. Гэвч энэ чинь цуглуулга биш болно оо. Жинхэнэ цуглуулагчид ингэдэггүй юм. Ойлгов уу, Крош минь? Ойлгосон бол идэх юманд ам хүрээч, Архи уух мөртөө даруулахгүй юм:

Игорь сэтгэлээ дэмий зовоох юм, коньякт би согтсонгүй.

Ходоодоо сайн тосолсон, би бас дахиад энэ хэрийг тогтоочихсон ч дөнгөнө! Сайхан л шөл байна! Сайхан л шорлог байна! Хэдийгээр дутагдалтай ч гэсэн Костя сайн л залуу байна.

— Дахиад зуу зуу татчих уу? гэж би санал гаргав. Игорь Костя руу нүд ирмэж

— Крош наргиж гарах нь ээ гэв.

- Би мөнгөтэй сэн бол та нарт зуу зуун грамм авч өгөх сөн.
- Крош ч гар султай хүн дээ гэж Игорь ам хуурай байсангүй.
- Юм идээч гэж Костя хэлэв.
- Би цадсан.

Миний түлхчихсэн таваг яагаад том хундага дайрч өнхрүүлснийг бүү мэд. Тэр том хундага нэлээд зайтай байсан юм... Хундага хаашаа ч юм одож, ширээний бүтээлэг хаашаа ч юм алга болж, Игорь шорлогтойгоо хундаганы араас, Костя нь бүтээлгийн хойноос дайвалзан алга болов... Тэдний оронд манай тасалгаа дараа нь эмгэн, тэгээд өөр нэгэн хүн гарч ирснээ хов хоосон болоод дахин шорлогийн гуанз бүтээлэг, Игорь, боржом барьсан Костя харагдав.

— Уу!

Боржомыг увал дотор жаал онгойсон боловч хэл эвлэрч өгөхгүй байлаа. Ямар нэг гашуун юм хоолой дээр гарч ирэхэд толгой эргэнэ. Дараа нь доошилж гайгүй болно. Шөл шорлог хоёроос л болж байгаа юм. Игорь үнэн хэлжээ. Энд юу ч хийж чаддаггүй юм байна. Хавиргатай шөлийг вааран саванд хийж, шорлогийг кар маягаар шарах хэрэгтэй. Коньякаас болоогүй л дээ? Ходоодоо цөцгийн тосоор гайгүй сайн тосолсон юм чинь.

Тос гэж бодохоос дахиад огиулах шахав.

— Дотор чинь онгойв уу? гэж Игорь асуулаа.

Костя намайг харахад би өөдөөс нь инээмсэглэсэн шиг санагдана.

Тэгээд тэр босож.

— Явъя гэв.

Бие минь зүв зүгээр харин нэг л газар суугаад баймаар байсан учир би эсэргүүцэх гэж оролдов. Гэвч тэд намайг жорлонд аваачсанд би бөөлжих шиг боллоо.

Тэд толгойг минь хүйтэн усаар шавшиж, тэр ч байтугай, золигууд чинь шилэн хүзүү рүү ус хийчихсэн чинь би жихүүцэж дулаан хөнжилд орчихмоор байсан боловч жорлонд юуны нь дулаан хөнжил байх билээ.

Бид танхимд буцаж ирэв.

Нимбэгтэй аяга халуун цай ууж жаал бүлээцсэн авч дотор бүлбийгээд нэг л тавгүй байлаа. Үүнээс хойш л хавиргатай шөл, шорлог хоёрыг идэхээ больё оо!

— Крош оо гонсойх явдалгүй, би ч гэсэн анхандаа ингэж л байсан юм гэж Игорь ивээнгүй хэлэв.

- Коньякаас болсон юм алга аа.
- Ай даа! Боржомноос л болоо доо.

Костя зун л энд унтаж, өвөл бол тасалгаандаа унтана. Эвхмэл орны нь дээр боксын бээлий, олс, бэлтгэлийн хувцас өлгөөстэй, жижиг шүүгээн дээр «Спидола» гэдэг бага гарын хүлээн авагч, «Советский спорт» сонин байна.

Костя зун л энд унтаж, өвөл бол тасалгаандаа унтана л даа. Энэ өрөөний тэн хагасыг эзэлсэн номын сан бий. Костягийн аав нь зохион бүтээгч юм. Нөгөө талд нь төгөлдөр хуур тавиастай байдаг. Костягийн дүү охин нь хөгжмийн дээд сургуулийн дэргэдэх хөгжмийн дунд сургуульд сурдаг юм. Тэр охин арван хоёр настай боловч өөрөө ая зохион төгөлдөр хуураараа өдөрт найм найман цаг сургуулилна. Их нөр хүүхэд.

Шилэн тагт нь гоё доо. Агаарт хийд байгаа юм шиг, тэгээд Москва нэлэнхийдээ харагдана гээч. Бас тусгайдаа байдгийг хэлэх үү. Би тусгай байртай болохыг мөрөөддөг юм. Боксоор оролдох ч бас зүгээр.

— Хөөе Костя, би бокс тоглож сурмаар байна. Тэгэхдээ зүгээр биеэ хамгаалдаг л болбол болоо.

Костя дуугарсангүй...

— Намайг намхан нуруутай болохоор олонх нь нас бага гэж боддог юм. Угтаа бол би тийм сул биетэй биш, ганцхан арга барилыг нь мэдэхгүй юм. Би самбогийн мэх сурья гэж боддог байснаа бокс дээр юм гэж бодох боллоо. Самбо бол заавал хүнтэй барьцалдаж авах хэрэгтэй. Бокс бол ганц дэлсээд л гүйцэх нь тэр.

— Чамайг дасгалжуулагчид үзүүлье л дээ.

— Арван зургаатайгаас эхлэхэд оройтохгүй биз.

— Яг эхэлдэг нас.

Надад боксчин болох байр байгааг дасгалжуулагч шинжээд би ёстой боксчин болчих ч юм бил үү? Өөрийнхөө жинд хөвүүдийн аварга болчих ч юм бил үү? Тэгвэл мөн ч мундаг аа!

— Чи намайг дасгалжуулагчдаа мөд үзүүлж өгвөл мөн сайн байна даа.

— Маргааш ч болно.

Жаахан ширүүн дориун зантай боловч үерхэж болмоор зүгээр залуу юм.

Тагтанд Костягийн аав орж ирэв. Орны ирмэг сандайлж суугаад өвдгөө илснээ биднийг харан инээмсэглэв. Костя хана ширтэн аавыгаа «юутай вэ?» гэж асуухад хүйтнээр

— Юмгүй гэж хариулав.

— Маргааш шатахуун бага зардаг машин туршина. Үүнтэй үйлээ эдлэв шүү.

Костя дуугарсангүй.

— Сайн машин болно доо. Цагт зуун километр хурдалж, дөрөвхөн литр бензин иднэ гээч.

Костя бүдүүн зүрх гаргая дуугүй суусаар байгаа нь надад эвгүй байлаа. Би ярианд нь хөндлөнгөөс оролцож

— Зөвлөлт Холбоот Улсын иргэн бүр машинтай байх ёстой.

Өнгөрсөн зуунд унадаг дугуй чухал байсантай л адил манай зуунд машин хэрэгтэй юм. Өрнөдөд хотод нь машин элбэгшин багтаж ядаж байхад манай оронд газар мундахгүй их байна гэв. Костягийн аав сайшаангуй толгой дохиж, өвдгөө илсээр л байна. Өвдөг нь өвчтэй юм болов уу? Харахад бол эрүүл саруул өндөр, махлаг, цагаан цайлган байрын хүн ажээ.

— Чи юу гэж бодож байна? гэж тэр Костягаас асуув.

— Надад ялгаа алга.

Би түүний ингэж хүний мөсгүй хариулсанд мэл гайхчхав. Аавтай ам мурийх удаа надад ч гэсэн байдаг. Гэхдээ эцэг нь эхэлж эвлэрье гэж байхад бас л хүн шиг байх хэрэгтэй.

— Та хоёр таардаггүй юм уу гэж Костяд хоёулхнаа үлдсэн хойноо хэлэв. Костя хариу дуугарсангүй.

— Аав ээжтэй муудалцах хэрэггүй юм, тэртээ тэргүй эвлэрэх юм чинь.

Костя дуугарсангүй.

— Аав чинь авто заводод ажилладаг юм уу?

— Тийм ээ гэж тэр сая нэг дуугарахчаа аядав.

— Манай аав ч бас тэнд ажилладаг.

Эвхмэл орны дээр хорго байв. Костя түүнийг нээвэл дотор нь жижигхэн сийлбэр байлаа.

— Сийлбэр үү?

— Тийм ээ.

— Үзүүлээч.

Япон жаал явган сууж өвдөг дээрээ ном тавьжээ. Гэхдээ тэр хүү номоо шагайсангүй, харин алсыг ширтэн, хэтийн юмыг санааширчээ. Царайд нь ариун сэтгэл, баяр хөөр, амьдралын баясгалан тодрон байх агаад сийлбэрч чухам яаж ингэж урлаж чадав аа гэдэг нь ой тойнд багтамгүй. Энэ бол урлагийн сод бүтээл мөнийг би ойлголоо.

— Их уран сийлбэрч нэгдүгээр Мива гэдэг чинь энэ дээ «Ном барьсан хүү» гэдэг сийлбэр нь.

— Чи бас цуглуулдаг юм уу?

— Үгүй ээ. Ганц энэ л байж байдаг юм. Над ийм сийлбэр байна гэж Веэнд битгий хэлээрэй. Ер нь энд тэнд харсан ч гэж бүү дурс.

— За тэгье ээ.

— Сайхан мэдээрэй!

— Намайг хэн гэж бодов оо?

Хашаанд усан оргилуурын дэргэд хүмүүс шавжээ. Усан оргилуур бол манай хашааны уран барилгын чуулгын төв юм. Түүнийг зун болгон засварлана. Тэгэхдээ намар болоод, ус тавих хэрэгцээгүй болох хүртэл засварлахыг яана. Гэвч усан оргилуур тавих бүрийд манай хашаанд нижгэр юм болно. Шмаков Петр үүнээс яалаа гэж хоцрох вэ. Шмаков нэг юм болох үеэр гарч ирдэггүй, харин Шмаковыг гарч ирэхлээр юм болох шиг санагддаг юм.

Шмаковыг хараад сэтгэл тавгүй болов. Костя гэдэг шинэ найзтай болоод өчнөөн удаан сайдахдаа сайдаж муудахдаа муудаж явсан хуучин анд Шмаковоо мартжээ.

Шинэ найзтай болоход хуучин, тэгээд өчнөөн удаан сайн муугаа хуваалцаж явсан найз саад болдог нь юу вэ?

Гурвуул үерхэж болохгүй гэж үү? Шмаков сайн нөхөр, тэгээд бас боксоор хичээллэж чадна. Түүнд тийм шинж цөм бий.

Шмаков тэтгэвэрт гарсан Богаткинтай усан оргилуурын техникийн асуудлын тухай ярилцаж байна. Үүнээс Шмаковт ойлгох юм даанч байхгүй, гэхдээ тэтгэвэрт гарагсадтай ярьж аргагүй чаддаг, хэл амаа ололцдог юм. Гэтэл намайг тэд шилэн дундуур минь одоо тат юу, байзнаж байгаад тат юу гэсэн байртай харахыг яана.

Богаткин гуайг цааш харах хооронд амжиж би:

— Хөөш Шмаков оо, чи бокс оролдохгүй юу гэв.

— Яах юм.

— Биеэ хамгаалахгүй юу

— Хэнээс тэр вэ?

— Хэн халдсан хүнээс.

— Надад халдсан хүн алга.

— Өнөөдөр би Костя Игорь хоёртой шорлогийн гуанзанд орж, зуу зуун грамм татаад.

— Дамчид даа!

— За ямар ч л гэсэн Костя дамчин биш дэг. Дүү нь хөгжмийн сургуульд явдаг юм.

— Хөгжмийн сургуульд бүү хэл, хөгжмийн хүрээлэнд ч панз үсэргэж болно оо гэж Шмаков Петр хэлдэг байна.

Би Шмаковын үгийг тоосонгүй. Костя Игорь хоёр урлагийн тулд Веэний даалгаврыг биелүүлж явааг тэр ямар мэдэх биш. Намайг хүнтэй нөхөрлөж эхлэхээр л Шмаков түүнийг дандаа өөлнө. Гэвч боксоор хичээллэхээс түүний эрс татгалзсанд би мэгдэв. Шмаков нэг учиртай татгалзсан хэрэг, тэр хар ухаантай хүн шүү. Хүн төрөлхтний ялихгүй хэсэг л боксоор хичээллэдгийг бодоод үз л дээ.

Намайг харихад аав ээж хоёр Ижил мөрнөөр аялах тухай ярилцаж байна. Тэд хоёр мөд усан онгоцоор Ока, Ижил, Кама мөрнөөр аялах юм. Би явахгүй ээ. Би хоёр дахиж аялсан ёстой ганц уйтгартай юм чинь тэр дээ. Нэг удаа ч бас яая гэх вэ, гурав дахиа ч больж үхье! Аав ээж хоёр дуртай юм, яах вэ явж л байг.

Би нэвтэрхий толь барьж авав. Манайд хоёр байдаг юм. Нэг нь Брокгауз, Ефрон хоёрын зохиосон, нөгөө нь ЗИНТ (Зөвлөлтийн их нэвтэрхий толь) юм.

Брокгауз, Ефрон хоёрын нэвтэрхий толь өнгөрсөн зууны шувтаргаар гарсан юм. Гэхдээ түүнд сонирхолтой баримт олон бий. Хүн наян жилийн өмнө ертөнцийг хэрхэн үзэж байсан нь сонин. Энэ нь заримдаа зэгсэн инээдтэй. Хүн төрөлхтөн хэчнээн урагш ахисан нь харагдана.

Бокс гэж өрсөлдөгчийнхөө толгойноос гэдсийг хүртэл цохих урлаг бүхий нударган зодооны нэг төрөл. Тэмцэлдээн нэгийгээ цусалж, бэртээж дуусах нь олонтоо... Нэг өрсөлдөгч нь нөгөөгөө цааш зодолдож чадахгүй болтол жанчсан хойно тэмцэлдээн сая зогсдог.

Хэрэв «жанчих» гэдэг гэнэн үгийг авахгүй юм бол уг тодорхойлолтод хүн дурламаар юм алга. Цус урсах, бэртэх, толгойноос гэдэс хүртэл цохих... Дурлууштай эд ч биш дэг ээ! Гэдэс рүү цохивол бас ч гэж яах вэ, хүнийг бөндгөр рүү нь балбаад байвал дүйрэн болж гүйцнэ шүү дээ. ЗИНТ бол орчин үеийн толь бичиг. Үүнд нэг хүнийг тахин шүтэхтэй холбоотой газар ч мэр сэр бий л дээ. Гэхдээ боксын тухай өгүүлэлд нэг хүнийг тахин шүтэж байсны нөлөө байх нь юу л бол. «Бокс спортын төрөл, нударган зодоон... Зодоон нь өрсөлдөгчийнхөө биеийн нэн эмзэг газрыг цохиж муужруулах зорилготой... муужрах нь хагас ухаантай буюу ухаангүй байх бөгөөд ихэвчлэн эрүү буюу гэдэс рүү цохиход ингэнэ».

Энэ тодорхойлолт арай шинжлэх ухааны үндэстэй юм. Гэхдээ биеийн нэн эмзэг газрыг... эрүү гэдэс рүү цохино... Ухаан алдана... гэнэ.

Дэлхийн буюу Европын аварга болох сайхан л юм биз. Гэхдээ чамайг ам хамраас чинь цус садартал цохиж, гэдэс рүү чинь балбаж толгойг чинь түншиж, ухаан балартуулах юм уу, бүр ухаангүй болгодог юм бол даамын аварга болбол дээр ээ. Манай нэг залуу ширээний одон бөмбөгний аварга болсон. Ойлгож байж шүү.

Гэвч зүв зүгээр байж байгаад больё гэхэд эвгүй. Өчигдөр гуйж гувшиж байснаа өнөөдөр үгүй гэдэг. Бокс нэвтэрхий толинд бичсэнчлэн тийм аймаар ч биш байж магад. Би телевизороор боксын тэмцээн олон харсан боловч цус урсаж бэртэж байхыг үзээгүй. Боксчид бие биеэ тойрон цовхчиж, бээлийгээрээ хааяа нэг, хараажаар төдий л өвдмөөргүй цохиж байх юм билээ. Бас орон тоогүй юм уу, надад авьяас байхгүй байгаад дасгалжуулагч нь намайг авахаа больж ч мэднэ. Богино гартай байна гэж бодъё. Тэгвэл өрсөлдөгчдөө хүрч чадахгүй, харин цаадах чинь намайг алхичихна шүү дээ.

Биеийн тамирын клуб байдаг Цэцэрлэгийн гудамж руу явах замдаа Костяд би:

— Гэнэт авахгүй гэвэл яана?

— Бүгдийг авдаг юм.

— Хэнийг ч гэсэн авна гэж үү?

— Хөгжимчин болох хүнийг л авдаггүй.

— Яагаад?

— Уруул, хуруугаа гэмтээж болзошгүй. Чи саксафон үлээдэггүй шиг билээ?

— Би саксафон үлээдэггүй ээ. Гэхдээ хөнгөн хөгжимд бөмбөрчнөөр оръё гэж бодсон юм.

— Эцэг эхийн зөвшөөрөл бас хэрэгтэй дээ.

Би дорхноо санаа амрав. Хэрэв эцэг эхийг оролцуулдаг юм бол бас ч учир байна.

Хэсэг зуур дуугүй явснаа намайг

— Эмгэнээс худалдаж авсан сийлбэр санаанаас гарахгүй юм.

Тусгүй л юм болсон доо гэхэд

— Юу нь тусгүй гэж? хэмээн Костя бүрсийн асуув.

— Үнэн чанартаа бид эмгэнийг малласан шүү дээ. Цуглуулга хийнэ, аз үзнэ энэ тэр л гэнэ... Гэхдээ тэр эмгэн даанч өрөвдмөөр юм. Лав тэтгэврээр л амьдардаг байх. Тэр мөнгө түүнд маш их хэрэг болох байсан даа.

— Чи ингэхэд тэнэг юм уу, эсвэл цэцэн юм уу гэж Костя асуув.

- Юу гэсэн үг вэ?
- Гуанзанд чамайг оруулсан биз дээ? Чамайг сайхан нүдтэй гэж үнэгүй хоол идүүлсэн юм уу? Дуугүй л байж үз.
- Би тэр мөнгийг чинь буцааж өгнө өө.
- Битгий удаагаарай гэж Костя зэвүүцэнгүй хэлэв.
- Тануусын тэр сийлбэр надад огт хэрэггүй ээ.
- Чамайг гуйсан хүн алга.

Троллейбус зогсмогц би буув. Костя миний хойноос харсан ч үгүй. За тэгж л байг! Шмаков зөв хэлж, би панзчидын бүлэгт орчхож. Урлагийн ертөнц гэнэ шүү, чөтгөр алгадмаруудыг хуухай. Цуглуулагчид, заяагүй муусайн гангачуул, хувалзуудыг! Би далим гарвал бодсоноо та нарт хэлж орхиё оо, гайгүй Зарчимч байх хэрэгтэй. Зарчимч байвал дийлж, шантрамхай байвал дийлддэг. Заяа нь орхисон муусайн дамчид, панзчидыг хуухай!

Харимааргүй байсан тул би биеийн тамирын барааны дэлгүүрт оров. Хаалган дээр нь «Худалдан авагч иргэд ээ, та нарт худалдааны сургуулийн сурагчид үйлчилж байна» гэсэн бичиг хаджээ. Эмэгтэй сурагчид гэж бичсэн бол зөв байх байсан юм. Дэлгүүрийн худалдагчид цөмөөрөө шахам бүсгүйчүүд, тэгэхдээ бузгай царайлаг бүсгүйчүүд гээч.

Хамгийн аятайхан бүсгүй бол биеийн тамирын гутлын тасгийн худалдагч Зоя л даа. Шмаков энд лангууны дэргэд өнжиж хүмүүс еэвэн шаахай тохируулж үзэхэд садаа болно. Зояг өндөр болохоор Шмаков өөрийгөө надаас илүү энд байх эрхтэй гэж итгэж, надад жижиг туранхай бүсгүй таалагдах ёстой гэж үзнэ. Бид охидтой танилцахад Шмаков арай өндөр нуруутайг нь шохоорхоно. Гэтэл надад бас нуруулаг бүсгүй аятайхан санагддаг юм. Нора шиг горзгор юмнууд биш ээ, гэхдээ л намхан биш. Хар үстэй хүнд цайвар үстэй, тарган хүнд туранхай, баясгалантай хүнд буурьтай, өндөр хүнд намхан, аманцар хүнд дуугүй хүн аятайхан санагддаг буюу төрх галбир өөрөөсөө тэс ондоо хүнд сэтгэл татагддаг нь тодорхой. Үүнийг Шмаков Петрт тайлбарлахаараа л нэг болсон. Ер нь нөгөөгөө мөрөөрөө түрэн зайлуулна гэдэг тэнэг явдал.

Үнэнээ хэлэх юм бол Майка надад бусдаас илүү сайхан санагддаг юм. Гэхдээ Майка хөдөө зусахаар явчихсан, тэгээд ч явахын нь өмнө нэг номын талаар жаал маргасан юм. Ямар ч ном билээ дээ мартчихаж, тун тусгүй л юм болсон юм даг, тэгээд ч мартчихсан хэрэг. Хэн ч зохиосон байлаа даа, санахгүй байна. Нэг л нэрд гараагүй зохиолч юм даг. Нэрд гараагүй байж, барьж авангуутаа л хийрхүү хүний тухай бичиж. Манай зуунд ийм хүн зөндөө байгаа болохоор нэгийнх нь л тухай бичиж л дээ.

Номын баатрыг шилжилтийн насандаа байна гэж Майка зүтгэв. Тэгэхлээр нь би шилжилтийн нас гэж ер байдаггүй. Жишээлбэл, манай нэг залуу Мишка Таранов, нэрт Тарановын хүү нэг захиа бичжээ. Тэгээд захиагаа «Уншихыг хүссэн хүнд» гэж гарчиглаж. Мишка аавыгаа! агуу их хүн гээд өөрөө бол өчүүхэн амьтан, иймд цааш амьд явах хэрэг байна уу энэ тэр гээд дөрвөн тал дүүрэн эсэн бусын юм сараачсан гээч. Цөмөөрөө л түүнийг! шилжилтийн насны гай гэцгээсэн. Тэгэхэд нь би Мишкад «Өөрийгөө эцэгтэйгээ зүйрлүүлнэ гэдэг тэнэг хэрэг. Аав чинь арван зургаатай байхдаа чамаас ч долоон доор олхиогүй байсан юм билүү» гэсэн юм. Энэ үг түүнд овоо хэрэг болж, мань хүн өөрчлөгдөөд танигдахын аргагүй болсон доо. Урьд нь хөл бөмбөг ч тоглодоггүй байсан бол одоо сургууль дээр твист хэнээс ч илүү хийдэг болсон гээч.

Номын баатар хөл үймээнээс холдож, ойд урц барьж аваад зэлүүд газар даяанчлах гэсэн байна гэж Майка булаацалдав. Хариуд нь би манай ангийн хамгийн өндөр бяргай залуу, бидний «Аав» гэж хочилдог Полекудыг нэр заав. Тэр, муу авчихлаараа л зөгийчин болно. Зөгий тэжээх газар очиж зөгий үржүүлнэ гэдэг юм. Зөгийчин болохыг эсэргүүцэх юм надад үгүй, ямар ч ажил сайхан. Гэвч аливаа ажилд дур сонирхолтой байх хэрэгтэй. Зөгийчин хүн элдвийн хорхой шавжид дуртай байх ёстой. Гэтэл «Аав» дан техникийн авьяастай хүүхэд. Ойд урц босгох гэсэн хүсэл хэнд ч төрж болох бөгөөд энэ нь юу ч нотолсон юм алга гэдгийн баталгаа болгож дээрх жишээг би дурдлаа.

Бас тэгээд номд эсэн бусын этгээд үг олон байвал охидод сайхан санагддаг. Тэд үүнийг «үгийн олз» гэдэг юм. Гэтэл би хараал зүхэлд дургүй. Ялангуяа эмэгтэйчүүд, хүүхдийн дэргэд харааж байхыг би үзэж чаддаггүй хүн. Эмэгтэйчүүд, хүүхдийн дэргэд хараал хэлж байгаа этгээдийн улаан нүүр рүү өгчилгөмөөр санагдаад байдаг. Утга зохиол амьдралыг тусгадаг учир ямар нэг хараалыг уран зохиолд хэрэглэсэн л байдаг. Гэхдээ беллетристка буюу уран зохиол гэдэг бол белль леттр — сайхан бичиг гэсэн утгатайг мартаж болохгүй. Манай хашаанд заримдаа чихээ бөглөмөөр үг дуулдана шүү... Гэвч би тэр белль леттрийг бичиж байгаа номдоо оруулах албатай юм уу?!

Номын баатар бол капитализмын бүтээдхүүн мөн гэж Майка хэлэв. Магадгүй юм, бүү мэд. Хүн капитализмаар түрээ барьж биеэ зөвтгөх нь надад ямагт сэжигтэй санагддаг юм. Хөдөө аж ахуйн үзэсгэлэн дээр манай нэг залуу алим зөрчхөж билээ. Тэгээд тэр этгээд

ангийн хурал дээр босоод «Найзууд минь, намайг өршөөж үз, үүнд миний буруу байхгүй. Капитализмын хар толбоны л гай» гэдэг байна. Харав уу? Капитализм гэгчийг огт үзээгүй байж арван зургаан насанд нь түүнд капитализмын хар толбо яаж суув аа? гэж асуумаар.

Стендалийн Жюльен Сорелийг тийм хийрхүү мянгатай ч зүйрлэшгүй гэж би Майкад бас хэллээ. Жюльен Сорель бол хамгийн ердийн уруу татагч гэж Майка зөрөв. Эмэгтэй хүн л өөрийнхөө толгойг эргүүлээсэй гэж хүсэхгүй бол хэн ч түүний толгойг эргүүлэхгүй гэж би хариуллаа. Намайг энэ талаар дульхан байна гэж Майка хэллээ. Тэгэхэд нь би түүнээс л илүү мэднэ дээ гэчихлээ. Тэгээд бас түүнийг дандаа омогдоод байлгүй Жюльен Сорелийн сүүлийн минутыг санаач гэж нэмж хэллээ.

Үхэх цаг чинь боллоо гэж хэлсэн тэр өдөр ашгүй хурц наран байгаль дэлхийг гийгүүлж Жюльен ч зориг чанга байлаа. «За яах вэ, зүгээр, би сэтгэлээр огтхон унахгүй» тэр боджээ... Толгой нь мөрнөөсөө салах цаг юу юугүй ойртоод байгаа энэхэн үед толгойд нь хэзээ хэзээнийхээс илүү уран яруу бодол төрж байжээ...»

Нялуурч уярах зуун аль эрт өнгөрсөн гэж Майка хэллээ. «Нялуурал» гэдэг нэр томьёог хатуу цэвдэг сэтгэлтэн л хэрэглэдэг юм гэж би хариуллаа. Майкатай үерхэх ямар албатай биш гэж энэхэн зуур надад бодогдоод явчихсан. Тэгээд ч Майкатай муудалцахаас өмнө надад биеийн тамирын гутлын тасгийн худалдагч Зоя аятайхан санагдах болсон юм чинь. Энэ хоёр өөр өөр зүйлээрээ миний сэтгэлд таардаг юм. Майка ухаанаараа, Зоя өөр зүйлээрээ сэтгэл татдаг. Майкатай хэрэлдсэнээс хойш Зоя илүү санагдах болов.

Ганц Шмаков Петр л саад болж байлаа. Намайг мөрөөрөө түлхдэгтээ биш, би бас хэнийг ч түлхчхэж дөнгөнө. Шмаковын сэтгэлд Зояагаас өөр хүн таардаггүйд учир байгаа юм. Тэгэхлээр түүний сэтгэл минийхээс ултай байж таарна. Би түүний энэ гүнзгий сэтгэлд саад болохыг хүсэхгүй байв.

Одоо Шмаков лангууны дэргэд бүгдийг мөрөөрөө түрэн Зоятай ярилцан зогсож байлаа. Зоя худалдан авагчдыг үл анзаарна. Түүний оронд байгаад үз, хүний цоорхой оймс харж байхад тийм ч аятай бишээ. Өөрсдөд нь эмэгтэй хүн үйлчилж байгааг бодолцдоггүй амьтад аль овоо бий. Ямар ч ажил сайхан нь сайхан. Гэхдээ би дэлгүүрийн дарга байсан бол эрэгтэй хүнд зориулсан барааг худалдахад эрэгтэй

худалдагч, эмэгтэй хүнд зориулсныг худалдахад эмэгтэй хүн тавих байсан.

— Чи яасан сүрхий байх юм? гэж Шмаков надаас доогтой асуув. Мань эр надтай бүсгүйчүүдийн дэргэд голдуу ингэж ярьдаг юм. Өөрийгөө эрийн цээнд хүрсэн, намайг хүүхэд гэдгийг харуулах гэж байгаа санаа нь тэр. Мангуу амьтан! Ийм арчаагүй юмыг би тэвчиж чаддаггүй юм.

— Шмаков, бүү маанагт гэж би хариулав.

Гэвч үнэнийг хэлэхэд би Шмаковтай уулзсандаа баярлав. Шмаков толгойгоо ажиллуулахаасаа мөрөө хөдөлгөх нь их боловч намайг дамын наймаа хийхэд уруу татаж байсан удаагүй. Харин ч үнэнч найзын хувьд Игорь Костя хоёрыг панзчид гэж сэрэмжлэн сануулж байсан. Тэгэхдээ би түүнд өөрийнх нь зөв байсныг хэлсэнгүй. Хэлчихвэл «Би чамд эс хэл лүү?!» гэнэ гэдгийг юу эс андах вэ.

Сэмбэгэр үстэй, өндөр, махлаг Зоя бүсгүй лангууны ард зогсоно. Түүнийг хашаа дотуур өнгөрөхөд сантехникийн засварчид хойноос нь нүд бэлчээдэг юм. Тэр тэдэнд тэгж их таалагддаг хүн дээ. Яах аргагүй хөөрхөн бүсгүй ээ. Шмаков Петр түүнийг дүйнгэ юм шиг нүд салгалгүй ширтэж зогсоно. Ингэх хэрэг юу байна?

Мөсөн гулгуур дээр бол ондоо хэрэг. Охид нэг л өөр, Битүүлэг, сэтгэл догдлуулам болоод хацар нь улаа бутран нүд нь тормолзоно. Тэдэнтэй хөтлөлцөөд гулгаж байх юм уу, шаахайг нь үдэж өгч байхад эр хүн шиг бодогдох бөгөөд тэгээд бас танхай амьтдаас хамгаалах хэрэгтэй. Гэтэл Шмаков лангууны дэргэд ч мангуу юм шиг зогсож, байраасаа хөдөлнө гэж байхгүй, Би ганцаар дэлгүүр дотуур явав.

Би дэлгүүр дотуур хэрэн явж, моторт шинэ завь сонирхон Веэний тухай бодов. Өөртэйгөө яагаад ажиллахыг хүсэхгүй байгааг минь тэр асуувал эмгэд хөгшдийг маллах мэхлэхэд оролцож чадахгүй гэж хариулна.

Гэтэл Везнийд очиход харин надаас:

— Өчигдрийнхөөс хойш бие ямар байна? гэж шал өөр юм асуув.

Юун тухай асууж байгааг нь ч би тэр даруйдаа ухаарсангүй.

Дараа нь ойлголоо.

— Одоо зүгээр.

— Нөхдөөсөө хоцрохгүй санаатай юм биз дээ? Чамайг уучилж болох юм. Костяг бол болохгүй, биеийн тамирчин боксчин хүн шүү дээ. Ууж болохгүй л бол болохгүй. Тийм биз? Везн үргэлжлүүлэн хэлэв.

— Тийм ээ.

Би өөр юу гэх вэ? Боксчин хүн үнэхээр архи ууж яаж болох вэ.

— Игорь Костяг уруу татаж байгаа юм. Жигтэйхэн залуу! Уг нь чадъя гэвэл чадах, юмны учир таньсан хүн...

Везн ноосон хантааз, цагаан цамц өмсжээ. Насыг нь бодоход бас ч гоолиг жавхаалаг харагдана.

— Игорь яарч тэвдэж байгаад гоомойдох нь олон.

Энэ сийлбэрийг үз гээд Везн шүүгээ тийш гар сунгаж тавиур дээрээс хөгжимчдийн дүрсийг авсан нь эмгэнээс Костя бид хоёрын авсан тэр сийлбэр байв. Игорь жинхэнэ эхийг нь оллоо гээд байсан. Гэтэл дуураймал юм байна. Костя ч Костя бол доо. Би түүнд эхлээд үнэлүүлж бай гэсэн юм байхгүй юу, гэтэл миний үгэнд орсонгүй. Ер нь хэн ч эндүүрч болно л доо. Тийм биз? Би юу гэх билээ! Нээрээ хэн ч андуурч болох юм.

— Үүнд тав, аягүй бол арван рубль ч алдах нь. Чамд паспорт чинь байна уу?

— Байна.

— Чамаас гуйх юм байна. Энэ сийлбэрийг хуучин юм худалдах газар аваад оч. Арван рублиэр авбал дээдийн заяа. Таваар ч авна гэж магад, ямар ч болсон өгчих.

— За.

— Дараа нь Костятай нэг газар очоорой.

— За тэгье.

— Костя чамд ямар санагдав?

— Бид сайн танилцаагүй л байна

— Костя сайн залуу, гэхдээ хэцүү зантай хүн. Тэр нь бас учиртай. Яваандаа чи мэднэ ээ... Та нарыг үерхээсэй гэж би одоохондоо хүсэх байна.

— Түүнийг дургүйцэхгүй бол...

— Чи түүнийг биедээ татаж чадна гэж бодож байна гээд Везн намайг цоо ширтэнэ. Нийцгүй юм шиг санагдаж болох боловч угтаа бол хүний мөсөөр сайн хүн.

Би юу гэх вэ дээ? Костя ширүүн дориун амьтан шиг санагдсан боловч би ташаарсан байж болох шүү дээ. Эмгэнийг араар нь тавьчихлаа гэж бодсон чинь эмгэн түүнийг араар нь тавьчихсан байж. Тэгээд бас жинхэнэ эх нь гэж мэтгээд байсныг яана гээ. Ингэж сэрдэмтгий байх муухай. Шмаков л байхгүй юу, тэр л намайг хар авхуулсан юм.

— Костягийн эцэг нь төрсөн эцэг биш хойд эцэг нь байгаа юм гэж Везн их л нухацтай хэлэв.

Хойд эцэгтэй нь ямар ганц Костя биш, үүнд онц гойд юм алга. Гэвч Костя аавтайгаа, өөрөөр хэлбэл, хойд эцэгтэйгээ ярихдаа ч тэгж хөндий хүйтэн байсны учрыг одоо л олов.

— Костя үүнийг мэдэхгүй, мэдэх ч ёсгүй гэж Везн хэлэв.

Энэ нь хэргийг нэг л учир тайлагдахааргүй болгож байв. Костягаас үнэнийг юунд нууна вэ? Хүнийг хүмүүжүүлсэн хүн л эцэг нь байх ёстой.

— Үүнийг нууж хаахын хэрэг юу байна? Хүмүүжүүлсэн хүн л эцэг нь байх ёстой.

— Костягийн эцэг онцгой нөхцөл байдалд амь үрэгдсэн юм. Костяг хойд эцгээр нь овоглох хэрэгтэй болсон юм.

— Костя үнэнийг мэдвэл...

Костя хэзээ ч мэдэхгүй. Энэ тухай ганц би л мэддэг юм. Одоо чи мэддэг боллоо.

— Надад санаа зовохгүй байж болно.

— Чи Костятай үерхвэл сайн үйл хийх чинь тэр. «Сайн үйлийг яаран бүтээ» гэж Гёте хэлсэн байдаг. Чи Гётег мэднэ биз?

— Бид «Фаустыг» нь үзсэн.

— Костягийн амьдралд өөр ээдрээтэй зүйл ч бий. Чи яваандаа мэднэ ээ, гайгүй. Ирээдүйд юу ч тааралдсан түүнийг давж чаддаг байгаасай гэж би хүсэх юм.

Харц нь гэнэт бодлогошронгуй, гунигтай болсонд би Костя, тэр хоёрыг өрөвдөж, тэдний талаар муу юм бодож явсандаа нүүр халав,

Хуучны зүйл худалдах газарт юм хүлээн авдаг хүн нь хөгжимчдийн дүрсийг гартаа эргүүлж тойруулснаа.

— Арван рублиэр тавья гэв.

— Тэг тэг гэж би Везний дөнгөж таван рубль алдаж байгаад баярлан зөвшөөрөв.

Эргэж харвал ард Костя байж байлаа.

— Везн чамайг энд байгаа гэсэн, Машинаар аялагчдын буудал руу явья.

Өчигдрийн тухай ганц үг дурссангүй. Ямар ч гэсэн журамтай залуу юм. Одоо би Костяг өөрөөр үзэж байлаа. Хэн болохоо мэдэхгүй байгаа хүний байдал мөн ч хэцүү еэ. Ийм юмыг жишээлэхэд надаас нууна гэх бодол надад төрөхгүй байв. Мэдэхгүй байснаас мэдэж байсан нь дээр. Бүүр адгийн муухай юм ч байсан тэр. Энэ нь яг зодоонтой адил юм. Хэрэв нүдээ анивал чамайг нүдчихнэ. Гэтэл Костягаас нууж байлаа. Би түүний тухай өөрөөс нь илүү мэдэх болов. Үүгээрээ би түүнээс нэлээд давуутай. Түүний дутагдлыг хүлцэн өнгөрүүлэх боломжтой болов. Гэхдээ бялдуучилж нялганах юм хаа байх вэ. Төлөв байдлаараа түүний дээрэнгүйгээс давуутайгаа харуулах хэрэгтэй.

Автобусанд хоёр загасчин өвгөн шархлааны тухай ярьж явна. Нэг нь ходоод шархалбал дээр гэнэ. Нөгөө нь арван хоёр нугалаа гэдэс шархалбал дээр гэнэ. Хөөрхий зайлуул! Ингэж ярих дээрээ тулах ч гэж дээ! Гэхдээ инээд хүрмээр юм аа...

Машинаар аялагчдын буудал Минскийн засмал, тойрог зам хоёрын уулзвар дээр байдаг. Дэргэд нь үйлчилгээний газар, шатахуун түгээгүүр мухлаг бий.

Засмал болон давхар замаар дээгүүр доогуургүй машин зөрөлдөн давхина. Нар тусаж, энэ бүхэн зурмал юм шиг харагдаж байлаа. Энэ үед хөл хөдөлгөөн надад аятайхан байлаа. Үүргэвч, халуун сав, дэгээ, хуйд хийсэн ангийн буу, эвхмэл ор, эвхсэн брезент майхан чемодан нүдний өмнө эрээлжлэн өнгөрнө... Москваг тойруулан хоёр урсгалтай ийм гоё зам тавьсан нь надад сайхан санагдаж байна. Зөвлөлт Холбоот Улсын иргэн бүр машинтай байгаасай гэж би ер нь хүсдэг юм. Урьд унадаг дугуй чухал байсантай л адил манай зуунд машин хэрэгтэй...

Ингэж хэлэхэд минь Костя намайг мангуу юм уу гэсэн байртай харав.

— Чи өчигдөр ингэж айлдаад байгаагүй юу...

Костя буудал орж би түүнийг гадаа хүлээхээр хоцров. Том цонхоор Костя мухлагаас лонх ус авч гадаадын байрын хүний сууж байгаа ширээнд суух нь харагдав.

Цонхоор гөлрөөд байх нь эвгүй байсан тул үйлчилгээний газраар сэлгүүцлээ. Машин угаах бүхээгийг би хачирхав. Дотуур нь машин аяархан явж өнгөрөхөд эргэлдэх шүршүүр тал талаас нь угааж, том сахлаг сойзоор зүлгэнэ. Хорьдугаар зуун гэдэг энэ дээ! Гэхдээ бүхээгээс машин гарахад угаагч эмэгтэй тонгойхоороо тонгойж, түүнийг дороос нь угаагаад хормогчоороо арчин, алчуур өгөхгүй байна гэж дарга нараа зэмлэнэ. Үүнд ч зэгсэн гайхав. Гэвч энэ бол шинэ тутам үйлдвэр юм, бэрхшээл тулгарч байгаа боловч яваандаа бүх юм зүгшрэх биз гэж бодов.

Ямар шархлаа, дээр болох тухай маргалдаж явсан загасчин өвгөд буудалд хүрч ирэв. Нэг нь мухлагт орж нөгөө нь агнуурынхаа хэрэгслийг шатан дээр тавиад хүлээж байлаа.

Энэ үеэр мухлагаас ханан хээтэй цамцтай халамцуу хоёр залуу гарч ирлээ. Нэг нь юу ч болоогүй байтал хувинг өшиглөчхөв. Хамаг юм нь бут үсрэн өнхөрлөө.

— Мөн тавив аа!

Муусайн юмаа өвгөн төдий л сайн байрлуулсангүй байж. Гэхдээ энэ бол юмыг нь бутраах далим биш ээ. Тэр залуучууд хөөрхий өвгөнийг агнуурын хэрэгслээ цуглуулан газраар мөлхөн байгааг харан харан хөхрөлдөж:

— Өвгөн ах, хүний хөл хугалчихааргүй аятай газар юмаа тавьж бай гэлдэнэ.

Би тэгэхэд нь:

— Та нар зориуд өшиглөлөө шүү дээ гэвэл

— Юу гэнэ ээ? гэж нэг нь бархиран нударга зангидаж над руу дайрав. Тэгснээ газарт тонгорцоглон унав. Костя буудлаас гарч ирээд тэр балмад этгээдийг нам цохисон нь энэ ажээ. Хоёр дахийг нь Костя руу ухас хийнгүүт би ташсанд нөгөөдхийнхөө дэргэд цардмал зам дээр тэрийн унав.

Зодоон гарахад хүмүүс гүйлдэн хүрч ирлээ... Цагдаагийн шүгэл тас хийв... Би танхайчуудыг болгож тавих гэсэн чинь Костя гараас

минь шүүрч:

— Гүйгээрэй! гэв.

Бид түгээгүүрийн дэргэдүүр харайлган, засварын газрыг тойроод хэсэг модон дундуур өнгөрч, зам дээр гүйн гарч хөдөлж байгаа автобусанд үсрэн орлоо.

Бид шившигтэйеэ зугтав. Гэтэл бид ямар ч гэмгүй. Тэр танхайчууд л буруутай. Тэднийг залхаах хэрэгтэй. Ийм үед Шмаков бид хоёр бол зугтана гэж хол, гэтэл Костя зугтав. Гэхдээ айсандаа ч биш юм. Хэрэв хулчгар амьтан сан бол тэр цадиггүй этгээдийг цохиж унагахгүй байсан. Тэгэхлээр элдэв явдалд орооцолдохгүй байх шалтгаан байсан хэрэг. Юу ч болоогүй юм шиг царай нь хэнэггүй. Гэвч намайг ширтээд байгааг нь мэдэв. Миний овсгоотой дэгээдсэнийг гайхаж байгаа бололтой.

Бид нэг зусланд галт тэрэг зогсдог тавцангийн тушаа автобуснаас буулаа. Зам засвартай учир дараагийн галт тэрэг гурван цаг өнгөрөөгөөд явна гэсэн зарлал кассын дэргэд өлгөөтэй байв. Бид хоёр пиво худалдаж аваад тавцангаас бууж ногоон дээр хэвтэцгээлээ. Ногоон дээр хэвтэхэд сэрүүхэн таатайхан даа. Төмөр зам, тавцан, наранд гялалзах зам төмөр, эцэс төгсгөлгүй ярайх хар тостой дэр мод сайхан санагддаг боловч миний амьдралын хамгийн аягүй дуртгал төмөр замтай холбоотой.

Гурван жилийн өмнө юм сан. Би тавцан дээр зогсож байлаа. Цахилгаан галт тэрэг өртөөн дээрээс хөдлөв. Сүүлчийн вагон надтай зэрэгцэж иртэл цонхоор малигар царай цухуйж чанх өөдөөс минь нулимчихлаа. Тэр олхиогүй, нүнжиггүй, маасгар нүүр өнөө болтол нүдэнд харагдаад байдаг юм. Тэр адгийн амьтан цахилгаан тэргээр зүрхээ зүсүүлэн зугтаж одлоо. Би түүнийг хэзээ ч олохгүй, түүнээс хариугаа авч чадахгүй, бузар авирласных нь таарсан шанг хүртээхгүй гэж бодохоос тэсэж байхын аргагүй болоод хор хөдөлж арга барагдан золтой л уйлчихсангүй. Би ер уйлдаггүй, уйлбал өөдгүйгээ л харуулж байгаа хэрэг. Хөхүүл хүүхэд байхдаа ч уйлдаггүй байсан. Хүүхэд уйлахад уушги сайжирдаг тул эмч нар намайг зод гэдэг байсан юм гэнэ лээ. Цахилгаан тэргэнээс тэр олиггүй амьтанд нулимуулсандаа би уйлаагүй, харин уйлчих дөхсөн юм. Гурван жил өнгөрсөн хойно одоо хүртэл үүнийг бодохоос зүрх дэлсэж уур минь цээжинд багтаж ядан, тэр булай хоншоорыг тасар татмаар болдог боловч даанч цахилгаан тэргээр зугтсан юм даа! Зөв зүгээр байхад минь нулимж орхиод

цахилгаан галт тэргээр зугтсан шүү! Үүнээс хойш нэг ч мангуу амьтан, дэлхийн нулималтын аварга ч байсан нулимж хүрэхээргүйгээр галт тэрэгнээс зайтай зогсдог болсон юм.

Костя ногоон дээр түрүүлгээ харан хэвтэж, толгойгоо өндийлгөлгүй асуусан нь:

— Чи юунд тийм юманд оролцоно вэ?

— Харж зогсох хэрэг үү?

— Чамайг навс зодох байсан шүү дээ.

— Хараад зогсож байх юм бол танхай юмнууд бүр толгой дээр гарна шүү дээ.

— Чи ухаантай юм уу, тэнэг юм уу, би ойлгохгүй юм.

— Бид хоёр бие биеийнхээ тэнэг цэцнийг дуудаад байвал ч...

— Чи Везнийд юунд очдог юм бэ? гэж Костя гэнэт асуудаг байна.

— Чи өөрөө яах гэж очдог юм бэ?

— Надад мөнгөний хэрэг байна.

— Чи мөнгөөр яах юм?

— Орон сууцын хоршоололд өгөх гэсэн юм.

— Чи байргүй юү?

— Энэ бол хойд эцгийн байр аа.

— Чи хойд эцэгтэйгээ мэддэг юм уу? гэж самгардан бувтнахад

минь

— Мэднэ ээ гэв.

— Чамаас үүнийг нуудаг гэж над нэг хүн хэлсэн юм.

— Мэднэ.

— Тэд чамаас, чи тэднээс нуудаг юм биз дээ? Яах гэж?

— Миний эцэг биш гэдгийг нь түүнд хэлнэ ээ би!

— Хүмүүжүүлсэн хүн л эцэг нь байх ёстой доо. Костягийн царай нь хувирсныг хараад дотор аягүй боллоо.

— Чиний саналыг асуусан хүн алга, мэдэв үү?

— Мэдлээ.

Би юу гэх вэ дээ? Түүний хувийн амьдралд хөндлөнгөөс ёсон бусаар оролцлоо шүү дээ.

— Тэгвэл амаа хамхи гээд Костя ногоон дээр дахиад түрүүлгээ харан хэвтэв.

Костя надад ширүүн авирласан боловч би түүнийг өрөвдөв. Уул нь санаа сайтай залуу юм. Эцэг эхийгээ гомдоохгүй гэж төрсөн эцгийнхээ явдлыг үнэнээр нь мэддэгээ тэднээс нууж байна. Нийцгүй,

ширүүн дориун авиртай ч санаа сайтай залуу юм! Нэг л ганцаардмал байдалтай. Дэндүү «хувиа хичээж», өөрийнхөө зангаас болж байгаа хүн юм даа! Хүн гаднын нөхцөлд нэрвэгдвэл яая гэх вэ, гаднын нөхцөл ямар ч байж мэднэ. Жишээлбэл, хүн машинд дайруулж тахир дутуу болбол насан туршаа тэр чигээрээ болно гэсэн үг. Харин өөрийнхөө зангийн мууд ингэвэл үү? Зангаа засахад тийм хэцүү гэж үү? Ээжтэйгээ, хойд эцэгтэйгээ ний нуугүй ярилцах юм бол нууж хаахын зовлонгүй, тусдаа гарч орон сууцын хоршоололд өгөх мөнгө цуглуулах хэрэггүй болно.

Костя халааснаасаа сийлбэр гаргаж ирэв. Хүүхэлдэй тэвэрсэн охин байна. Охины царай ямар нэг үнэтэй зүйлээ алдсан мэт байдалтай аж. Хүүхэд л юмандаа яг ингэж харуусдаг даа. Түүнийг нь их нарийн харуулсан байна.

Би буудлын зүг толгой дохиж

— Тэндээс авав уу?

— Тийм.

— Сайхан эд юм аа... Сийлбэр бүр яагаад дандаа ийм гунигтай байдаг юм бол?

— Чи ч дандаа баясгалантай байх санаатай л даа гэж Костя хэлэв.

Алсын аянаас Москвад ирж байхад нэг л онцгой сэтгэгдэл төрдөг юм. Ойрхон яваад буцаж ирэхэд ч бас тийм сэтгэл төрдөг.

Вагоны цонхоор харахад Москва таньж мэдэхгүй, хөл хөдөлгөөнгүй юм шиг санагдаж ямар нэг гудамж талбайг олж харъя гэхэд ганц ч гудамж, нэг ч талбай үл үзэгдэх бөгөөд хэлбэр дүрсгүй багширсан барилга байна. Галт тэрэгний буудлаас гарангуутаа талбай, гудамжаа шууд таньж, машин, яарч яваа хүмүүсийг харж, Москвагийн хөдөлгөөн, үнэрийг мэдрэхэд сайхан. Бүх юм өөр болчихсон гэж нэг хүн бодож байхад үнэндээ юу ч өөрчлөгдөөгүй байдаг. Нөгөө л гудамж, байшин, хоршоо, гудамжны цардмал талбай, элсэн дээр наадаж буй хүүхдүүд, биеийн тамирын барааны дэлгүүрийн арын хашаа дахь хоосон хайрцаг, усан оргилуур, хаалганы дэргэд суугч цахилгаан шатчин авгай аанай л хэвээрээ байна. Нэг хүн байхгүй байсныг хэн ч анзаараагүй, тэр хүнийг хаашаа ч яваагүй юм шиг харна! Лут том Москвад хүн гэж элсэн ширхэг шиг байдаг байна.

Спортын барааны дэлгүүрт үдийн завсарлагаа болж, худалдагч бүсгүйчүүд нарлаж, аарц ууж байна. Манай байшинд сүүний дэлгүүр байдаг юм. Бас талхны газар, орон сууцын гал зуух бий. Хоолоор дутахгүй. Спортын гутлын тасгийн Зоя хаалганы хажууд суугаад аарц ууж байна. Би дэргэд нь очиж суув. Шмаков Петр байхгүй байгаа нь хачин. Үдийн завсарлагаагаар хашаанд л дандаа эргүүлдэж байдаг сан. Энэ удаа алга байсан тул би ч Зоягийн хажуу дахь урт сандал дээр сууж авлаа.

Дэлгүүр дотор Зоя инээнэ гэж зангүй, харин гадаа инээмсэглэдэг юм. Инээмсэглэх нь ч нойрмог, нүд нь ч нойрмог, өөрөө ч хөдөлж ядсан махлаг зузаан. Зөвхөн хэн рүү ч ялгаагүй инээмсэглэх бөгөөд зарим хүн үүнийг нь буруу ухаж мэднэ. Эмэгтэй хүн инээмсэглэхийнхээ өмнө сайн бодох хэрэгтэй.

Худалдагч бүсгүйчүүд аарц ууж аальгүйтэн, жолооч нартай шаан паан хийнэ. Манай хашаанд жолооч олон бий. Тэгтэл утасны хорооны засварчин, монтёрууд хөшилдөж, намайг Зоягийн хажууд сууж байгааг харсаар байж, Зоягаас үг өднө. Зояг өөрсдийгөө хараад инээмсэглэж байна гэж бодоцгоожээ. Түүний зүгээр л нэг инээмсэглэж байгааг мэдэхгүй байгаа юм.

Ний нуугүй хэлэхэд Зоятай ярих юм олддоггүй юм. Шмаков Петр олдог бол би үгүй дээ. Шмаков ямар ч охинтой хэл амаа олно гээч. Гэхдээ сүүлд нь түүний юу ярьсныг санах гэвэл сэтгэлд буух юм ганц ч байхгүй. Ямар ч утгагүй аялга үгс л байдаг. Гэтэл охид инээлдэн, өлгөж авахыг нь яана. Ямар ч утгагүй юм бурж байхад тэдэнд аятайхан санагддаг байж. Би утгатай юм ярих гэж оролддог. Гэтэл охид үүнийг маань таашаадаггүй. Тэд инээж өлгөж авах нь битгий хэл ямар балай юм донгосоод байна вэ гэх аятай нүдээ бүлтийлгэнэ гээч.

Тэгтэл надад сайхан санаа төрж:

— Завины дүүжин мотор ямар үнэтэй байдаг вэ?

— Манай тасагт байдаггүй гэж Зоя инээмсэглэн хариулаад

— Светланаас асуу гэв.

— Тануус шинэ мотороллёр авах гэж байгаа гэсэн байхаа.

Манай тасагт ирэхгүй. Раяагаас асуу гэж Зоя инээмсэглэв.

Би юу ярихаа ердөө ч мэдэх ээ байв. Үүний юу сонирхдогийг чөтгөр бүү мэд!

— Танайх хаана байдаг вэ?

— Таганкад, Нөхөрлөлийн гудамжинд.

— Хол уу?

— Хол оо.

— Ах эгч бий юу?

— Гурван ах бий.

— Чи отгон нь юм уу?

— Тиймээ.

— Тэд чинь хаана ажилладаг юм?

— «Алх хадуур» заводод.

— Надад ч ах бий, гэхдээ үеэл ах л даа. Касимовт суудаг юм.

— Өө тийм үү гээд Зоя инээмсэглэв.

Хашаанд нэг «Волга» орж ирээд үүдэнд зогслоо. Түүнээс саарал костюм, цагаан цамцтай Веэн гарч ирсэн нь Америкийн автомашины пүүсийн зарлалын зураг дээр байдаг английн язгууртантай адил байлаа. Машин нь наранд гялалзаад л, Веэний хүрч ирсэн нь спортын барааны дэлгүүрийн худалдагч бүсгүйчүүдэд лут сэтгэгдэл төрүүлэв.

Би өөрийнхөө байдлыг сүүлд бодож үзээд тун тааруухан, тэр ч байтугай базаахгүй авирласнаа ойлгосон юм. Харин тэр үед үүнийг ухаараагүй байжээ. Веэн машинаас гарч ирж олны анхаарал түүнд татагдсанд би энэ их сүр бараатай, сайхан машинтай язгууртан

намбатай хүний нөмөр нөөлөгт багтмаар санагдаад явчхав. Тийнхүү нэр нүүр олох гэсэн гавихгүй бодол төрөв. Зояд сайрхаж танилаараа гайхуулмаар санагдлаа. Би Веэн рүү нөхөрсгөөр толгой дохин, ухаандаа за найз, сайн! гэсэн байртай инээмсэглэв.

— Аа Крош сайн уу!

Веэн Зояг харлаа.

— Танилц, энэ Зоя.

Веэн маасайтал инээмсэглэж,

— Их баяртай байна гэв.

Тэгээд хаалганыхаа бариулаар бидэн рүү далласнаа хаалгаар далд оров.

— Миний сайн танил урлаг судлагч, хуучны ховор юм цуглуулагч гэж би хайхрамжгүй хэллээ.

— Сонин эр юм.

Энэ үгийг би гайхав. Зояд тэр юуны нь эр байх вэ. Бараг эцэг нь болохоор хүн байхгүй юу.

— Сайхан хувцастай юм.

Энэ бол өөр хэрэг. Хувцас нь үнэхээр сайхан юм. Эмэгтэйчүүд хүний хувцас хунарыг шинжих дуртай байдаг болохоор Зоягийн тийнхүү ажигласан нь зүйн хэрэг.

— Хувийн машинтай байх сайхан юм аа гээд Зоя инээмсэглэв.

Би хувийн машины тухай асуудлыг юу гэж үздэгээ хэлж амжаагүй байтал дэлгүүрийн үдийн завсарлага дууслаа.

Орой нь Игорь над утасдаж:

— Өвгөөн, маргааш машинаар хотын зах гаръя. Бүсгүйгээ аваад явж болно шүү гэв.

— Ямар бүсгүй?

— Зояг.

Игорь түүний нэрийг мэддэг байх нь. Ер нь Игорь ч гэсэн спортын барааны дэлгүүрээр эргэлддэг юм л даа.

— Тэр чинь миний бүсгүй биш ээ.

— Өвгөөн, эр хүн шиг байж үзээч.

Зояг урьж болохгүй яах вэ. Гэхдээ Шмаков Петрээс нууцгай шүү...

— Би ганцаараа явна аа.

— Өөрөө л мэд. Нэг хүн таван рубль гаргана.

— Надад таван рубль байдаггүй дээ.

- Олох хэрэгтэй, өвгөөн.
- Олдохгүй ээ.
- За яах вэ аргаламз. Харин эргүүлж өгнө шүү.
- Ямар яриа байх вэ!

Бид хоёр машинаар, Веэний «Волга», Игорийн, үнэндээ бол Игорийн ахын «Москвичаар» гарав. Игорь үүнийг өөрийнхөө машин мэт царай гаргадаг боловч ахаасаа хэчнээн их гуйж гувшиж царай алдан байж авдгийг нь би юу эс андах вэ. «Волгад» Веэн, Нора, Зоя бид дөрөв суулаа. «Москвичаар» Игорь, Костя, бас Зоягийн найз, спортын барааны дэлгүүрийн худалдагч Светлана, Рая гэдэг хоёр бүсгүй явав. Охидыг Игорь урьсан юм.

— Өвгөөн, яг тусгай захиалгаар юм шиг байгаа биз гэж Игорь над руу нүд ирмэв.

Зояг үзээд би анхандаа самгардсан боловч сүүлдээ баярлалаа. Би түүнийг өөрөө урьсан бол Шмаков Петрийг араар нь тавьсан хэрэг болох байсан. Гэтэл энд түүнтэй санамсаргүй нийлсэн болохоор би ямар ч гэмгүй. Аз таарна гэдэг энэ. Бүсгүйгүй бол энд би маанаг юм шиг байх байсаан.

Бид майхан, аяны хөнжил, хийлдэг дэр, цэнэглэсэн савтай хийн зуух, халуун савтай кофе цай, шорлог шарах сүлбүүр, том сияан хувинд дутуу болгосон шорлог хийж цуугаар амтлан дугариглаж хэрчсэн сонгиноор хачирлаад бас өчнөөн төчнөөн юм авч гарав. Машинд юм пиг чихчихсэн тул Зоя бид хоёр шахцалдан суух хэрэг гарлаа. Зоя надаас хөндийрсөнгүй. Хааяа эргэж нүдийг минь ширтэн дуугүйхэн инээмсэглэнэ.

Би Шмаков Петрийг бодсонгүй. Юуны чинь Шмаков Петр? Хэн ч лангуу шөргөөн зогсож чадна, энэ ямар хамаатай юм бэ. Зоя Шмаковт сайн байсан бол бидэнтэй яалаа гэж явах вэ. Зоя Шмаков Петрийг огт тоохгүй, юман чинээ санахгүй байна. Би гараа гарынх нь дэргэд тавьсан боловч Зоя гараа татаж авсангүй. Намайг гараа барихыг хүлээн байх бөгөөд гар нь зөөлхөн, аяыг минь дагах ажээ. Зоягийн гарыг атгаж, түүгээр барахгүй үнсэж болно, над үнсүүлнэ гэж бодохоос энэ насанд төрөөгүй омог төрж бардамнах сэтгэл намайг эзэмдэв.... Хэнд ч зөвшөөрөхгүй, надад бол зөвшөөрнө... Би үүнд бардамнан эрэмшиж, хамаг сэтгэл хөөрөөд, хүнгүй харанхуй ойд Зоятай хоёулхнаа зогсож байна гэж бодлоо.

Зоя над руу эргэж инээмсэглэхэд нь тэр бас миний бодож байгааг бодож байх шиг санагдав. Боодолтой баадантай юмс нухаад тухгүйхэн байсан боловч намайг биеэ холдуулж байна гэж Зояг бодуузай хэмээн би хөдлөхөөсөө ч эмээж явлаа.

Нора Веэний хажууд эзэгтэй адил заларч Зоя бид хоёрыг, ер нь ертөнцийн хамаг амьтныг дор үзэж явна.

Бид Минскийн засмалаар давхиж, өчигдөр Костя бид хоёрын очсон жуулчдын зочид буудлын хажуугаар гараад, харуй бүрий болж байхад Звенигородын засмал руу эргэв. Зураан дундуур тавьсан засмал зам нэг үе гүн нугачаа руу орж, нэг үе эгц даваа өөд өгсөнө. Эргэн тойрон битүү ой ширэнгэ үргэлжилж нэг хотойн нэг гүвийж асар том давлагаа болон үелжээ.

— Москва орчны Альпа гэж Веэн хэллээ.

Бидний явж байгаа газар үнэхээр маш үзэсгэлэнтэй ажээ. Гэхдээ Альпад очиж үзээгүй болохоор Альпатай адил эсэхийг бүү мэд, Альпа гэхлээр шөнө гэлэнгүүдийн барьсан дэнлүүний гэрэл, осгосон аянчныг дарсан цас малтаж байгаа лут том эрүүлч нохой санаанд ордог юм.

Би Костяд майхан шаахад нь тусалж Рая, Светлана хоёр гишүү түүн, Игорь магнитофон янзалж, Веэн Зоя хоёр шорлог хийж байв. Нора Веэнг шорлог шарахад нь Зоягийн хамжилцаж байгааг харан хожуул дээр хямсалзаж сууна. Юунд ингэж муухай аашилна вэ! Хэн нэг нь Веэнд туслалгүй яах вэ. Хижээл насны буурь суурьтай ах гуай хормогч зүүхээд өөрөө шорлог шарж байхад дэмий суугаад байвал эвгүй шүү дээ!

Костя бид хоёр пүүгээгээ майханд зөөж оруулав. Майхан жижигхэн учир сайндаа л хоёр хүн багтана. Бид энд унтаж, охид машинд тэнийдэг суудал дээр унтах юм.

Рая, Светлана хоёр хичээнгүйлэн гишүү түүх ажээ. Турь муутай, олон таван үггүй энэ охид ерийн нэг зугаалгад ирээгүй, ямар нэг хүлээн авалтад ирсэн юм шиг, энд эрхэмсэг оюуны ажилтан, ардын жүжигчин буюу гавьяат зүтгэлтэн нар байгаа юм шиг байлаа. Веэний намба сүрд дарагдан тэр хоёр түүнийг эгц ч харж үл чадна.

Зоя идэх юм түгээж өгч, талханд хачир түрхэх зэргээр зүгээр үл сууна. Ингэхдээ Зоя тун ялдамхан сурмаг учир хүн бүхний сэтгэлд аятай санагдаж, Веэн хүртэл түүнийг «Зоевка» гэж дуудаж байв. Ганц Нора л түүнд, ер нь хүн хүнд мөчөөрхөх ажээ.

— Манай жижиг боловч нягтармал, иймээс хүчирхэг нөхөрлөлийн төлөө анхны хундагыг тогтооё гэж Веэн хэлэв.

Бид уучхаад дарууллаа.

— Бүгдээрээ хөгжилтэй тохитой амрахын төлөө хоёр дахь хундагаа тогтооё

Бид дахин хөнтөрч даруулав.

— Хонгор бүсгүйчүүлийнхээ төлөө гурав дахиа тогтооё.

Тэгээд Веэн Зоятай тулгав. Тэр хоёр нэг доор сууж байсан учир Веэн түүнтэй тулгав.

Сарын саруулд тогтуун ойн гүнд дүрэлзэх түүдэг тойрон сууж, халуун сүлбүүрээс мах зулгаан идэж байгаа бид махчин аятай байсан байхаа.

Бидний элэнц хуланц өвөг дээдэс галын дэргэд мах иддэг байсан гэж Веэн ярив.

Светлана Рая хоёр бишрэн чагнана. Гэхдээ шорлогийг мань хоёр сайн гүвдэж байлаа. Айхавтар охид юм!

— Найман биеийнхээ төлөө ууя! Бид чинь наймуулаа шүү дээ гэж Веэн хэлэв.

— Наймуулаа гэж Игорь зулгуйдан давтав.

Веэн сүлбүүртэй шорлогоо дээш өргөж.

— Бид бие дааж, цуг явж, бие биедээ үнэнч байгаа цагт юунаас ч айхгүй, хийе л гэснээ хийнэ.

— Охид оо! би та нарыг кинонд авна гээд Игорь Рая Светлана хоёрыг хүзүүдэж, — Биеийнх нь галбирыг харагтун, Лоллобрижидүүд л гэсэн үг гэв.

— Чи кино найруулагч болчихсон уу? гэж намайг асуухад Веэн

— Игорь эдэнд туслах гэж байгаа нь гол юм. Игорийн энэ сайхан сэтгэлийг л би үнэлдэг дээ. Энэ дэлхийд юм юмыг амжуулдаг л байх хэрэгтэй. Насаараа амь улжиж яваад үхсэн хойноо хэчнээн ч магтуулаад яах юм билээ дээ. Артаньяныг би өнгөрсөн, эдүгээ, ирээдүйн бүх агуу их зүтгэлтнээс ч илүү үнэлдэг юм. Ингээд л Артаньян, Атос, Портос, Арамис нарын төлөө!

Эхэн үед Веэн цөмөөрөө ууж уу, үгүй юу гэж хардаг байсан бол одоо хувиа л борлуулж байлаа. Тэгээд сав л хийвэл «Шадар гурван цэргийг» нэр цохож байх юм. Үүнээс өөр юм юу ч уншаагүй хэрэг үү?

Гэвч Веэн айлтгалаа зэгсэн үнэн сэтгэлээсээ хэлэв. Энэ нь бүгдийг уяруулжээ. Бүгдээрээ ам халж ирсэн болоод ч тэр байж мэднэ. Би зөвхөн «Мукузаныг» л уусан боловч бас л толгойд гарчээ.

— Бүжиглэе гээд Игорь магнитофон тавив. Светлана Рая хоёр дэрхийн босож твистэлж гарлаа. Яриа байхгүй догь хийж байлаа. Гэхдээ дэндүү улайрч дэндүү хичээх ажээ. Игорийн дараа Костя, Костягийн дараа би, тэгээд бас Игорь гэх зэргээр ээлжилсээр тэдэнтэй бүжиглэж байхад Светлана Рая хоёр ч баадууг нь чангалчихсан юм шиг эргэж байлаа. Элдэв янзаар хөдөлж байна гэдэг нь жигтэйхэн. Костя ч гэдэлзэж бөхөлзөнө. Харин Игорь янжуур зуучихсан, хайхрамжгүй дороо хавчин бүжиглэнэ. Би ч гэсэн тайван бүжиглэлээ. Тэгэхгүй бол таван минутад багтарч мэдэхээр бүжиг.

— Пресли хэн ч барихгүй дуучин даа гэж Игорийг хэлэхэд

— Поль Анка автомашины осолд ороогүй бол чиний Пресли юу гавих вэ гэж Костя үг сөргөв.

Игорь өөрийнхөөрөө зүтгэж, Преслийг хамгийн мундаг дууч, Брубекийг хамгийн лут төгөлдөр хуурч, Армстронгийг хамгийн сайн бүрээч гэлээ.

Хамгийн мундаг төгөлдөр хуурч бол Брубек биш, аяыг цээжээр зохиодог сохор негр юм. Сохор болохоороо аяа дандаа цээжээр зохиодог, цээжээр зохиосныгоо бичиж чаддаггүй юм гэж Костя хэллээ.

Тэр сохор негрин хөгжимдөж байгаа туузыг Костя тавив. Энэ бол ямар нэг татганасан бүжгийн ая биш, харин ёстой хөгжим шиг хөгжим байлаа. Тэр бээр Дюк Эллингтоны «Жинчнийг» тоглож, би ч хөгжимдөж эхлэнгүүт нь л үнэхээр агуу хөгжимчин болохыг ойлгов... Элсэн цөл цэлийн, жингийн тэмээд найгалзан алхаж цагаан ороолтоор толгойгоо ороосон аянчин хажууд нь дагана... Эхний айзмын дараа цээжээр зохиосон гайхамшигт ая дуулдаж, жингийн сэдэв мэдэгдэхгүй шахам болсон бөгөөд үүнийг ялгаж сонсоход сонор маш сайн байх хэрэгтэй ажээ. Би олж сонссонгүй нь мэдээж, Игорь ч олж сонссонгүй, харин Костя ялгаж сонсоод дагаж аялав. Ингэхэд нь бид олон өнгөт цээж аялгууны дундуур уг сэдвийг олж сонслоо. Би Костягийн хөгжмийн авьяастайг гайхав. Уг нь үүнийг гайхах юмгүй, дүү охин нь хөгжим зохиодог, гэр бүлээрээ хөгжмийн авьяастай улс юм. Энэ нь Костягийн сэхээтэн төрхийг улам лавшруулав. Хөгжимд авьяастайгаараа сайрхаж байсан удаагүй. Тэр ч байтугай цухуйлгасан удаагүй. Хэрэг гарахлаар гаргаад ирж байна.

Сохор негр лут тоглож байна, гэхдээ Брубек илүү санагддаг гэж Игорь хэлэв. Хэрэв мэдье гэвэл модернизмыг баримталдаг төгөлдөр хуурч бол манай Толя Морковский байгаа юм даа, ганц гэм нь авьяасаа дэлгэрүүлэх газар даанч алга. Хөнгөн хөгжимд бүрээ гоцолдог, тэгэхлээр дэлхийн хамгийн сайн бүрээч бол Луи Армстронг. Юу ч гэлээ гэсэн өвгөн Армстронг дэлхийн хамгийн сайн бүрээч. Тэр дэлхийн хөнгөн хөгжмийн хамгийн сайн дууч ч байж магад. «Тогтсон их цээл хоолойтойдоо» гэж Игорь түүнийг бахдан үнэлэв.

Хөнгөн хөгжим сонсож байхад хэний янаагүй цөмийг нь тоглож чадах юм шиг бодогддог юм. Нугалгаатай, цохилттой, түргэн аянд би дуртай. Үгийг нь би хайхардаггүй. Хөнгөн хөгжмийн дуунд үг ямар хэрэгтэй юм бэ? «Би чамд хайртай, чи наддаа хайртай юу? Хоёулаа бүжиг хийе» гээд л хамаг үг нь болох нь тэр. Бас цыган хөгжим сайхан байдаг юм. Ганц «Хар нүд» гэхэд л юутай ч эгнэхгүй. Луй Армстронг ч үүнийг дуулдаг гээч. Цыган хөгжим манай хөгжим шүү дээ.

Чамирхагчид цөмөөрөө манай аяыг шүүрдэг юм. Би орос дүрвэгсдийн тухай ярихгүй ээ... Харин тэднүүс гадаадын хүн шиг хазгай дуудлагатай дуулдаг нь хачин. Эх хэлээ мартсан байх нь уу? Эсвэл удам судар нь дуулж байгаа юм болов уу?

Тууз дуусав. Бид амсхийлээ. Нэг харсан чинь Везн Зоя хоёр цоорхойд алга. Тэдний хаачсаныг асуусанд Игорь:

— Усанд явсан гэв.

Нора хөх инээдээр инээж

— Охиныг алдаж дээ... гэж хошуу нэмэрлэв.

«Тэр хоёр усанд явсанд гойд юу байгаа юм бэ? Ус утгаж аваад л ирнэ биз. Хардах гэдэг ой гутам зүйл, хүнийг шал сохор болгоно гээч» гэж бодогдов.

Дөнгөж ингэж бодтол Везн Зоя хоёр данх, сияан хувин барьчихсан хүрч ирлээ. Нораг тохуурхангуй харахад мань хүний царай хөхийн барайжээ. Бид хэд дахиад түүдгээ өрдөж, ус халаан сав суулгаа угаалаа. Зоя инээмсэглэхээ больжээ. Везнийг нэг юм хэлэхэд л ганц удаа ичингүйрсэн бодлогоширсон, эмээсэн байртай инээмсэглэн аядав.

Сэтгэл нэг л гунигтай болов. Везн Зояг оролдох гэлээ гэж үү дээ.

Машинд Зоятай хамт сууж байхад намайг эзэмдсэн омог бардам сэтгэл дорхноо хөрөв. Тэгэхэд Зоягийн гарыг атгаж, түүнийг үнсэж болно. Ингэх эрхтэй, надад, ганц надад л үнсүүлнэ гэж бодож явсан. Үүндээ бахархаж, омгорхож, магнай хагартал баярлаж байж билээ. Одоо би баярлах юм огт үгүй, нэг л уйтгартай гол харламаар байлаа. Нэг юм эмт үсэрч алга болж, эвдрэх шиг болов... Зоя Везний оролдоход царай өгсөн эсэх нь хамаагүй, Зоя сэдэв гаргаж өглөө. Майка бол сэдэв өгөхгүй байсан! Зоя өгчээ.

Зоятай машинд явахад юу ч болоогүй байж магадгүй яа? Намайг налаад байх шиг байсан нь миний санаа дагаад тэгж бодогдсон юм болов уу? Боодолтой шуудайтай юманд шахагдаад тэгсэн байж болзошгүй яа? Ийм явдал нэг удаа тохиолдсон шүү дээ. Өнгөрсөн өвөл юм даг... Би нэг охинтой «ЗСБНХУ-ын түүхийг» авч уншлаа. Уншлагын танхимд ганцхан хувь байсан учир хоёул авч хамт сууж уншсан юм л даа. Тэр охин зориуд надад ойртож суух шиг надад санагдаад явчхав. Хамаг бие хөшиж, номын ганц ч мөр олж харахаа болив. Би түүн рүү харж ч зүрхлэхгүй байлаа. Түүн рүү эргэх гэвэл түүнийг үнсчихээр байв. Зүгээр нэг эргэж байх нь эвгүй. Би ганц ч охин үнсэж үзээгүй. Үнсчихвэл дараа нь түүнд нэг юм хэлэх хэрэгтэй.

Тэгээд юу гэж хэлэх юм бэ? «Би чамд дурлаж байна» гэж хэлэх үү дээ? Гэтэл би түүнд огт дурлаагүй. Намайг тэгж дүйнгэ юм шиг сууж байтал өнөө охин маань «Чи уншиж гүйцэв үү» гэж асуудаг байна. Тэгтэл хоолой дээр юм тээглэчхэв. Нээрээ шүү, юу ч дуугарч чадсангүй. Уншсаан гэх аятай толгойгоо дохиж орхилоо. Тэр, охин хуудсаа тайван эргүүлж цааш уншиж гарлаа. Би түүхийн хичээлд «хоёр» авснаар энэ явдал шувтарч билээ. Түүнийг ядахдаа ганц үнссэн бол ч бас яая гэх вэ. Яаж ч чадсан юмгүй «хоёр» дэгээдчихсэн минь тоогүй.

Одоо тэрүүн шиг болж байж магадгүй биш үү? Санаа дагаад л Зояд аятайхан харагдсан гэж салагдаж байгаа ч юм бил үү?... Гэсэн ч сэтгэл нэг л хачин, ёозгүй байлаа. Шмаков Петрийг бодоход бүр ч авгүй болов. Веэн надад хуншгүй зан гаргаж, би Шмаковт найзын мөсгүй явдал гаргалаа. Шмаков Зояд надаас илүү сэтгэлтэй. Тэр ёстой дурлаж байхад би зүгээр шохоорхож байсан бөгөөд би түүнийг эргүүлэх гэж байж харин Веэнтэй танилцуулчихлаа. Хэрэв Зоя Шмаковоос бүрмөсөн эргэвэл Шмаковын сайн найз би л буруутай.

Зояг эндээс ямар ч байсан аваачих хэрэгтэй. Москвад аваачаад Шмаковт бүх үнэнээ тоочье, тэр өөрөө Зоятай учраа олог. Би Зояг зугаалгад уриагүй, тэр ч байтугай урихыг татгалзсан! Түүнтэй машинд хамт сууж явахдаа бодсон зүйлийг минь хэн ч мэдэхгүй. Зоя ч бас огт мэдэхгүй. Гэхдээ Зояг яаж аваачих вэ? Бид хоёр хаачих билээ. Зам дээр гарч чадна аа. Цаашаа хаачих вэ? Өртөө баруунтай байна уу? зүүнтэй байна уу? Энд ойр төсөр өртөө байгаа болов уу? Зояг явъя гэж яаж ятгах вэ? Гэнэт татгалзвал яана? Жаал явъя гэж гуйгаад төөрсөн болоод өөр тийшээ явчих уу? Энэ ямар хөвч биш дээ. Ямар нэг зам тааралдах байлгүй. Бидэнд саад болж мэдэх ганцхан юм бол магнитофоны дуу юм.

Би магнитофонд дөтөлж суув. Үнэтэй эд, гэхдээ хүний хувь заяа үүнээс ч үнэтэй. Туузыг нь солингоо би дугуй доогуур нь гараа явуулж утсыг нь таслав.

— Крош оо, хэчнээн ноцолдох гэсэн юм бэ? гэж Игорь хашхирав.

— Одоохон гэх зуураа хоёрдох утсыг тасаллаа.

Тэгээд товчийг нь дарахад магнитофон ажилласангүй.

— Аппарат ажиллахгүй байна гэхэд минь Игорь намайг түлхээд чадахгүй байж бүү оролдож бай гэв.

Игорь товчтой нь ноцолдож гарахад би Зоягийн дэргэд очиж:

— Зоя, түр уулзья гэлээ.
Зоя босож хойноос минь дагав.

Бид жим дагаж явав. Манай найзуудын дуу дуулдахааргүй хол явъя гэж бодож байлаа.

— Чи намайг хааш аваачиж явна аа?

— Энд... нэг сайхан чөлөө бий. Би чамд үзүүлье. Миний маанаг хариу Зояд хангалттай санагдсан бололтой.

Дуу сонсогдохоо болилоо. Эргэн тойрон модод хөдөлгөөнгүй бараалж, хөл доор хуурай гишүү тас няс хугарна. Би өөр нэг жимээр орж тэндээс бас нэг рүү оров. Энэ нь жим биш ч байсан байж мэднэ, харанхуйд ялгаж харахын аргагүй байсан боловч мөчир нүүр рүү учиргүй ороолгохгүй байсныг бодоход ширэнгэ биш бололтой. Бид ирсэн зүгийнхээ эсрэг зүгт явж байснаа баруун гар тийшээ эргэв. Би өөрсдийнхнийгөө тойрон гарч, ирсэн замдаа нийлэхээр бодож байв. Тэнд замын машин дайралдах юм уу, үгүй ядахад замаар явахад ямар нэг орон байр таарна.

Бид өргөн зураанд ирлээ. Зогоож болно. Бид дархи модон дээр суулаа.

— За?! гээд Зоя инээмсэглэв. Гэхдээ ердийнхөөрөө биш, насанд хүрсэн бүсгүй хүн хүүхдэд ялихгүй дооглонгуй, үл мэдэг зоригжуулсан янзтай, тэгээд сониучирхсан байртай жаахан эргэлзсэн байдалтай инээмсэглэдэг шиг инээмсэглэв шүү. Ингэж инээмсэглэхийг би мэднэ, үүнийг чөтгөр аваасай! Хоёр сарын өмнө манайтай айл байдаг Елизавета Степановна авгай ингэж инээмсэглэн намайг хардаг байсан юм. Би түүний нүдэнд аль болох олон өртөхийг хичээж, инээмсэглэхийг нь харах гэж хашаанд түүний гарч ирэхийг хүлээн суудаг байсан юм. Гэтэл Елизавета Степановна инээмсэглэхээ гэнэт болив. Тэгээд л гүйцэх нь тэр. Намайг харахаа ч байлаа... Нэг удаа Шмаков Петртэй дааман хаалган дээр зогсож байтал Елизавета Степановна хажуугаар өнгөрөхдөө дахин инээмсэглэв. Миний баярласныг яана. Гэтэл учрыг нь олоод Шмаковт инээмсэглэсэн болохоос биш, над инээмсэглээгүй ажээ. Би нэг үе тамаа цайж, Шмаков Петрт атаархаж явав. Тэд дийлсэн байртай, их учиртай, янзтай нь аргагүй явна. Сүүлд нь Елизавета Степановна түүнд инээмсэглэхээ болиод Васька Полянскийд инээмсэглэх болов.

Энэ бол аль дивангарын, хоёр сарын өмнөх юм. Гэтэл одоо унанги модон дээр Зоятай сууж байхад Зоя яг Елизавета Степановна шиг ялихгүй доогтой, үл мэдэг зоригжуулангуй, тэгээд сониучирхсан янзтай, жаахан эргэлзсэн байртай инээмсэглэдэг байна. Ингэж инээх ямар байдгийг би юу эс андах вэ. Түүнээс гадна Зояг Шмаков Петрийн төлөөнөө аврахаар бат шийдсэн юм.

— Манай найз нар чамд ямар санагдав? гэж би хөндийвтөр асуулаа.

— Игорь инээдэмтэй юмаа.

— Нора?

— Сайхан л бүсгүй юм.

— Костя?

— Костя ч зүгээр санагдаж байна.

— Тэгвэл Веэн?

— Веэн гэж хэн юм бэ?

— Владимир Николаевич.

— Аятайхан санагдаж байна.

— Тэр чинь нас нь талийсан хүн. Дөч хүрсэн ч байж магад.

— Бие даасан хүн.

— Тэгвэл Шмаков Петр?

— Петя бас бие даасан хүн шүү.

Ийм дүгнэлтээс мангуурч хоцрох юм байна. Бие даасан гэдэг үгийг ямар утгатай хэлж байна аа?

— Тэгвэл би бие даасан уу?

— Чи сайн жаал.

Ганц гялайлаа. Тэд бие даасан хүмүүс, би сайн жаал гэнэ. Үгүй мөн гялайв аа!

— Би чамайг үнсвэл яах вэ?

— Үнсмээр санагдаж байна уу? гэж Зоя инээмсэглэн асуулаа.

Ингэж асуухад нь би тэвдэв. Би юу гэж хариулахаа мэдсэнгүй. Зоя хажууд минь сууж, сарын саруулд царай нь гойд ялдам, хөөрхөн харагдан сэтгэл жигтэйхэн догдолж үнсээд авах сан гэж хачин их санагдаж байлаа. Гэвч үнэнийг хэлэхэд би охидыг ганц ч үнсэж үзээгүй. Янз бүрийн маанаг бооц тавьж үнсэж байсан, жинхэнэ, ёсоор бол үгүй ээ. Миний хоолой давчдан чүү чамай

— Тиймээ гэж хэллээ.

Зоя инээмсэглэн ялихгүй тонгойход нь би хацрыг нь үнсэв. Зоя аяархан инээж мөрөө овгосхийлгэснээ намайг наллаа.

Үс нь хацар ирвэгэнүүлж нэг л аятайхан, сэтгэл хөдлөм үнэр анхилна. Зояг дахиад үнсмээр байсан боловч түүний амгаланг алдуулахаас айв. Түүнд ингэж суух нь дулаахан эвтэйхэн байгаа.

Тэгж байснаа толгойгоо сэжээд,
— Хонгор минь явъя, эвгүй гэв.

Зояг үнссэнээс хойш Шмаков Петрийн төлөө түүнийг аврах гэхийн хэрэг алга болов. Одоо тайван гэгч гэдрэг буцаж болно. Шөнөжин ой дундуур тэнэх хэрэг байхгүй. Гэхдээ замаа олдог болов уу? Магнитофоныг эвд гэж намайг ямар чөтгөр нь түлхэв ээ.

Бид дуугаар нь баримжаагаа авахгүй юу.

Хоёул явлаа. Би түрүүлээд Зоя ардаас минь дагав. Шөнө ойд явахаасаа айхгүй байна. Зоригтой охин юм.

Модны мөчирт нүүрээ аль болохуйц гуядуулахгүйгээр явах гэж би хичээнэ. Хааяа зогсож чимээ чагнаж байсан боловч ямар ч ашир чимээ үл сонсогдоно.

— Бид зөв явж байна уу? гэж Зоя асуув.

— Ёстой бүү мэд!

Ийм зоригтой охин юм чинь үнэнийг нууж юугаа хийнэ.

— Аль вэ, гууглая гэж тэр хэлэв.

Бид хоёр удтал гууглаж хашхирсан боловч хэн ч хариу өгсөнгүй. Бид гарах нь нэг гарах л байх гэж урагш гэлдрэхээс өөр мэхгүй боллоо. Би ч яах вэ ямар ч модны доор унтаад өгч чадна. Харин Зояд Москвагаас зуугаад километрийн алсад ой дотуур тэнэх нь төдийлөн таатай бус байгаа.

Зоя «ядарлаа» гэв.

— Жаахан явъя, зам ойрхон байх шиг санагдаж байна.

Нээрээ ч зуу юм ууг, хоёр зуугаад алхам явтал ойн захад гарч өндөр эрэг, сарны саруулд гялалзах голын ус харагдлаа. Миний санаа амрав. Гол бол тээврийн зам, тэгээд Москва голд цутгадаг болохоор биднийг нэг газар аваачихдаа аваачна. Уруудаж явах юм бол Москвад ойртоно.

Бид хоёр хэсэг суулаа. Би Зояг дахин үнсмээр байсан боловч түүний царай нь ядарсан, үнсэлдэхтэй манатай байсан учир үнсэх барих гэж дэмийрэх эвгүй байв.

Бид ойн захыг дагаж явлаа. Зөрөг модны хоорондуур тахиралдан мушгирч нэг үе өгсөж, нэг үе уруудна. Гэнэт ус цалгилах, хүмүүс инээлдэх дуулдаж, усанд самарч байгаа улс харагдав.

Өөрсдийнхнийгөө усанд орж байгааг үзээд би зэгсэн гайхаж билээ.

Бид хоёрын ирэхэд тэднийг сүйд болно гэж бодож байсан чинь харин огт хайхарсангүй. Ганц Везн л намайг сүрхий харав. Дөнгөж үүр тэмдгэрч байгаль дэлхий өглөөний буданд хучигдсан байсан болохоор ямар, учиртай харсныг тодорхой хэлж мэдэхгүй байна. Түр зуурын шөвөгдсөн, үүний чацуу ёозгүй, арга нь барагдсан харц байсныг мэдэрснийхээ чинээ ажиглаж чадаагүй юм.

Зоя бид хоёр машин руу очиж, Зоя усанд орохдоо өмсдөг хувцас, би шуудгаа авав. Шөнө сарын саруулд усанд ороход гайхалтай сайхан, ус бүлээн, голын хаана юу байгаа нь үл мэдэгдэнэ. Чамаас хол сэлцгээж байгаа юм шиг санагдах атал дуу хажууханд сонстох нь сонин. Зоя Норатай адил усруу хар эрчээрээ үсэрч оролгүй, хулгасхийн, болгоомжтой орж хэвтээд самчсанаа намайг харан инээмсэглэнэ. Хацрыг нь үнссэнээ санахаас баяр хүрнэ.

Машин уруугаа эргэж ирээд халуун савтай кофеноос ууж, талх идэв. Кофег нойр сэргээдэг гэдэг боловч бидний нойр хүрч байлаа. Бид өдрийн хоёр цаг хүртэл унтаад, ядарчихсан үнгэлэгдчихсэн босож ирцгээлээ. Везний хацар дээр сахал нь сөрвийн гарч, шингэхэн халимаг нь налчийн нүд нь шарлан бөлцийжээ. Бид үлдсэн идэх юмаа цохиж аваад хот буцахаар болов. Охид маргааш өглөө ажилтай, тэгээд ер нь хэн ч майханд бас нэг шөнө зовохыг хүссэнгүй.

Бид юмаа цуглуулж, эвдэрхий магнитофоноо аваад машинд сууж Москвад гэгээтэй байхад хүрэв.

Би Зояд хайртай, Зоя ч над хайртайг мэдэж байлаа. Түүнийг үнссэнээ, үсний нь үнэр, мөрний нь илчийг санахад сэтгэл хөдлөн баясна. Зоя сэтгэлээс үл гарна. Цагийн зүү арван нэгийг заан, спортын барааны дэлгүүр нээгдэн Зоятай уулзаж болох цагийг хүлээн би цагаа тэсэж ядан хялалзаж байлаа.

Зун амарч байгаагийн хэрэг юу билээ, би орондоо хөрвөн сонин гарчиглаж хэвтлээ. Хашаанд лонх харшилдаж сүү авчирлаа. Сүүний дэлгүүр спортын барааныхтай адилгүй наймаас ажилладаг юм. Зоя сүүний дэлгүүрт ажилладаг сан бол таван цагт ажил тараад оройжин юу дуртайгаа хийж болох сон. Зоя цагаан халаадтай үсний торон даруулгатай, эзэгтэй нарт тараг энэ тэрийг хийж өгч байх сан. Спортын бараа сонирхож байгаа царай гаргаад худалдагч руу нүд бэлчээж тэдэнтэй танилцахыг оролдож байдаг ажилгүй залуучууд түүний дэргэд эргэлдэж байхгүй сэн. Сүүний дэлгүүрт лангууны дэргэд зогсоод байх аргагүй, бяслагийг нэг их хараад байх юу байх вэ, энд чихцэлдэх юмгүй, өөрөө өөртөө үйлчилдэг дэлгүүр болохоор юу авч ирсэн юу авч гарснаа л үзүүлнэ. Харин сүүний дэлгүүрт таргалж мэднэ. Өглөөнөөс аваад орой болтол ам хойш татахгүй идэж байдаг байх.

Цай ууж байхад ээж надад зааварлаж гарлаа. Ээж аав хоёр нөгөөдөр явах юм.

Би хаалгаа онгойлгохдоо гинжин түгжээгээ тайлалгүй онгойлгож гал тогооны өрөөнд шатдаг хийг анхаарч, халуун усны өрөөнд цорго хааж, гэрлээ унтрааж, тараг аваад шилийг нь эргүүлж өгч, гудамж хөндлөн гарахдаа гарцаар гарч, мөнгөө гамтай зарж, томоотой байх ёстой гэнэ.

Гэртээ оройтож ирж, түлхүүрээ гээж, гарцгүй газраар гудамж хөндлөн гарч, зайрмаг их идэж, зурагт радиогоо эвдэж, мөнгөө доор нь үрж, биеэ муу авч явж болохгүй гэнэ.

Цайгаа ууж, заавар авч дуусаад би спортын барааны дэлгүүрт очив.

Зоя лангууны ард зогсож байлаа. Түүнийг харангуут зүрх булгилав. Тэр ч намайг хараад бас баярлаж инээмсэглэхдээ надтай ойд шөнө сууж байснаа санасан нь мэдэгдэв.

Светлана, Рая хоёр цэнхэр дурдан даашинзаа өмсчихлөөр зугаалгад явах үеийнх шигээ тийм хөөрхөн харагдахгүй байлаа. Тэд бол театр юм уу, гэрэл зургийн газар руу явахдаа л гоё харагддаг охид ажээ. Зоя бол хэзээ ч хөөрхөн байдаг. Зоя нэг л нүдэнд тусаж, түүний төлөө яахаас ч, амиа өгөхөөс ч буцахааргүй байлаа. Би түүнийг хайрлаж хамгаалахыг хүсэж, түүнийг гомдоож мэдэх хүнийг чинээндээ тултал үзэн ядаж тийм хүнийг тасар татан хаяхаа ч сийхгүй байлаа.

Гэвч Зояаг гомдоосон хүнгүй.

Энд Шмаков Петртэй тааралдах байх гэхээс би жаахан түгшив. Түүнтэй үг хэлэлцэнэ гэдэг нэг л аягүй. Сайн найзынхаа сэтгэлд сэв суулгана гэдэг муухай байлаа. Юу ч л гэлээ гэсэн би Шмаков Петрийн урдуур орж бүсгүйг нь булаалаа. Намайг булаагаасай гэж Зоя өөрөө хүссэн юм. Гэхдээ Шмаков Петрийн сэтгэл үүнээс болж хөнгөрнө гээ юу. Сүүлийн үед би Шмаков Петртэй ер нь уулзахаа болиод байснаа одоо бүүр найз бүсгүйг нь булаав. Би ямар ч буруугүй гэдгийг түүнд ойлгуулна гэж үү?!

Шмаков Петр дэлгүүрт байгаагүй нь бөөн аз.

Гэвч Зоятай ярих юм бас л олдохгүй. Зугаалгаас ирээд сайн байна уу? гэж асуулаа. Сайн гэнэ. Ажлаасаа хоцроогүй биз?.. Үгүй, хожимдоогүй гэнэ.. Өөр юугаа асуух вэ?

Шог юм ярьдаг юм бил үү? Би инээдэмтэй шог мэднэ. Гэвч энэ нь охидод яагаад ч юм инээдэмтэй санагддаггүй. Хэний нь зарц тэнэг болох талаар маргалдсан английн хоёр сурвалжтаны тухай шогийг Зояд ярьж өглөө. Нэг лорд нь нэг пенсээр машин худалдаж авахыг, нөгөө лорд нь клуб руу очоод лордод өөрт нь лорд гэртээ байна гэж хэлэхийг зарц нартаа тушаажээ. Зарц нар нь огт татгалзсангүй тушаалыг биелүүлэхээр явсанд хоёр лорд зарц нарынхаа усан тэнэгийг мэджээ. Гэвч зарц нар шатан дээр дайралдаад эздийгээ мангуу гэлцжээ.

«Машин нэг пенсээр худалдаж ав гэххээд, орой бүх дэлгүүр хаадгийг мэддэггүй юм байна. Мангуу чинь» гэж эхний зарцыг хэлэхэд нөгөө дэх нь «Харилцуур аваад утсаар хэлчхэж чадахгүй юм шиг намайг клубт өөрөө өөр рүүгээ явуулж байдаг мангуу» гэжээ.

Инээдэмтэй байгаа биз дээ? Зоя ч инээлээ. Гэтэл нэг лорд нь нэг пенсээр, өөрөөр хэлбэл, нэг мөнгөөр машин худалдаж авах гэсэн, нөгөө нь өөрөө өөр рүүгээ зарцаа явуулсанд нь Зоя инээсэн ажээ. Энэ л түүнд инээдэмтэй санагдаж. Гэтэл хамгийн инээдтэй нь зарц нарын

яриа бөгөөд тэд үнэхээр мангуу амьтад байж шүү дээ. Гэтэл энэ нь Зоягийн ухаанд багтсангүй, тэр шогийн утгыг ойлгосонгүй. Худалдан авагчид түүний анхаарлыг сарниулаад байснаас ч болсон байж мэднэ. Би муу ярьсан ч байж магад. Зарим хүн ярихлаараа элэг авчихдаг юм. Зарим хүний ярихад залхуу хүрээд гасалмаар байдаг юм.

Англи сурвалжтаны тухай бас нэг шог ярих гэсэн чинь Зояг агуулахаас бараа ав гэж дуудав. Өнөөдөр кино үзье гэдэг байж дээ гэж түүнийг явсан хойно бодогдов. Ер нь аав ээж хоёрыг явчихлаар нөгөөдөр урьдаг хэрэг. Орой болгон кино үзэж, амралтын өдөр голын захад очиж байя.

Би гэртээ ирээд «Д» үсэгтэй нэвтэрхий толь авч «Дактилоскопия» гэсэн үгийг харав. Брокгуаз, Ефроны тольд энэ үг байсангүй. Наян жилийн өмнө ийм ухаан байсангүй. Хүмүүс ч хурууны хээг ашиглаж болно гэдгийг мэддэггүй байжээ. Маш сайн хэрэг Шинжлэх ухаан шинэ тулгар болох тусам л нээлт хийх боломж төчнөөн их байдаг.

«Дактилоскопия» гэдэг үгийг би Зөвлөлтийн их нэвтэрхий толиос олов.

«Дактилоскопия» гэдэг үгийг (грекийн дактило - хуруу, скопия - харж байна гэсэн үгнээс үүссэн) ...хурууны арьсны хээгээр хүнийг хэн болохыг тогтоох ухаан. Хүн бүрийн хуруу болгоны хээ онд ондоо байдаг бөгөөд гэр хээ насан туршид өөрчлөгддөггүй. Тэр хээгээр «нэр болон урьдын явдлаа нууж байгаад баригдсан гэмт хэрэгтнийг хэн болохыг нь тогтоож болно, гэхдээ...»

Гэхдээ тэр хүний хурууны хээг урьд нь авсан байх ёстой. Гагцхүү ингэвэл аль нэг юман дээр үлдсэнтэй нь тэр хээг сая дүйлгэж үзэж болно...

Тэгэхлээр эртний зүйл дээрээс хурууны ор илрүүлдэг юм гэхэд хэний хурууны ор гэдгийг би яаж таних билээ? Бальзак, Наполеон буюу ах дүү хоёр Гонкур сийлбэрийг барьж үзэж байсан гэхэд чухам тэдний хурууны ор гэдгийг яаж нотлох юм бэ? Бальзак, Наполеоныг амьд байхад нь хурууны хээг аваагүй шүү дээ.

Гавихгүй ихэрхэг зангаас болж төрсөн нэг хоосон санаархал маань ингэж балрав. Хэлэхэд ичмээр юм. Гэвч би одоо хүртэл өөрийгөө зэрлэг адуу сургагч буюу амьд амьтны хүрээлэнгээс зугтсан арсланг номхруулагч, эсвэл хөнгөн хөгжмийн нэрт дууч буюу бөмбөрч, хөл бөмбөгч, гимнастикч, үгүй бол хоккейчин болгон болдог

юм. Ингэж бодоход зурагт радиогоор зохих нэвтрүүлэг харахад л болох нь тэр.

Би сийлбэр цуглуулах болбол нэр төр олох гэсэндээ биш, сийлбэрийг үгүй болгохгүй гэж л цуглуулна. Сийлбэрийг зүгээр нэг цуглуулах нь надад аятайхан санагддаг. Сийлбэрт ямар ч маягласан юмгүй зүгээр л нэг дуртай. Сийлбэр бүхэн өөрийн домог үлгэр, сургаалтай (нэгийг нь би туужийнхаа эхэнд иш татсан билээ) байдаг бөгөөд эдгээр нь маш сонин, яруу сайхан байдаг юм.

Би зохиолч болох гэж байгаа болохоор эдгээр нь надад хэрэг болохсоон. Тэгээд зохиолч болно гэдэг бодол ч бас л миний их санаа юм. Игорь утасдаад Везн чамайг ир гэж байна гэж хэл өгч бодлыг минь тасалсан нь сайн боллоо...

Веэн урьдахаасаа нэг л төдгүй байгааг нурууг нь хараад мэдэв. Ийм нүдэнд хүйтэн зэвүүн нурууг би андахгүй. Манай сургуулийн тооны багш тийм өргөн, амарлингуй нуруутай. Хичээл давтаагүй байхдаа би хонх дуугарахыг сэтгэл түгшин хүлээдэг. Тэгэхдээ надаас асуух эсэхийг нурууг нь хараад яг мэддэг юм. Хичээл давтаагүй байвал заавал асууна гээч.

Веэн ширээн дээрх цаасыг хэсэг үзэж, би түүний нүдэнд хүйтэн нурууг дуугүйхэн харж зогслоо. Тэгснээ тэр суугаад хоёр минут хэртэй болсноо нүдээ жоотойлгон намайг ямар нэг болохгүй хэрэг хийчихсэн гэсэн аятай харна. Надад хийсэн хэрэг байхгүй. Үүнийгээ би сайн мэдэж байсан мөртөө үнэхээр гэмтэй юм шиг гэлбэлзэж байлаа. Би дандаа хэрэгт холбогдож байдаг юм. Холбогдох ямар ч учиргүй атлаа л холбогдчихоод байдаг юм даа. Бусад нь аргалаад гарчихад би л хоморгод нь орчихсон байдаг. Нэг хэрэгт орооцолдсон юм шиг сэтгэл надад төрлөө.

— Чи хэлсэн амандаа яагаад хүрдэггүй хүн бэ? гэж Веэн асуув.

— Ямар хэлсэн ам?

— Костяд чи хойд эцгийнх нь тухай хэлсэн байна.

— Яалаа гэж! Хойд эцэгтэй гэдгээ өөрөө над хэлэх чинь билээ.

— Түүнийг мэддэгээ чи хэлсэн байна. Яаж байгаа юм?

— Үг таарсан юм. Түүнийг өөрийг нь мэдэж байхад мэдэхгүй болж маяглаад яах юм бэ?

— Костя чамаас цохиж асуусан байна. Гэтэл чи шууд хэлчихдэг, Үүнийг надаас чамайг олж мэдэж гэж тэр ойлгосон юм. Надаас өөр үүнийг хэн ч мэдэхгүй. Тусгүй байна.

Костя надаас үг дуулах гэсэн байж дээ? Муухай амьтан юм даа. Үүнийг би хэзээ ч уучлахгүй. Тэгж ний нуугүй байсанд нь тэгэхэд хачирхсан юм. Гэтэл би түүнийг энгийн шударга залуу гэж бодож байсан. Веэний хэлдэг бас л зөв болж, түүний хэлсэн нь дандаа л зөв болж таардаг. Энэ Веэн нууц мууцтайгаа далдраасай.

— За яах вэ гэж Веэн зөөлрөнгүй хэлээд, үүнийг мартъя. Чи ч Костяд юу ч яриагүй, би ч чамд юм хэлээгүй больё. Үгүй бол чи энэ ярьснаа Костяд бас л хэлчих юм уу? гэв.

— Яалаа гэж!

— Чи амаа татаж байж үз. Тэгвэл чамд хэрэгтэй юм шүү.

Түүний үгнээс сүрдүүлсэн өнгө сонсогдож байлаа.

— Хүүхэд ч гэсэн хийснээ хариуцдаг. Эр хүн тэр тусмаа.

Үгүй гэх аргагүй. Эр хүн хийснээ хариуцалгүй яах вэ.

— За ингээд болох нь тэр ээ.

Веэн над руу гараа сунган урьдын адил эелдгээр инээмсэглэв.

Тэгээд тавиур дээрээс нэг сийлбэр авлаа. Би мэл гайхан ярих ёсгүй юмыг золтой л ам алдчихсангүй. Энэ бол Костягийн миний үзсэн, намайг үзсэнээ битгий хэлээрэй гэсэн тэр сийлбэр, ном барьсан хүүхдийн сийлбэр байлаа.

— Юуг нь гайхав?

— Гоё сийлсэн юм аа гэж би аргалав.

— Тийм ээ, маш гоё эд. Үүнийг сайн нүдэлж ав. Би эргүүлж тойруулж үзлээ.

— Сайн нүдэлж авав уу?

— Тэглээ.

Веэн хүүхдийг тавиур дээр тавиад өөр нэг том дугуй сийлбэр авав. Үүн дээр наймалж урласан байлаа. Олзоо ороон аваад хомхой махчин, зэвүүцэм хануураа шигтгэн сорохоор зэхэн байгаа бахим тэмтрүүлийн цаанаас хүйтэн, өлөн нүд нь ширтэнэ.

Веэн наймалжтай хамт надад нэг бичиг өгөв.

— Энэ хаягаар очоод зураач Краснухиныг сурагла. Наймалжийг ямар нэгэн сийлбэрээр сольё гээ. Краснухин чамд цуглуулгаа үзүүлнэ. Цуглуулгыг нь үзвэл хэрэг чинь ганц бүтэх нь тэр. Чи ном барьсан хүүхэд байгаа үгүйг мэдэх ёстой гээд Веэн ном барьсан хүүхдийн байгаа шүүгээ рүү зааж

— Ийм сийлбэр байна уу үгүй юу гэдгийг нь чи олж мэд. Ойлгов уу? гэв.

Одоо би бүгдийг сайн ойлголоо. Энэ бол хуулбар юм, Веэн эх сийлбэрийг нь эрж байгаа аж. Веэн үүнийг Краснухиныд эрж байдаг, гэтэл тэр нь Костяд байж байдаг.

— Ийм сийлбэр түүнд байвал наймалжаар сольё гэж гуй.

Өгөхгүй нь мэдээж, чи өөр юм бүү аваарай. Тун болж өгөхгүй бол нэг юм эргүүлж өгөхөөр ав. Зөвлөж, үнэлүүлж байж больё гээ, бидэнд ийм юм байдаг юм. Ойлгов уу?

— Ойлголоо.

— Хамгийн сүүлд хэлэхэд, чи Краснухины хаягийг найзаасаа, жишээлбэл Женя Ивановоос авсан болог. Миний нэрийг хэрхэвч дурсаж болохгүй. Намайг таньдаг эсэхийг асуувал нь үгүй, танихгүй гээрэй! Женя Иванов явуулсан гээд л гүйцэх нь тэр! Юун Женя Иванов бэ? гэвэл хамт сурдаг гээ. Женя Иванов бас сийлбэр цуглуулдаг юм гээрэй. Үүнийг ойлгосон биз?

— Ойлгохгүй яах вэ.

— Шүүгээ рүү очоод сийлбэрийг дахин харж сайн нүдэлж ав.

Би шүүгээ рүү очлоо. Ном барьсан хүүхдийг үзэхийн хэрэг байсангүй. Би түүнийг тэртэй тэргүй сайн тогтоож авсан юм.

Түүнийг зэрвэс хараад бусдыг ажиглаж байтал... Костягийн эмгэнээс худалдаж аваад, миний хуучны юм худалддаг газар аваачиж өгсөн нөгөө хэрмэл хөгжимчид байж байна. Везн миний гайхсаныг ажаад

— Би жинхэнэ эхийг нь олсон юм гэж хэлэв

Веэн худлаа хэлж байлаа. Хүн худал хэлэхлээр миний нүүр халах шиг болж, худал хэлж байгааг нь анддаггүй юм. Эмгэнээс бидний сул шахам авсан хэрмэл хөгжимчид яах аргагүй мөн дөө. Веэн намайг молигодож байна. Гэвч Костя ч Веэнийг хуурч байна. Ном барьсан хүүхдийн жинхэнэ эх нь Костяд байгаа юм.

Гэтэл би хэнийг ч мэхлэх хүсэл алга. Мэхлүүлэхийг ч үл хүснэ, худал хэлэхийг үл хүснэм. Хуурсаар хуурсаар худалч болж, урьд юу гэж худал хэлснээ мартаад дахин худал хэлнэ. Үүндээ ороогдохгүйн тул чухам юу гэж худал хэлснээ насан туршаа санаж явах хэрэгтэй.

Веэн урлаг судлагч, хуучны үнэт зүйлс цуглуулдаг, нүдэнд дулаахан хүн нь тэндээ л биз. Гэхдээ намайг хуурч байхын хэрэг юу вэ? Зояаг оролдож, үе мултарсан байж Норатай явж байдгийг нь, ойд миний гайхаж хоцорсон тэр битүүлэг харцыг нь аваад үз...

Сийлбэр бол урлагийн бүтээл болох нь гарцаагүй. Гэвч урлагийг худалдаж авч зарж болдог юм уу? Цуглуулга хийхдээ хуурч мэхэлж байх ёстой юм уу? Цуглуулгыг би огт өөр юм гэж бодож байсан юм.

Веэн яагаад өөрөө хаашаа ч зүглэдэггүй юм. Яагаад сийлбэрээ өөрөө олж өөрөө сольдоггүй юм бэ? Яагаад ингэж нууцгай байдалтай байдаг юм бол? Ямар учраас Костя тэгэхэд зочид буудлаас зугтаасан юм бэ? Би хэнээс ч зугтахыг хүсдэггүй. Зугтана гэдэг жигшүүртэй хэрэг. Би яагаад хийж байгаагаа аав ээжээсээ нууж хаах болж байна. Би болохгүй ажил хийж байгаа юм уу? Баримал цуглуулах нь болохгүй бүтэхгүй ажил юм гэж үү? Тэд яагаад Костягийн хойд эцгийн талаар нуугаад байна вэ? Хэрэг дээрээ би зөвхөн үүнийг л сонирхож байлаа. Би эдний бүлгээс холдож чадах нь чадна. Гэхдээ ингэхлээр Костяг эдэнтэй орхих болж байна. Гэтэл би Костяг орхихыг хүсэхгүй байна. Костя нийцгүй, ширүүн дориун боловч уг нь сайн, нэг л сэтгэлийн зовлонтой залуу.

Зураач Краснухиныд очно оо. Гэхдээ хүүхдийн сийлбэр байгаа эсэхийг мэдэх гэж очихгүй ээ. Тийм сийлбэр Краснухиныд байхгүйг би мэдэж байгаа юм чинь! Эдний хийж байгаа, хачин учрал тохиолдлоор би өөрөө ч хоморгод нь орсон тэр ажлыг лавтай мэдэж авахын тулд очно. Ер нь ингэхэд сийлбэр гэдэг чинь юу юм бэ?

Нэцкэ бол японы жижиг сийлбэр цуглуулгын зүйл гэж мэдэхээс цаашгүй. Гэхдээ ийм жигтэй хэрэг удаж байгаа болохоор бас чиг энгийн зүйл биш байх нь ээ.

Би сурсан зангаараа Брокгауз, Ефрон хоёрын тольд эхэлж үзэв. «Нэцкэ» гэсэн үг тэнд байсангүй. Би «е» үсгийг, өөрөөр хэлбэл «нэцкэ» биш «нецке» гэж харсан боловч бас байсангүй. Хувьсгалаас өмнө «t»-яг үсэг хэрэглэж байсан нь санаанд орлоо. Хуучин үсэг «t», «V», «Ө», хатуугийн тэмдэг хэрэглэсэн нь Брокгауз, Ефроны ганц сул тал бөгөөд нэг үг эрж байтал тэр нь урьд шал ондоо бичигддэг байсан байдаг. Гэвч «Б» гэж хараад олсонгүй.

Зөвлөлтийн их нэвтэрхий тольд ч энэ үг байсангүй. Хачин юм! Нэцкэ бол хуучны эд, арван долоодугаар зууны үед урласан нэцкэ ч байдаг атал нэвтэрхий толинд адаглаад дурдаа ч үгүй байдаг нь. «Япон» гэсэн тавин найман хуудас том өгүүллийг эхний нь мөрнөөс эцсийн нь мөр хүртэл нэгд нэгэнгүй уншив. Ерөнхий мэдээ, физик, газар зүйн тойм, эрэг, уул нуруу, нам доор газар, ашигт малтмал, ургамал, ан амьтад, хүн ам, аж үйлдвэр, тээвэр, хөдөө аж ахуй, гадаад худалдаа, санхүүгийн тухай ч уншлаа. Балар эртний үеэс өгсүүлээд феодализм, хэмжээгүй эрхт хааны үе, хөрөнгөтний хувьсгалын тухай уншиж, төрийн байгууламж, машин, зэвсэгт хүчин, улс төрийн нам, үйлдвэрчний эвлэлийн хөдөлгөөн, гэгээрэл, гүн ухаан, утга зохиол, урлаг, уран барилга, хөгжим, театр, кинотой нь танилцлаа. Гэвч «нэцкэ» гэдэг үгийг ер олсонгүй.

Би Брокгауз, Ефрон хоёрын толийг дахин авч Японы тухай өгүүллийг уншлаа. Бас элдэв мэдээ баримт, хүснэгт, ус зүй, дундаж халуун хүйтэн, тунадас, амьтны аймаг, ургамлын аймаг хүн амын суудаг байдал, насны ангилал, язгуур угсаа, гадаадад цагаачилж одох, гадаадаас цагаачилж ирж байгаа байдал, газар тариалан, уул уурхайн үйлдвэр, тослогт үр боловсруулах ажил, хөрөнгө, банк, даатгалын нийгэмлэг, зоосны системийн тухай, цэцгийн тарилгын тухай байлаа...

Хамгийн сүүлд «Японы урлаг» гэсэн бүлэгт Нэцкэгийн тухай ганцхан удаа дурдсан байхыг олов. Нэцкэ нь бүснээс янз бүрийн жижиг сажиг зүйлс зүүдэг тээг маягийн жижиг дүрс ажээ. Нэцкэгийн тухай тэнд өгүүлсэн юм гэвэл ердөө л энэ байлаа. Учир тайлсан юмаар бага энэ богинохон өгүүлбэрийг унших гэж би Наран улсын газар зүй, санхүүг нь хүртэл судалж орхилоо!

Япон бол эртний орон нь орон, гэхдээ тэр сийлбэрт ямар учир байна «Бүсэнд янз бүрийн жижиг сажиг зүйлсийг чагтлан зүүдэг жижиг дүрс» яагаад жижиг зүйлсийг бүсэнд, тэгээд тэр сийлбэрээр чагталдаг болох нь вэ? Урлаг нь юундаа байна. Яагаад үүнийг ингэтлээ хөөцөлдөнө вэ?

Брокгаузийн толь ЗИНТ-ийн аль алианаас эдгээр асуудлынхаа ганцад нь ч хариу олж чадсангүй, уншлагын танхим руу явлаа.

Би уншлагын танхимд, тэр мөртөө том бол дургүйг яана. Чимээгүй оргиод, хөдөлж ч болохгүй, бие бариастай, сандлаас өнхөрчихнө гэж мэд. Мухлаг, бие засах, тамхи татах газарт орж болно, гэхдээ дандаа гараад байхаар ямар хэрэг байх вэ? Хажуудаа суугаа улсыг хулгай нүдээр харахад өөрийг маань бас сэм ажиглаж байдаг. Охид бол хүнийг ажиглахаар ирээгүй дэмий суух гэж ирсэн юм шиг харна гээ!

Өөрсдөө зүгээр суух сан гэж байгаадаа тэр. Нэг сууж авахлаараа бөгс өндийлгөхийг мэддэггүй ургаа хад шиг амьтад ч бий. Гэтэл би тэгж чаддаггүй, хүмүүсийг хармаар болоод байдаг юм. Дээд сургуульд орох гэж байгаа улс л энд өнөөдөр голдуу байна. Энэ нь харваас андашгүй. Наймдугаар сарын нэгэнд элсэлтийн шалгалттай, тэгээд энд шигдэж байгаа юм. Зун өөр хүн шилбүүрдүүлээд ч энд орно гэж зангүй.

Сул сандал зөндөө байсан боловч суух гээд очихоор ширээн дээр нь ном дэвтэр тавиастай, эзэнтэй байна. Тэгж тэгж нэг сул суудал олохчоо болж номоо дэлгэн, чийдэнг асаав. Сийлбэрийн тухай хурдхан уншиж авмаар санагдаад, хажуу дахь улсаа би анхаарсангүй. Тануус бодоод үз, эхний номд л сийлбэрийн тухай бүхэл бүтэн бүлэг зураг хөрөгтэйгөө байж байна.

Нэцкэ тоо томшгүй олон ажээ. Япон хүн болгон бүсэндээ нэцкэ зүүж явдаг байж. Гэтэл Япон дэлхийн хүн ам хамгийн олонтой нэг орон шүү дээ.

Японы үндэсний хувцсанд халаас байдаггүй юм байна. Гаанс, хавтага, эмийн хайрцаг, дэвүүр, тамга, үзэг, харандаа гээд Европынхны халаасандаа хийж явдаг юмыг япон хүн бүсэндээ зүүж явдаг ажээ. Тэр бүхнийг хамт хэлхэх буюу тусгай хайрцагт хийж оосрын нэг үзүүрт бэхэлж нөгөө үзүүрийг нь нэцкэд байдаг хоёр жижиг нүхээр сүвлэн гаргадаг аж.

Тийнхүү нэцкэ нь нэг ёсны тээг, тойг, чагт юм байна. Яваандаа түүнийг чулуу, зааны яс, яст мэлхийн хуягаар, хамгийн сайныг нь нягт шар, зандан буюу интоороор дүрс гарган сийлж хийх болжээ. Аажмаар энэ нь гоёл болж, улмаар урлагийн бүтээл болжээ. Гэхдээ сийлбэр бүхэн биш л дээ, агуу их уран сийлбэрчийн гараа гаргаж, гоц ухаан зарж, гайхам үлэмж хөдөлмөрлөж байж туурвисан зүйл ингэсэн байна. Энэ бол жинхэнэ ардын эрхэм урлал мөн.

Энэ ном маань нэцкэгийн тухай биш, японы урлагийн тухай ном боловч энэ урлагийн тухай ингэж тодорхой тайлбарласан ном дайралдсан нь бүүр хачирхалтай. Энэ сийлбэрийн тухай ном англи хэл дээр байдаг аж. Би тийм нэг ном бас захиаллаа. Гэр номд гойд гоё сийлбэрийн зургийг өнгө ялган буулгажээ. Ийм ном захъя гэж санасан маань бөөн аз. Японы урлагийг алдаршуулсан хамгийн үнэтэй, ховор, тавин сийлбэр байна. Эдгээрийн дотор ном барьсан хүүхдийн сийлбэр байлаа. Костяд эх нь, Веенд хуулбар нь байхыг миний харсан Краснухинаас Веений намайг ол гэсэн тэр сийлбэр байна. Веен үүнийг хайж байгаагийн учрыг одоо л ойлголоо.

Ханцуйг нь шамласан цамц, жинс өмд өмссөн зураач Краснухин намхан мухар сандал дээр суугаад баримал барьж байлаа. Цамц өмд нь туж гөлтгөнө, шохой, нүүрс, будаг болжээ. Эргэн тойрон хана, шалан дээр зураг, баримал, гөлтгөнөн баг, тавиур жааз, багаж, вандан, зорох өнгөлөх суурь машин, утасны дамар, модны тайрдас, сонин дүрстэй модны үндэс байна. Том вандан дээр сонин сэтгүүл хөглөрнө. Яйжгай ширээн дээр лонхтой шар айраг, хайрцагтай тамхи, харилцуур байна.

Энд хүн ажилладаг нь үзтэл илт. Ажилчин хүний бахим бадируун гартай, богинохон хүзүү, ханхар том цээжтэй эр байна. Хүрэн үс нь дух руугаа хоёр хэсэг мушгиран унжжээ. Краснухин алгаараа үсээ хойш илнэ, гэтэл алга нь туж шавар болчихсон байлаа. Энэ нь надад аятайхан санагдав. Ажлын мөр хөөгөөд биеийн тамир хийх завгүй учир нэлээд махалжээ. Энэ бол огт өөр цуглуулагч байсан бөгөөд жинхэнэ урлагийн хүн ийм л байх ёстой гэж би бодож байсан юм. Цайлган байрын царай, бүлтгэрдүү цэнхэр нүдэнд нь битүүлэг, овжин байр байсангүй. Түүнийг залилж, мэхэлж чадахгүйгээ би ч ойлголоо. Ямар нэг ихэрхэг, хээнцэр Везний төлөө энэ ажилсаг зураачийг мэхлэхийг хүсэхгүй.

Урлах газар нь зэгсэн том боловч суудаг өрөө нь бага ажээ. Би өлгүүр, шүүгээ, хайрцаг шавааралдуулсан давчхан гудамжаар өнгөрөв. Гал тогооны өрөөнөөс сагамхай загас шарж байгаа үнэр ханхалж, хоёр дахь өрөөнөөс хүүхэд шуугилдах дуулдаж байлаа. Эд бол Краснухины Галя, Саша гэдэг охин хүү хоёр ажээ. Намайг ажлын өрөөнд ортол тэр хоёр орж ирэв. Галя нь долоотой, Саша нь дөрөвтэй юм байна. Саша хуруугаа хөхөж Краснухиных шиг том цэнхэр нүдээ эцэг шигээ эргэлдүүлэн бүлтийлгэж намайг ширтэнэ.

Галя ч гэсэн бас том цэнхэр нүдтэй юм. Гомдолгүй том нүдтэй төрсөн аав, хүү, охин гурав байна шүү нээрээ.

Хоёр жаал намайг харж харж вандан дээр гараад цовхчиж шуугьж, тонгочиж гарав. Краснухин тэднийг харсан ч үгүй «Аль вэ, эндээс гар» гэв. Тэд энэ үгийг нь хайхарсангүй, цовхорч шуугилдсаар байлаа. Краснухинд өөрт нь төдий л саад болохгүй байгаа бололтой. Эсвэл тэднийгээ хөөж чадахгүй тийм зөөлөн хүн юм уу.

Краснухин миний хэн болох хаанаас явааг асуусан ч үгүй. Надаас наймалжийг авч үзээд

— Юугаар солих юм бэ? гэв.

— Танд юу байна вэ?

Юу ч байж болох л байх...

Тэр бээр тавиураа хойшлуулав. Шилэн нүүртэй шүүгээн дотор олон сийлбэр байна. Вээн бол том шүүгээтэй, сийлбэр болгоноо үзэсгэлэнд байгаа юм шиг ил харагдахаар тавьсан байдаг. Энд шүүгээ нь жижиг учир сийлбэрийг шахаж хэд эгнүүлэн тавьжээ.

Сийлбэрийг харж байх зуур наймалжны оронд өгөх гэсэн сийлбэрээ эрэнгүүт Краснухин

Цуглуулах болсоор удаж байна уу? гэв.

— Үгүй ээ

— Жинхэнэ цуглуулагчидтай танил уу?

— Заримыг нь танина...

Би нэг л итгэл муутай хариулж, худал хэлж байгаадаа ичиж байлаа. Краснухин намайг гайгүй сайн харав.

Энэ зуур Галя Саша хоёр зөөлөвчит вандан дээр шуугилдаж, Краснухин бид хоёр бие биеийнхээ үгийг бараг дуулахаа болив.

— Люда, эднийг аваач! гэж Краснухин хашхирлаа.

Өрөөнд нарийхан гоолиг нуруутай, хөөрхөн боловч алжаангуй царайтай залуухан эмэгтэй орж ирлээ. Жинхэнэ уран зураач хүний гэргий л ийм байдаг байх, тэр бол мөнгө багатай, ажил ихтэй гэрийн авгай, эх хүн байлаа.

Тэр эмэгтэй хүүхдүүдээ дуудаж, цаадуул нь ч араас нь дуулгавартай дагав.

Краснухин ширээн дээр хэдэн сийлбэр тавилаа.

— Шилж байгаад ав.

Нэг ч сийлбэр сэтгэлд таарсангүй. Хун, яст мэлхий, үхэр хулгана, мэлхий, мөөгөн хүрээ, туулай байна. Краснухин лав сайн сийлбэрээ үзүүлээгүй байх, наймалж ч гэсэн өөрөө хямдхан шүү дээ. Түүнээс гадна би хүний дүрсэнд дуртай.

Энэ сийлбэрийг өөртөө сольж авах гэж байгаа юм шиг хорхой хөдлөв. Цуглуулна гэдэг бол хүний хорхой хөдөлгөдөг, аз туршсан ажил байдгийг би сая л ойлголоо.

— Хүний дүрс л надад аятайхан санагддаг юм.

Би шовгор малгайтай, хэлхгэр өмдтэй, баясгалантай, будмал улаан нүүртэй алиа салбадайн содон сийлбэрийг заалаа. Өрөөсөн хөлөө өргөж товшин бүжиглэж байгаа тэр сийлбэр баяр хөөр төрүүлэх ажээ. Ийм нэцкэг бол дуртай авмаар байлаа.

— Дүү минь, чиний сэтгэлд таарлаа гээд яах вэ? Чи тийм тэнэг биш бололтой.

— Та ном барьсан хүүхдийг мэдэхгүй биз?

Краснухин намайг цоо ширтлээ.

— Чи яаж мэддэг юм?

— Уншсан юм...

— Тэр бол алдартай сийлбэр, Мавродакийн цуглуулгын сор нь байсан юм?

— Мавродаки гэж ямар хүн бэ?

— Сийлбэр цуглуулж байгаа мөртөө Мавродакийг мэдэхгүй ээ?

— Мэдэхгүй гэж үнэнээ хэллээ.

— Мавродакийн цуглуулгатай жиших цуглуулга манай оронд байгаагүй юм.

— Та Мавродаки гэв үү?

Тийм ээ.

— Мавродаки.

— Хаана байдаг юм?

— Тэр байхгүй болсон.

Жигтэйхэн үг вэ? «Байхгүй болсон» гэдэг нь юу гэсэн үг вэ. Үхсэн юм болов уу? Тийм юм бол «үхсэн» л гэж хэлбэл барав. Гэтэл Краснухины хэлж байгаагаас үзэхэд энэ тухай ярих дургүй байгаа нь илт. Би зөвхөн:

— Цуглуулга нь яасан бэ? гэж асуув.

— Алга болсон

— Бүр үү?

— Ганц, хоёр зүйл энд тэндээс олддог юм. Ер нь цуглуулга үрэн таран болсон юм.

— Ном барьсан хүүхэд нь?

— Ер нь гарч ирээгүй...

Тэгээд хэсэг дуугүй байснаа

— Урлагийн ийм гайхамшигт туурвилыг дамлах, хөлжих зүйл болгож байдаг гэж бодлогошронгуй хэлэв.

Би л нэцкэг мөнгө олох, дамлах зүйл болгож байгаа мэт намайг харав. Намайг хэн явуулсныг гадарлаж байгаа юм биш байгаа?

— За солих гэж байна уу?

— Болих уу даа.

Веэнд сольж өгөхийн хэрэг юу байна. Золиг гэж, Краснухин намайг ямар хачин харна вэ?

— За яах вэ, зав гарвал ирж бай гээд Краснухин бадируун алгаараа сийлбэрийг ширээнээс хамж авав.

Тэгэхдээ намайг дахиад ирнэ гэдгийг яг мэдсэн юм шиг хэлэв шүү.

Мөрнөөр аялах үед зогсоолоос хөдлөх л хамгийн сайхан даа. Хөгжим нижигнэж, мөрний дээгүүр пянз тоглуулагчийн дуу алс цуурайтан, хүмүүс баясаж сэтгэл хөөрсөн байдаг. Онгоцны тавцан дээр усан цэргүүд дор дороо ажиллаж, үйлчлэгчид шатаар гүйлдэх бөгөөд тэрүүхэндээ нэг л онцлог байдаг. Цагаан хөлөг наранд гялалзаж, мөрний буудлын хөнгөхөн гоё барилга тэнгэр өөд цоройжээ. Голын зүгээс сэрүүн салхи сэвэлзэж, хөнгөн онгоц өвчүүгээрээ ус зүсэн, зурайсан цагаан хөөс татуулна. Над руу голын чийгтэй агаар сэнгэнэхэд дахин үүгээр хөвмөөр санагдав. Ингэж аялахад тийм ч залхуутай бишээ. Эрэг, зогсоол, тосгон хот, усны хэмжүүр, усны боолт, болгоомжлох тэмдэг байсхийгээд дайралдана...

Гэвч би явж чадахгүй, Зоя маань байгаа. Би хэнд түүнийг даатгаж үлдээх билээ? Лангууны дэргэд түлхэлдэхээс өөр ажилгүй амьтдад уу? Надыг дагаад Химкид ирж надтай хамт зогсоол дээр байгаа Шмаков Петрт үү?

Хоёр хөгшнийхөө төлөө би баярлаж байлаа. Хоёул тавцан дээр суучхаад аав хөөр тоглоно. Ээж ч заримдаа наадна л даа, гэхдээ аавыг байхгүй бол тоглодог юм. Тэр хоёр нэг удаа наадаж байгаад муудалцсанаасаа хойш тус тусдаа тоглодог болсон юм. Зогсоол, зогсоол дээр өргөст хэмх, улаан лооль, шинэ цөцгий, амьд загас дайралдвал тарвас, гуа авах болно.

Миний аав ээж хоёр сайн хөгшид дөө. Тэд насан туршаа хөдөлмөрлөж ирсэн улс. Аав завод дээр өнжиж, ээж хянагч учир хэвлэх үйлдвэр дээр гар бичмэл, боолт уншиж алдааг нь олдог юм. Тэд зочид ирэх, жүжиг үзэх, төрсөн өдөр тэмдэглэх, шинэ жилийн бэлэг авах зэрэг ялихгүй юманд баярлахыг яана. Гэтэл ингэж нэг их баярлаад байх юмгүй мэт санагдах боловч сайн бодоод үзвэл нээрээ ч хүн хүн өөр өөрийнхөөрөө зугаацдаг, хүн хүний сонирхол онд ондоо байдаг даа. Жишээлэхэд, орчин үеийн хамгийн лут залуу яруу найрагч, уран зохиолч, уран зураачид гэж миний боддог хүмүүс тэдний санаанд таардаггүй. Би ингэлээ гэж тэднийг буруушаахгүй, гэхдээ л хуучныг баримтлах үзэл тэдэнд бага сага байгаа юм. Тэдний сонирхол өөрсдийн амьдарч, ажиллаж байгаа ертөнцийн хүрээгээр л хязгаарлагдаж байдаг.

Тэд амьдралын түгээмэл асуудлыг шийдвэрлэдэггүй. Гэтэл хүн ямар ч гэлээ гэсэн хувийн амьдралдаа явцуурах ёсгүй.

Аав явахдаа «Хүн шиг байж үз» гэж бахь байдаг үгээ хэлнэ. Аав явахдаа дандаа «Хүн шиг байж үз» гэдэг юм. Өөр хүн бол ойлгохгүй байж магадгүй, харин аав бид хоёр бие биеэ сайн ойлгодог юм. «Хүн шиг байгаарай» гээд л болох нь тэр. Энэхүү товч «Хүн шиг байгаарай» гэдэг нь шатдаг хий, хогийн хоолойг мэдэж бай гэж үглэхээс хавьгүй илүү санагддаг юм.

Гэвч ээж намайг үнсээд тэвэрснээ нүдийг минь санаа зовонгуй ширтэхэд би эгээ л орилчихсонгүй, нээрээ шүү!

«...Ээжийн минь гар уярам зөөлөн!»

«Эцгийн минь гэр дээгүүр одод түгнэм, ээжийн минь гар уярам зөөлөн байнам» гэж хэн хэлсэн билээ? Бабелийн «Конармиод» тэгж хэлсэн байдаг юмаа!

Дахиад л хөгжим хангинаж, цөмөөрөө алчуураар даллав. Онгоц алсалж цонх нь улам жижгэрэн хүмүүс ч жижгэрлээ. Тэр гар далласаар байсан боловч нүүр царай нь танигдахгүй боллоо.

Шмаков Петр энэ үйл явдлыг огт хайхрахгүй байв. Миний аав ээж хоёр явж байгаа болохоос биш түүнийх яваагүй л дээ. Гэхдээ өөрийнхөө аав ээж хоёрыг явж байхад ч санаанд ордоггүй юм. Түүний аав ээж хоёр нь нэг бол Энэтхэгт, нэг бол Египетэд очсон байдаг. Тэд эрчим хүчнийхэн, өөрөөр хэлбэл, усан цахилгаан станцын барилгачид, тэгээд Дорнодын нэг оронд л ажиллаж байгаа юм. Аав ээжийгээ дандаа хол явж байдагт Шмаков Петр дасчхаад үүнийг бүр тоохоо байжээ. Онгоц далд ормогц надаас сурчихсан байртай:

— Чамд хэдийг орхисон бэ? гэв.

— Гучийг.

Тэр бээр дотроо тооцоолж үзээд,

— Арван таваар нь чөлөөтэй дарж болно доо гэлээ.

Би хариу дуугарсангүй. Шмаковт төсвийнхөө талаар далан булчирхайгаа тоочиж байдаг нь би биш ээ. Түүнд ямар хамаатай юм?

Зоогийн газар жаал сууя. Энд орж ер үзээгүй юм гэж Шмаков гуйв.

— Би хоол идчихсэн.

— Хоол идсэн гэсэн чинь юу гэсэн үг вэ? Би ямар чамайг үдийн хоол идье гэсэн биш, загасны шөл ууя гэсэн болохоос. Чи ер нь шүхэрлэг загасны шөл идэж үзсэн үү?

— Би цатгалан байна.

— Шүхэрлэг загасны шөл гэдэг зүгээр нэг хоолтой адилгүй нарийн хоол доо! Химкид ирчхээд шүхэрлэг загасны шөл уухгүй бол ёстой хэрэг алга аа! Маанаг л амьтан байж таарна. Их л базаавал гурав хэд биз. Хариад чамд өөрийнхөө идсэний үнийг өгөмз гайгүй.

— Чи мөн өгнө өө!!!

— Өгөхдөө л өгнө.

— Үгүй ээ.

— Ингэсэн мөртөө чи намайг харамч гээд байгаа. Өөрөө чи харамч байж!

Харамчаа дуудуулахаас муухай юм байхгүй. Гэхдээ тэр золигийн загасны шөлөөр үхсэнээ хийх юм бэ. Дэмий маяг байгаа даа!

— Больё оо, больё гэж эрс хэлээд явж усанд оръё! гэв.

— Би юм идмээр байна.

— Үхчихгүй байлгүй.

Би хөвөөн дээрээс «цахилгаан товчтой» халаастай, зангуу хатгамалласан шуудаг авлаа. Ийм дэгжин шуудагтай хархүүтэй голын хөвөөн дээр ирэхэд Зояд аятайхан байх болно. Зоогийн газар орохыг ятгаад байсан Шмаков Петрийн үгэнд орсон бол энэ мөнгийг тэртэй тэргүй хоолноос өгчих байсан. Харин би азаар авч хоцорч, Шмаковын шалаанаас сална гэдэг амаргүй. Сайн усчин буюу усны харайлтын хүн л ийм шуудагтай байна. Би усанд муугүй самардаг, харин ус руу үсэрч сурах хэрэгтэй юм. Зоятай голын эрэг дээр ирнэ. Зоя хажууд минь суучхаад ус руу үсэрч байгаа хүмүүсийг бахархан харна. Би дуугүй л байгаад байна. Дуугүй байж байж, хайхрамжгүйхэн босоод тавцан дээр гарч шунган харайна! Чүү гээд урагшаа хоёр эргэнэ. Чүү гээд гэдрэгээ хоёр эргэнэ! Зоя ам ангайн гайхна даа. Би мөнгөө золигийн загасны шөлнөөс үрэлгүй шуудаг авсан маань ямар сайн болов оо.

Хэнхэг залгах л дутаж гэнэ. Энгийн аятайхан хоол идэх хэрэгтэй. Хэт идсэнээс тулай, судас хатуурах өвчин зэрэг элдвийн өвчин даамжирдаг.

— Ээ чаваас гэж! Наад шуудгаар чинь яах юм бэ? Усчин хүний хорчгор биен дээрх содон даавуу л гэсэн үг. Загасны шөл сайхан цохисон бол. Сагамхай загас ид явж байгаа үе, яг сагамхай загас барьдаг үе.

— Хоолны мэргэжилтэн гарах нь гэж би доогтой хэлээд

— Загасны шөл уух дур нь хүрч гэнэ! Чамд хан боргоцой өгдөг юм бил үү? Хан боргоцойг шампан дарсанд хийж өгөх үү? Мөстэй кофе, хөдөөгийн сүмс авч өгөх үү дээ!

— Хөөш, чи Зоятай зугаалгад явсан байх чинь билээ? гэж Шмаков үгийг минь таслав. Ганц цочмог асуулаа даа.

— Тэгсээн.

— Өнөөх сайн найз нартайгаа яваа юу?

— Олуулаа явсан.

— Надад яагаад хэлсэнгүй вэ?

— Чамайг хаанаас олох юм бэ? Намайг өөрийг минь явъя гэсэн юм. Жаал давхиж, усанд сэлж, шорлог идэж байгаад ирсэн.

Би хэлэх гэсэн, хэлэх хэрэгтэй байсан зүйлээсээ шал ондоо юм ярьж байлаа. Зоя бид хоёр бие биедээ хайртай, дандаа уулздаг, уулзаж ч байх болно гээд л шулуухан хэлчих хэрэгтэй байсан юм. Гэвч ингэж хэлэх гэхлээр хэл эвлэж өгөхгүй, мөн ингэж хэлээд Шмаковыг гомдоож чадахгүй байв. Бид хоёр дурлалын тухай ярилцаж байгаагүй. Шмаков шоолж гарна. Гэтэл би үүнийг инээдэм болгож, тэнэг тоглоомын нь бай болгохыг хүсэхгүй байв.

Хэлэхэд ганц болдог цаг байсан боловч Шмаков Петрт би юм хэлсэнгүй. Хэл минь ээдрэв. Бүсгүйг нь булаачихсаныг мэдвэл Шмаков надтай тангараг тасарч мэднэ. Босоод л явчих хүн. Химкээс явган л туучуулчихна. Хэзээ л мөнгөтэй явдаг байлаа. Хэрвээ ингээд түүнийг явуулчихвал би хамгийн адгийн амьтан болно. Гэтэл тэр намайг бодож энд ирсэн шүү дээ.

— Шорлог нь сайхан юм уу гэж Шмаков асуув.

Шмаков мөн дөө! Шорлог л идэх сэн гэж санаж байдаг! Боллоо. Одоо түүнд юу ч ярих албагүй. Шмаков эвшээлгэв.

— Өнөөдөр Зоя дээр очиж кинонд урих юм байна.

Зүрх минь зогсох шиг болов. Би өнөөдөр Зояг кино үзье гэх гэж байсан юм. Би л түрүүлж хэлэх байсан юм. Гэтэл сая Шмаков урьтаж хэллээ. Тэгэхлээр Зояг урьтаж урих эрхтэй боллоо.

— Би ч гэсэн түүнтэй өнөөдөр кино үзэх гэж байсан юм.

— Ёстой догь, гурван билет авчхаарай.

— Гурвыг авдаг нь яаж байгаа хэрэг вэ?

— Чи мөнгөтэй газар даа.

— Бид хоёр хоёулхнаа явах гэсэн юм.

— Зоя надтай явахаас чамтай явахгүй л болов уу гэж бодож байна гэж Шмаков хэлэв.

— Өдөржин лангууны дэргэд ёрдойж зогсдог чинь юу ч бишээ. Лангууны дэргэд зогсож хэн ч дөнгөнө. Зоя надтай л явна даа

— Дүү минь хаашаа зүтгээд байна?

— Ингэж бодох үндэс над бий.

— Тэгвэл өөрөөс нь асуух уу?

— Тэгье.

Одоо бол Шмаковыг өрөвдөхөө болив. Дэндүү шаралхаад байна...

Зоя лангууныхаа араас өндөр залуутай ярьж зогсоно. Тэр залуу лангууг хэнэггүй тохойлдсон, Зоя түүнтэй ярьж инээж инээмсэглэж байгааг харахад энэ бол энгийн нэг худалдан авагч биш, ер нь худалдан авагч биш гэдэг нь илт. Зоя худалдан авагчид руу инээмсэглэж, худалдан авагчтай инээнэ гэж хол. Жигтэй юм. Нэг гоохойсон юм Зоягийн дэргэд гэртээ байгаа юм шиг тухалж, ам мэдэн бурж байгааг харахад чалчаагийн цаад чалчаа болох нь илт. Зоя бидэн тийш толгой дохисон боловч нэг л хайхрамжгүй муухан танил уруугаа дохидог шиг дохилоо.

— Хэн гэгч хайрхан бэ? гэж Шмаков Петрийг асуухад би

— Ах нь гэж бодож цөхсөнгүй авчихлаа.

— Зоя ахтай юм уу?

— Гурван ч ахтай гээч гэж би мэддэгээрээ Шмаковын зүрхийг нь үхүүлээд

— За яах вэ? гэлээ.

— Ах нь юм бол ч... ахынх нь дэргэд эвгүй юм аа...

— Миний хувьд бол адилхан, ахынх нь дэргэд ч чадна.

— Эвгүй ээ, хожим больё гэж Шмаков хэллээ.

— Чи ингэе гэж байгаа юм бол яая гэх вэ гэж би зөвшөөрлөө.

Огт санаанд оромгүй юм болов. Везн надыг тоолоо. Тасалгаа дундуур холхиж, гараа хавиран Костя, Игорь хоёрт:

— Крошийг би эндүүрсэнгүй. Алиа Салбадай Краснухинд байгаа нь ойлгомжтой. Ном барьсан хүүхэд алга уу?

— Харагдсангүй.

Костя хэнэггүй сууна.

— Дахиад шалгах боломж чамд бий. Чи тэднийд өөр сийлбэр авч оч. Холбоо тогтоох нь чухал байсан юм. Тэгээд ч тогтоолоо.

Краснухинд сийлбэрийн хэрэг юу байна? Краснухин зураач болохоос ямар цуглуулагч биш, бүтээж хийх ёстой болохоос цуглуулах учиргүй хүн.

— Тэр сайн зурдаг хүн үү? гэсэнд Везн ярвайн

— Авьяасгүй ч хүн биш, гэхдээ этгээд маяг гаргадаг юм. Би түүний тухай бичсэн юм. Заримыг хүндэтгэх нь зүй боловч борлоогүй урлаг бол урлаг биш ээ. Авьяас билэг алдарших шаардлагатай, тэгэхгүй бол доройтдог.

— Нас барсныхаа дараа алдаршсан зураачид байхгүй гэж үү? гэж намайг үг сөрөхөд,

— Тийм зураач байхгүй! гэж Везн эрс хэлээд,

— Нас барсны дараа алдаршиж болно. Гэвч амьдаадаа огт алдар нэр олоогүй бол үхсэн хойноо юу ч олохгүй гэв.

— Гэхдээ тэр бас ч гэж залуувтар хүн билээ.

— Юу гэх юм бэ дээ... Фронтоос ирээд сургууль төгссөн хүн... Гэхдээ бид түүнийг зураачийн нь хувьд сонирхож байгаа юм биш ээ. Бидэнд түүний нэцкэ л сонин байна. Тэр цуглуулагч биш, бид цуглуулагч. Цуглуулга бүр эрин цагийг эзэлж агуу их зураач бүр эрин цагийг эзэлдэг. Хэрвээ бид манай оронд байгаа нэгдүгээр Мива, Язамицу, Томатад, Мазанаогийн бүтээлийг цөмийг нь цуглуулж чадвал дэлхийд дээгүүр орох цуглуулгатай болно.

— Краснухин ч цуглуулга хийж байгаа юм билүү гэж миний тааварлахад Везн зэвүүрхэж:

— Краснухин хоёрын хооронд цуглуулж байгаа юм. Гэтэл цуглуулга бол миний нэг насны ажил. Хэчнээн эрхэм дээд зорилго тавьсан байх тусам хүн тэмцэлд ямар ч арга хэрэглэх их эрхтэй болдог.

Нэг бол Краснухин миний цуглуулгыг эзэмшинэ. Үгүй бол би Краснухин, бусад хүний цуглуулгыг эзэмшинэ гэж Веэн хорсолтой хэлснээ

— Ертөнцөд хамгийн лут цуглуулга хийнэ. ёс суртахууны эрх миний талд байна. Чи юу гэж бодож байна? гэж гэнэт надаас асуухад нь,

— Үүний учрыг би сайн олдоггүй юм гэж би булзаарууллаа.

— Учрыг нь олох болно! Номын санд очиж ном зохиол уншсан чинь над сайхан санагдаж байна. Энэ бол ажилд нухацтай хандаж байгаагийн тэмдэг.

Энэ үгийг Игорь, Костя хоёрт зориулж хэлсэн боловч цаадуул нь өөрсдөд нь огт хамаагүй юм шиг царай гаргав.

— Гэвч над байгаа зүйлийг ганц ч номын сангаас олохгүй. Сийлбэрийн тухай бүх хэлээр гарсан ном бий. Тийм ч олон ном гараагүй. Дорвитой судалгаа эзнээ хүлээж байна.

Чухамхүү Веэн л өөрөө нэцкэгийн тухай дорвитой бүтээл бичнэ гэсэн байрын аялгуугаар түүнийг хэллээ.

Веэн, Игорь, Костя гуравт би мундаг хүндтэй болов. Нэцкэгийн тухай хэдэн ном үзсэн л гэж тэр. Хийж байгаа зүйлтэйгээ танилцах нь зүйн хэрэг биз дээ. Гэвч энэ нь их сэтгэгдэл төрүүлж миний нэр хүндийг цаглашгүй өсгөв. Би тэдний нөхөрлөлийн бүрэн эрхт гишүүн боллоо. Миний сорилтын хугацаа дууслаа.

Костя дуугарсангүй. Хойд эцгийнхээ тухай ярьснаа Веэнд хэлснээс нь хойш би түүнээс хөндий байх болсон юм. Тэр лав үүнийг мэдчихээд дуугүй байгаа байх.

Игорь доог хийж өнгөрөөх гэж оролдоод үзэв. Крош сүрхий эр, шинжилгээний ажилд авьяастай энэ ээ тэр ээ гэхэд нь түүний шоглоомыг хэн ч дэмжсэнгүй тул амаа хамхих нь тэр.

Веэн шүүгээнээс сийлбэр авч,

— Үүнийг аваад Краснухинд оч гэлээ.

Энэ бол хулсны дүрстэй том товч байлаа. Хулс хагдран хариугүй унах гэж байгаа нь илт. Юугаар ийм бодол төрүүлж байгааг хэлж мэдэхгүй юм. Саяхан амьд, цэх байсан гол нь эцсийн удаа навтайсныг харуулсан гойд зураглал, үений нь байрлал ингэж бодогдуулж байх шиг байна. Сийлбэр гэдэг гайхамшигтай урлал юм. Мундаг сийлбэрчид эдгээрийг туурвижээ!

— Энэ ч овоо юм даа! гэж Везн сийлбэрийг сонирхонгоо хэлээд Краснухин заавал мэдэж байгаа. Нэгдүгээр Мивагийн сийлбэрээр л сольдог юм шүү. Тэр юу байгаагаа үзүүлэг, тэгээд бид түүний цуглуулгыг мэдчихье... Ингэхэд Крош чи мөнгөөр ямар байна вэ?

— Мөнгө бий.

— Чи одоо ганцаараа байгаа шүү дээ. Мөнгөөр суувал ирээрэй. Таваг шөл чамд хэдийд ч олдоно гэж Везн инээмсэглэн хэлэв. Костя, Игорь бид гурав Везнийхээс гарлаа.

— Та нар хаачих нь вэ. Би л хувьд үсчинд очлоо.

— Ямар?

— Олигтойхон засдагаар нь төв үсчин явна гэж тэр хэлээд миний толгойг харснаа чамд ч гэсэн илүүдэхгүй л болж гэв.

Илүүдэхгүй гэдгийг би ч өөрөө мэдэж байлаа. Гэвч ямар журам горимтойг нь мэдэхгүй болохоор тийш очихоос зүрхшээгээд байсан юм. Игорьтой бол болно. Игорь журам горим анднаа гэж байхгүй.

— Би Павел Ивановичаар үсээ засуулна. Би бүх үсчнийг танина. Тэд ч намайг мэднэ. Чамайг нэг мэргэжсэн хүнд суулгаж өгье. Ганц хоёр мөнгө илүү чулуудчихаарай.

Тохиролцсоноороо уулзъя гэж Костяг хэлэхэд Игорь

— Гүг-гүү гэв.

Юу гэж тохиролцсоныг би асуусангүй. Костягаас урьтаж ам нээхийг хүсэхгүй байлаа. Гүг-гүү гэдгийн нь тухайд гэвэл Игорь баяртай гэж байгаа царай нь тэр.

Игорь тэндхийн бүх үсчнийг таньдаг байж магадгүй юм. Харин бүх үсчин түүнийг таньдаг нь юу л бол. Энэ бол манай гудамжны өнцөгт байдагтай огт адилгүй үсчний газар. Хана нь нэлэнхийдээ шил толь болсон, сандал нь нүсэр том бөгөөд эргэдэг, чанартай үнэтэй ус ханхалсан, үсчид нь хижээл, эрдэмтэд шиг ихэмсэг бөгөөд тэд хоорондоо хааяа нэг шивнэн ганц нэг үг солихоос ондоо огт дуу шуугүй ажиллах ажээ.

Миний үсийг засаж байгаа үсчин, учир нь олдохгүй байрын ширүүн хүн тул би хөдлөхөөсөө ч эмээж байв. Тэр надаас нэг юм асуусан боловч би юу гэсний нь ойлгосонгүй. Дахиж асуухаасаа халшрав. Яаж л засвал засаг, яаж засахаа надаар заалгахааргүй мэдэж байгаа.

Би «ай даа» гэж тодорхойгүй хэллээ.

Тэр бээр үсийг минь манай тэндхийн үсчнээс хамаагүй удаан засав.

Гэдийж байгаад л харах юм, тэгснээ хайчлаад л гарах юм, энд тэнд гарч байгаад харах юм, тэгснээ хайчлах юм, тэгснээ харах юм. Тэгээд толгойг минь угааж цахилгаанаар хатаагаад үнэртэй ус хийж боолоо.

Тэгээд сахлын хэрэгсэл авчирлаа. Би сахлаа хусуулж ер үзээгүй юм. Шанаанд минь жаахан боловч зэгсэн эгдүүтэй хууз ухаантай юм байдаг. Чухам үүнээс болоод охид надад хөнгөн ханддаг байж магад гэж заримдаа санагддаг юм. Жижиг, янзын батга бас байдаг юм. Насанд хүрэхлээр яваандаа алга болно гэж аав хэлдэг.

Манай тэндэх үсчний газар бол сахлаа хусуулах уу гэж асуудаг юм. Гэтэл энд үсчин юу ч асуусангүй хутга аваад л хусчихлаа. Дараа нь жин тавьж, иллэг хийж, дахиад л жин тавьснаа үнэртэй усаар шүршээд алчуураар сэвэн нүүр амыг минь арчиж, өөр юу хийх вэ гэж ширтэж байлаа. Өөр хийх юмгүй болжээ.

Би толинд харлаа. Аргагүй гоё засжээ. Анх удаа сахал хуссан болохоор чамархай шанаа, эрүүний арьс жигтэйхэн цагаан, бусад газраа бол бор, хууз байсан газар наранд түлэгдсэнгүй, ялгаран харагдаж байлаа. Петр хааны ноёд баяд сахлыг нь авчихлаар нүүрээ нүцгэрчихлээ гэж гомдол тавьж байсны нь учрыг сая ойлгов.

Би кассад нэг рубль наян копейк төлөв. Гэтэл манай гудамжны өнцөгт хорин копейк л төлдөг билээ. Гэхдээ яах вэ, ямар өдөр болгон төв үсчинд очих биш. Өөр юманд л санаа зовж байлаа. Үсчинд тавин мөнгө яаж сэм атгуулна аа! Ёстой ичгэвтэр, шившигтэй юм чинь энэ дээ. Үсчин зэвүүцвэл яана. Илүү шан харамж авна гэдэг муухай шүү дээ.

Ичиж, ичиж, улайж улайж би талонтой хамт тавьтын мөнгө өгчихлөө. Эрдэмтэнтэй төстэй үсчин маань түүнийг хээвнэг аваад цагаан халаадныхаа халаас руу гулсуулчхав.

— Одоо л нэг хүн төрхтэй болж. Чи атгуулсан уу? гэж Игорь асуулаа.

— Тэгсээн. Ганц эвгүй юм аа.

— Се ля ви² гэж Игорь номчирхоод

— Аяга Кофе уучихвал илүүдэхгүй биз. Кофе ууж болох газар ганц энд л байна.

Тэгээд төв үсчний дэргэдэх цайны газрыг заав.

Би энд орж үзээгүй, гэвч яруу найрагч, уран зураач, жүжигчдийг цуглуулдаг газар гэж мэдэж байлаа.

Костя биднийг цайны газар хүлээж байлаа. Би энд байгаа улсыг харахаараа нэг, болсон боловч нэг ч нэртэй жүжигчин, яруу найрагч буюу зохиолчийг олж үзсэнгүй. Биднийг ширээнд суумагц Игорь:

— Веэн их юм мэддэг боловч адармаатай хүн... Хэдүүл аминчилж ярих шив гээд эхлээд намайг жоготой гэгч нь харлаа.

— Тэгэлгүй яах вэ.

Костя дуугүй байгаагаас үзэхэд энэ яриа нь санамсаргүй зүйл биш намайг зориуд энд авчирсныг би ойлголоо. За яах вэ тэгье, сонин байна.

— Чи, бидний нөхөр, тэгэхлээр чамд нэг юм сануулалгүй болохгүй нь. Веэн ариун нандин бодлоор сийлбэрийг цуглуулж байгаа юм биш. Энэ бол түүний ашиг хонжоо харсан зүйл. Тэгээд ч докторын зэрэг авах шинжилгээ бичиж байгаа юм.

— Ингэлээ гээд юу гэж?

— Веэн бол наймаачин хүн. Бид ч гэсэн бас жаал зугаа ашиг харж л яваа улс. Үүнээс цаашгүй. Гэтэл чи мундаг амьтан болж байна. Гэнэхэн хүнтэй ажиллах нь Веэнд мэдээж ашигтай байгаа.

— Би та нарын үнийг буулгаад байна уу? гэхэд минь Игорь ярвайж:

— Ингэж бүдүүлэг хэлэх хэрэг юун?

Чи дэндүү хэнхэглэж, жигтэйхэн гэнэн аашилж байна. ... Номын сан ман, ном мом чамд ямар хэрэгтэй юм. Шангаа хүртчихээд гэлдэрч байвал болоо!

— Надад шан хэрэггүй бол яах вэ?

— Тэгвэл энэ хэрэгт яах гэж оролцсон юм.

— Ийм л болчихлоо.

— Ингэж амар болдоггүй юм. Веэнтэй анх чиний ярилцаж байсныг сайн санаж байна. Чамд мөнгө өгнө гэж хэлж байсан. Хэлсэн биз?

— Тийм болог.

— Чи юунд оролцох гэж байгаагаа мэдсэн үү?

— Сийлбэрийг нь сонирхсон байвал яах вэ?

— Энэ бол чиний хувийн хэрэг. Гэвч Веэнтэй харилцахдаа бидний нийтийн эрх ашгийг бодож хайрла.

— Чи далайлгаад дэмий.

— Чамайг айлгасан юм алга, хэмээн Игорь намайг харалгүй сунжруулан хэлээд

— Гэвч чамайг урам хугараасай гэж бид бодохгүй байна гэв.

— Оёо, яасан уярмаар юм бэ?

— Чамтай хэл амаа олоход хэцүү, гэвч тэвчиж үзэхээс биш.

Краснухин гэж хэн бэ? Краснухин авьяаслаг зураач. Би түүний бүтээсэн болгоныг сайн гэхгүй. Гэвч тэр дэвшилт зураач гэдэг нь яах аргагүй үнэн.

Инээд минь хүрэв. Краснухины бүтээлийн юуг нь Игорь үнэлэхгүй байгаа юм бол? Элэг хөшөөчих нь!

— Краснухин ингэлээ гээд нэг их хотойхгүй байлгүй гэж бодож байна.

— Яалаа гэнэ ээ? гэж Игорь нүдээ жоотойлгов.

— Бүтээлийг нь чиний үнэлэхгүй байгаад гэж би өглөө.

— Наадмаа орхиё.

— За, за цааш нь сажлаач!

— Тэгэхлээр, Веэн Краснухиныг ямар нэг үзэл бодлоос болж төнхөж байгаа юм биш нэр алдарт нь ашигтай учраас л төнхөж байгаа юм. Веэн бол дээгүүр сэвдэг хүн, сийлбэр, зураг, наймаанаас бусад нь түүнд сохор зоосны үнэгүй. Иймээс өөрөө Краснухиныд очихгүй, чамайг явуулаад байгаа юм. Гэтэл чи үүнийг их юм болгож, эргэцүүлэн бодож, судалж, тэр ч байтугай шан авахаас татгалзаж байна. Тэгвэл энэ бүхний учрыг ойлгохдоо чи хүн төрөлхтөнд итгэхээ болино. Чамайг хүн төрөлхтөнд итгэл алдаасай гэж бид хүсэхгүй байна.

— Тийм юм бол тануус Веэнд яах гэж тусалж байгаа юм бэ?

— Хачин амьтан бэ? Энэ бол зүй ёсны шударга ажил, хүн бүр чадахын хирээр, заримдаа тийм ч таатай биш аргаар мөнгө олдог гээд

Игорь хоол зөөгч рүү дохиж

— Энэ хийж байгаа нь сэтгэлд нь таардаг юм биз, надад бол үгүй. Би хүнд кофе зөөж өгч байхыг хүсдэггүй. Кофе хүнээр авчруулж байхыг хүсдэг.

— Ухайс, чи хүнээр зөөлгөх дуртай юм уу?

— Тийм ээ, хүнээр зөөлгөх дуртай.

— Нийгэмд хоол зөөгч ч гэсэн хэрэгтэй. Ажил болгон сайхан.

— Крош, хий мөрөөдлөө орхи! Хоосон мөрөөдлийн зуун өнгөрсөн. Бэрх өдөр ирлээ. Хүн мөнгө олохын төлөө ажилладаг. Би шударгаар олж байгаа хөлсийг хэлж байна.

— Эмгэнээс жинхэнэ сийлбэрийг дуураймлын үнэ өгч авах нь шударга хэрэг үү?

— Эмгэн юу ч вэ! Үүнгүйгээр цуглуулга хийнэ гэж ярихгүй, Веэн үүнийг чамд зэгсэн дэлгэрэнгүй тайлбарласан. Цуглуулагч хүн хожихдоо хожиж, алдахдаа алддаг.

— Зураач Краснухиныг мэхлэх нь шударга явдал уу?

Игорь ярвайж,

— Тэгж хялбарчлах хэрэг юу вэ! Зураач Краснухиныг залилсан хүн байхгүй, түүнийг миний нөхөд хүндэлдэг. Түүнийг мэхлүүлэх ч үгүй. Краснухин цуглуулагч гэдэг нь өөр хэрэг. Энд өөр хүрээний хууль үйлчилж байна. Краснухиныг Веэнээс сийлбэр доор таньдаг гэж бодож байна уу? Бүү сэтгэл зов! Тэр хууртахгүй. Аль аль талдаа ашигтай наймаа болно.

— Нэр хөөцөлдөгч Веэн Краснухиныг шулж байгаа нь шударга хэрэг үү?

— Тэр над ямар хамаатай юм! Өнөөдөр Краснухиныг Веэн дөнгөж, маргааш Веэнийг Краснухин дөнгөнө. Өнөөдөр нэг хэсгийн нь зөв, маргааш нөгөөдүүлийнх нь зөв. Тэдний маргаан заргаан надад пад алга. Хэлбэрдэгчид, хуулбарлагчид над хэрэг алга. Дуртай бол гэдсэндээ хөлөө хийлцэж л байг! Надад мөнгө хэрэгтэй. Тэгээд ч би шударгаар мөнгө олж байна.

— Өө, чи шил милхэн цуглуулж, ах гуай нар чамд илжиг шиг зүтгэж байх юм биз дээ. Энэ хоол зөөгч цааш нааш харайлгаж, чи алхайж хэвтэх юм биз дээ?

Үүнээс илүү ажилд толгой нь хүрэхгүй бол яана гэх вэ дээ.

— Хэний нь толгой илүүг бүү мэд дээ?

— Сэтгэл мэдрэлийн л нэг өвчин... гэж Игорь бувтнаснаа

— Чи юунд орилоод байна вэ? гэв
— Орилсон юм алга. Би ярьж байна. Мөнгөнөөс гадна ёс зарчим гэж бий.
— Бураад бай, бураад бай!... гэж Игорь үрчийснээ
— Зарчим гэнэ. Хаана чи түүнийг үзэв? Хаана түүнтэй дайралдав. Энэ бол мөхсөн ай. Үүнийг чинь аль язгуурын устгасан юм. Хүн бүр чадахынхаа хэрээр хувиа борлуулж явдаг. Чи дэндүү үзэл сурталч болчхож. Яагаад энэ вэ? За яах вэ. Чамд Веэнтэй бидний ажиллаж байгаа болзлоор ажиллах хүсэл байна уу?
— Би зальхай Веэнтэй ерөөс ажиллах хүсэл алга гээд халааснаасаа хулсны сийлбэрийг гаргаж ширээн дээр тавиад
— Үүнийг Веэнд буцааж өгч болно. Цаашид түүнтэй ажиллахыг хүсэхгүй байна. Танууст сайхан байгаа бол өөрсдөө цаашид ингээд л бай гэв.
Энэ болтол ам ангайгаагүй Костя сийлбэр рүү дохиж
— Наадахаа далд хий.
— Энэ надад хэрэггүй
— Веэн чамд өгсөн, чи өөрөө эргүүлж өг. Чиний өмнөөс хэн гүйж байдаг юм.
Энэ ч зөв юм. Би сийлбэрийг буцааж хармаалав.
— Чи Веэнд юу гэх юм? гэж Костяг асуухад нь
— Би ямар түүнд хөлслөгдсөн юм уу? гэлээ.
— Чи түүний ажлыг мэдэж байна. Түүний мөнгөөр ууж, зугаалсан биш үү... Зүгээр ингээд хаячихдаггүй байх аа!
— Би боолчлогдоо юу! Хамжлагат ёсыг зуун жилийн өмнө халсан шүү! Костя намайг хүйтэн харцаараа ширтэв.
— Игорь бид хоёрыг Веэнтэй ажиллахаа больсон цагт л чи болих болно доо.
— Хэрэгтэй гэж үзсэн цагтаа л болино.
— Хожим амаа бариузай!
— Өөр л хүнийг айлган сүрдүүлж үз. Чиний боксчин тэндээ л биз. Үүнээс чинь нэг их айгаад байх юм алга. Нударгаар юм олж долоохгүй. Тэр тусмаа надаас
— Боль хүүхдүүд ээ гэж Игорь эвлэрүүлэнгүй хэллээ. Костя занасан хүйтэн харцаа надаас салгасангүй. Би түүнээс огтхон ч, хумсын чинээхэн ч айсангүй. Тэр боксчин, гэвч энд ямар дэвжээ байгаа биш. Энд дүрэм бусаар зодолдоно. Дүрэм бусаар бол би ч мөчөөгөө

өгөхгүй. Тэгээд ч Костя зодоон үүсгэнэ гэж бодохгүй байна. Бид хоёр сайхан нөхөрлөсөн шүү дээ! Энэ нөхдийн дунд түүнийг орхиж байгаа минь л тоогүй. Би тайвнаар:

— Миний дургүй зүйлийг та нар албаар хийлгэж дөнгөхгүй ээ.

— Энэ яриа бидний дунд үлдэнэ гэж чи ам өгсөн шүү дээ гэж

Игорь сануулав.

— Бүү санаа зов! Зарим амьтантай адил хүнтэй ярьснаа бусдад тоочиж байдаг нь би биш! гээд Костя руу учиртай харав.

— Намайг юу гэж нэг их хараад байгаа юм? гэж тэр асуудаг байна.

— Харж болдоггүй юм уу?

— «Зарим амьтан» гэдэг чинь хэн бэ?

— «Зарим амьтан» гэдгээ тэр «зарим амьтан» өөрснөө мэдэж байгаа биз.

— Чи хэнийг хэлээд байна аа?

— Чи бид хоёр чиний хойд эцгийн тухай ярьсан. Чи түүнийг Веэнд яах гэж хэлсэн юм бэ? гэхэд минь Костя намайг гайхан харав.

— Бид хоёр аминчилж ярьсан. Гэтэл чи Веэнд хэлсэн байсан, яаж байгаа нь тэр вэ?

— Би түүнд юу ч хэлээгүй. Чиний хойд эцэгтэйг Крош мэдэж байна уу гэж Веэн надаас асуусан, би мэдэх юм билээ гэсэн

— Веэн над хэлэхдээ бол би чамд хойд эцгийн чинь тухай ам алдсан юм шиг хэлсэн. Танай кампанид үг болгоныг тэмээ гэхэд ямаа, үхэр гэхэд хонь болгож байх юм. Би ингэж сураагүй, сурахыг ч хүсэхгүй байна. Та нартай толгой эргэж гүйцэх юм байна, тэр тэгсэн гэх, энэ ингэсэн гэх! За яах вэ тэгж л байг. Ингээд л больё! Харин ганцхан юм асуумаар байна. Тануус Мавродаки гэдэг нэрийг мэдэх үү?

— Мавродаки! гэж Игорь давтсанаа

— Грек нэр юм уу даа, үгүй ээ, мэдэхгүй юм. Ямар хүн бэ?

— Чи? гэж би Костягаас асууснаа амаа хамхив...

Костя намайг хачин харахад нь би бүр айчихлаа.

— Чи энэ нэрийг яаж мэддэг юм? гэж надаас бөглүү дуугаар асуулаа.

— Дуулсан юм.

— Тэгвэл март, Үүрд март! хэзээ хаана ч бүү дурс. Ойлгов уу? гэж Костя хэллээ.

Веэнийд очиж, хулсны сийлбэрийг эргүүлж өгөх гэж хамгийн түрүүнд бодогдов. Гэвч түүнд сийлбэрийг нь буцааж өгнө гэдэг энэхүү оньсого мэт хэргийн нууцыг тайлж чадах ганц хүн болох Краснухиныд очих замгүй болно гэсэн үг.

Костя Мавродакийн тухай дуулаад юунд цонхийв? Яагаад энэ нэрийг битгий хэл гэв? Мавродакийн цуглуулгын сор нь байсан сийлбэр ном барьсан хүүхэд яагаад түүнд байна вэ? Үүнийг тэр яагаад Веэнээс нууна вэ?

Бодох хэрэгтэй. Маргааш л шийдье. Тэгээд ч орой болчихлоо, Зояг кинонд амжиж урих хэрэгтэй.

Би «Ударникт» очиж билет авав. Билет үзэхлээрээ охид ухаан тавьдгийг би олонтоо ажигласан юм. Билетгүй болохоор билет олдох ч юм уу, үгүй ч юм уу, хэдэн цагийнх байх юм, ямар кино тааралдах юм бэ бүү мэд. Хаана суух болох ч мэдэгдэхгүй, бүх юм тодорхойгүй, бүрхэг бүдэг байдаг. Билет олж атгасан цагт юм бүхэн тов тодорхой ив илэрхий болно.

Нээрээ ч билет үзчихээд Зоя:

- Намайг хаалган дээр хүлээж бай гэв.
- Долоо гучийн билет шүү гэж би сануулав.
- Амжина.

Би дэлгүүрийн хаалганы дэргэд хөлхөх зуураа Шмаков Петр буюу Зоягийн ах горзгорыг булан тойроод гараад ирэх бий гэж яс хавтайн хоёр тийш нүд тавьж байлаа.

Дэлгүүрээс худалдагч бүсгүйчүүд уван цуван гарсаар Зоя ч гарч ирлээ. Миний цаг долоо арван найм болж байв. Метро хүртэл гүйгээд тэндээс кино театр хүртэл гүйнэ гэдэг гарцаагүй хоцорно гэсэн үг. Бидний аз дайрахад дэлгүүрийн дэргэд такси зогсож, бид ч ухасхийгээд орчхов. Гэрэл унтарч байхад бид танхимд ам мөлтөс орлоо.

Эрүүлч нохойн тухай кино байлаа. Гэмт хэрэгтнийг барьж сургаж байгаа тухай ажээ. Гэмт хэрэгтнийг барих нь зөв боловч гэмгүй хүн рүү ч турхирч мэднэ. Бүх юм нохой хөтлөгчөөс шалтгаална. Хүний хоолой тас мэр гэвэл ядаж цөхөх юмгүй тас хазна. Ер нь нөхөрлөшгүй

амьтан. Чеховын Каштанка юм уу, Муму юм уу, Цагаан соёо юм уу, эд бол шал өөр хэрэг. Тийм нохой бол ёстой хүний нөхөд.

Дээд дарга нарыг хараад нохой бас айж тэвддэг гэж дэмий хошигносон, ер нь тиймэрхүү янзаар хүн нохой хоёрыг жишиж адилтгасан нь миний санаанд таарсангүй. Нохойны амьдралаас хүний амьдралыг дүгнэж болох юм шиг ингэдэг нь юу вэ.

Гэтэл Зоя догдолж, инээж, миний хэлсэн учир шалтгааныг ойлгохгүй байлаа.

— Чи юу ярьж байгаа юм. Ийм сайн нохой байхад! Битгий санаанаасаа зохиогоод бай.

Гэвч кино үзсэний дараа үүнийг ярилцсан юм. Кино гарч байх үеэр бол би яаж Зоягийн гарыг барьдаг билээ гэж л бодож суув. Зоя дэлгэцийг нүд салгалгүй ширтэх бөгөөд түүний ялдам царайг, дух руу нь унжсан бужгар үсийг хажуугаас нь харж байлаа. Ёстой сэтгэл татам охин юм. Мөр нь хажууг минь шүргэх боловч гарыг нь бариад авч нэг л болохгүй байлаа. Хажуугийн хашлага дээр алга нь байсан бол барихад юухан байх вэ. Гэтэл түшлэг дээр тохойгоо тавьсан байлаа.

Азаар киноны хамгийн эгзэгтэй үе болж, гэмт этгээд нохойг буудлаа. Тэр нохойг алчих нь гэж Зоя айн шивнээд өөрөө гарыг минь шүүрч авав. Би кино дуустал гарыг нь тавьсангүй. Энэ бол киноны ганц дөмөг хэсэг бөгөөд яг дуусах гэж байхад болов.

Бид гудамжинд гараад би киног шүүмжилж эхэллээ. Зоя зөвшөөрсөнгүй, тэр ч байтугай надад уурлав. Зояг кинонд урьчхаад тэнэглэж, түүнийг баярлуулах гэсэн мөртөө өөрөө урам дээр нь ус асгалаа.

Ийм илжиг шиг амьтан байх гэж би! Маанаг чамайг! Киног магтахгүй гэлээ ч муулахгүй байж болсонгүй юу?

Бороо шиврэв. Зоя таксигаар явъя гэлээ. Би түүнийг Таганкад, нөхдийн гудамжинд хүргэж өгөв.

— Маргааш кинонд явах уу? гэж би салахдаа асуув.

— Өдөр болгон кинонд явах гэж үү? Гэрийнхэн маань юу гэх юм бэ? гээд Зоя инээмсэглэв.

— Тэгвэл бүтэн сайн өдөр Химки рүү явъя.

— Бүтэн сайнд би ажилтай.

Нэг дэхэд

— Нэг дэх болтол хаа ч байсан юм гээд Зоя дахиад яагаад ч юм инээд алдав.

Би Краснухиныг ширээн дээр ном бичиж суухад нь орж очив. Тэр их л ажилтай байртай нэг юм бичиж байна. Харанхуй гудам нь аанай л зай муутай хэвээрээ агаад шарсан сагамхай загасны үнэр бус, дөнгөж хөөрүүлсэн сүүний үнэр ханхалж байлаа. Галя, Саша хоёр харагдахгүй, тэдний дуу ч сонсогдохгүй байлаа. Лав ээжтэйгээ нэг тийшээ явсан байхаа.

Краснухин хулсыг үзээд

— Сайхан сийлбэр байна. Үүнтэй үнэ дүйх юм оронд нь өгч чадах болов уу даа. Энэ Соно л магадгүй...

Тэр бээр шүүгээнээс мод гэхэд мод биш, эвэр гэхэд эвэр биш том дугуй хавтгай сийлбэр авав.

Түүн дээр хөнгөхөн сиймхий, шунган нисэх соно ухаж хийжээ.

— Чиний хулсыг хийсэн сийлбэрчийнх. Юм үнэлдэг газар үнэлүүлж байж больё.

— Намайг аваад алга болчихно гэж айхгүй байна уу?

— Чи хулгайч юм уу?

— Та намайг танихгүй шүү дээ!

Краснухин дахиад бичиж эхлэв. Ямар нэг яаралтай юм бичиж байгаа бөгөөд би түүнд саад болсон нь илт.

— Би танд удаан саад болохгүй. Та дөчин хэдэн оны шувтаргаар Мавродакийн цуглуулга алга болсон гэж эртээд хэлсэн. Тэр хаачсан юм бэ? Энэ нь дайны дараа болсон байна. Дайнаар ч олон юм алга болсон л доо, гэтэл дараа нь... Хаашаа алга болдог байна? Мавродаки өөрөө яасан юм бол?

— Мавродаки дөчин найман онд амиа хорлосон юм. Чи хэдэн онд төрсөн бэ?

— Дөчин найман онд.

— Тэр дөчин найман онд чинь л үрэгдсэн юм.

— Та таньдаг байсан уу?

— Краснухин духаа атируулан бичих зуураа

— Тэр манай профессор байсан юм.

— Энэ бүхэн огт санамсаргүй болсон юм... Сонинд нэг өгүүлэл гарч дараа нь институт дээр хурал болсон юм...

— Мавродаки сайхан санаатай, их юм мэддэг боловч дорой хүн байсан. Гэтэл ширүүн үе байлаа гээд Краснухин босов.

— За явж үз! Зав алга... гээд бичиг цаасаа зааж,

— Яасан юм ийсэн юм гэсээр байтал болохоо байлаа, за явж үз!
гэв.

— Ганцхан юм асууя. Мавродакийн тухай өгүүлэл ямар сонинд гарсан бэ? гэж яаран асуулаа.

Краснухин дөчин найман онд гарч байсан, одоо гарахаа больсон сонины нэр надад хэлэв.

Сонины ямар дугаарт тэр өгүүлэл гарсныг асуух гэлээ. Гэвч Краснухин хаалга руу намайг элэгсэг боловч шуудхан түлхэв.

Би Везнийд орохдоо баахан ширвээдэв. Ичмээр юм. Би хулчгар амьтан биш боловч хүний нүүрэн дээр зальхай амьтан гэдгийг нь хэлэхэд эвгүй юм. Даан ялангуяа Везн шиг намбатай ноёнд хэлэхэд тэр. Тэр тусмаа өөрт минь талтай, ам сайтай, өөрийг минь магтдаг бол. Хүн өөрийг минь магтаж, сайн хэлж байхад өөдөөс нь зальхай амьтан гэж байдаг.

Везн одоо ч гэсэн надад бүрэн талтай байгаагаа харуулж, инээмсэглэж, буруу харахгүй байсан бөгөөд буруу харсан ч нуруу нь тийм зэвүүн бус, зөөлөн, нөхөрсөг байлаа.

Краснухиныд очив уу?

Би очих нь очсон боловч сэтгэлд таарах юм олдсонгүй гэж хариулаад Везнд хулсыг нь эгүүлэн өгч дахин эргэж ирэхгүй байж болох л юм. Нэг үгээр хэлэхэд Везнтэй иймээ тиймээ гэлцэлгүй холбоо тасалж болох юм. Гэвч энэ бол бэрхшээл түвгээс халшран зуларна гэсэн үг. Ингэснээрээ би биеэ бассан хэрэг болно.

— Владимир Николаевич, би таны даалгаврыг дахиад биелүүлж чадахгүй ээ.

Везн номын шүүгээ налан зогсож байснаа нааш эргэж,

— Яагаад миний даалгасныг биелүүлэхээ больдог билээ?

— Дур алга.

— Яагаад тэр вэ?

— Дур алга, тэгээд л тэр. Яагаад дургүй байгаа нь миний хувийн хэрэг.

— Энэ ганц чиний хэрэг биш, бидний нийтийн хэрэг.

— Дургүй юмыг минь хэн ч надаар албадаж хийлгэж чадахгүй.

Энэ нь тодорхой чиг, ойлгомжтой чиг.

— Чи нөхөрлөлөөсөө урваж байна уу?

Би мөрөө хавчив.

— Та яасан жигтэйхэн юм ярина вэ? Костя бокс сонирхдог, тэгэхлээр найз нар нь бас бокс оролдох ёстой болж байна уу? Би усны харайлт сонирхдог, тэгэхлээр миний найзууд бас харайх ёстой юу. Сийлбэр, цуглуулах нь надад сонин бус байна. Тэгээд л тэр!

Усанд харайх талаар би залчихлаа. Би оролдож эхлэх санаатай л байгаа юм. Гэвч баримт болгоход маш оновчтой байв.

— Нэцкэ чамд сонирхолгүй байна гэнэ ээ? гэж Веэн татгалзаад номын санд очиж, баахан ном уншсан мөртөө өнөөдөр болохоор сонирхохоо больдог чинь юу билээ. Авцалдаагүй, үнэмшмээргүй юм. Надаас холбоогоо таслахыг чинь би хорих эрхгүй. Гэвч яагаад ингэж байгааг чинь би асууж мэдэх эрхтэй байхаа. Шударга журамтай улс ингэж холбоогоо тасалдаггүй юм.

Би тайлбар тавьсандаа харамсав. Веэн хуурмаг баримт гаргахдаа надаас илүү. Тэр бээр ямар ч асуудалд шударга хариулж, ямар ч зэмлэлийг няцаахад бэлхэн хүний байртай намайг ширтэж номын сан налан зогсож байлаа. Ер нь би түүнийг юу ч гэж буруутгах юм билээ. Эмгэнээс аялагч хөгжимчдийг нь мэхэлж авсан гэх үү? Краснухиныг шүүмжилсэн өгүүллийн төлөө юу? Ядахдаа би тэр өгүүллийг уншаагүй байгаа. Игорьтой ярилцсаныг ч би шалтаг болгож чадахгүй байв. Би хаашаа ч үгүй болов. Зүгээр явчих байсан юм. Гэтэл би хэл амаа билүүдэж байж энэ.

Мавродакийн тухай асууя байз гэсэн бодол төрөв. Нэцкэ цуглуулдаг байсан тийм лут хүнийг заавал мэддэг байж таарна. Веэнийг Мавродакийн тухай ярьж байх хооронд би цааш яахыгаа бодъё.

— Владимир Николаевич, та Мавродакийг таньдаг байсан уу? Миний ингэж асуухад Веэний ямар болсныг өгүүлж чадахгүй л болов уу. Дөнгөж сая хөнгөхөн дэгжин костюмтай урлаг судлаач Веэн номын сан түшиж, намайг тайван, итгэлтэй ширтэн зогсож байлаа... Гэтэл одоо өмнө минь шал ондоо хүн зогсож, магадгүй, ганц хувь, ганц хором, ганц агшин төдий өөр хүн зогсож харагдлаа. Гэвч энэ агшин сэтгэлд минь хадагдав. Эртээр голын эрэг дээр байхад намайг харсан агшин зуурын, шөвөгдсөн, үүний хамт арчаагүй үхээнц харц нүдэнд тусав. «Нуруу хүйт даах» гэгчийг анх удаагаа үзэв. Ийм хэллэгийг дуулсан, өөрөө хэлдэг байсан боловч яаж нуруу хүйт даадгийг Веэн намайг харахад л анх мэдэв.

Гэвч тэр агшин өнгөрлөө. Веэн сандал дээр хөлөө ачин сууж, нүүрээ дарав.

— Хэн чамд Мавродакийн тухай ярив?

— Краснухин.

— Тэр юу гэж ярив?

Мавродаки гэдэг сийлбэр цуглуулагч алдарт хүн байсан гэсэн.

— Өөр юу гэсэн бэ?

— Өөр юм хэлээгүй.

Везн хурууныхаа салаагаар намайг сонжин харлаа. Чи намайг таньдгаа хэлсэн үү?

— Үгүй ээ.

Тэр бээр хэсэг зуур гараараа нүүрээ таглан дуугүй сууснаа:

— Тэгэхлээр Краснухин чамд Мавродакийн тухай ярьж үүний дараа чи надаас холбоогоо таслах гэж шийдсэн хэрэг үү?

— Энд Мавродаки ямар хамаатай юм бэ?

— Чи яагаад ингэж шийдэх болов?

Бид эхэлсэн зүйлдээ эргэж оров. Би түүнд юу гэх билээ. Тэр үнэнийг хэлүүлэх гээд байдаг, гэтэл үнэн нь түүний зальхай этгээд гэдэгт байдаг. Үүнийг хэлэхэд эвгүй юм.

— Би явлаа.

— Азна

Би дахин суув.

— Чи үнэнийг хэлэх болно доо.

— Би танд юу хэлэх юм? Энэ бүхэн санаанд таарахгүй байна. Би нууц мууцад дургүй. Би Костяд хойд эцгийн нь тухай хэлэх, Краснухинд таны явуулсныг, эцэг эхдээ таны даалгавар биелүүлж байгааг хэлэх ёсгүй гэнэ! Цаг үргэлж нэг юм нууж хааж, ухаж төнхөж байх ёстой! Би ингэж сураагүй. Би юу ярих ёстой, юу ярих ёсгүйг мартаж будилах боллоо. Цуглуулга хийхэд ингэж нууж хаах хэрэгтэй байдаг юм уу? Гэвч ийм цуглуулгын ажил надад сонин биш байна! гэж би хашхирлаа.

— Би чиний хэлж байгааг ойлгож байна гэж Везн тал өгөн хэлээд

— Гэхдээ чамайг би худал хэл гээгүй биз дээ? Томрох тусмаа бид хийж байгаа юмаа эцэг эхдээ тоочих нь цөөрдөг шүү дээ. Хэрвээ чамд нэг охин аятайхан санагдвал түүний тухай аав ээждээ хэлэх гэж гүйхгүй байх. Тийм биз дээ?

— Тиймээ

Би юу хариулж чадах билээ? Майка, Зоя хоёрын тухай яриагүй, ярих ч үгүй.

— Краснухины тухайд гэвэл түүний цуглуулгыг миний мэдэж байгаагаас илүү тэр миний цуглуулгыг мэдэж байгаа гэж итгэ. Буурь муутай боловч том мэргэжилтэн. Буурь муутай нь тоогүй. Тэр Мавродакийн тухай чамд ярьж. Гэвч шавь нь байсан хэр нь хэргийн мөн учрыг мэдэхгүй байгаа юм.

— Нэг өгүүлэл сонинд гарч дараа нь хурал болсон гэж Краснухин ярьсан.

Веэн маш хайхрамжгүй царай гаргаж:

— Тийм юм болсоон, гэвч гол нь өөр учиртай юм. Эмгэнэлт явдал болохоос өмнөхөн Мавродаки гэрлэсэн юм. Гэргийдээ маш хайртай байсан боловч гэргий нь түүнийг хаяж, өөр хүнтэй... сайн нөхөртэй нь суучихсан юм. Болсон зүйлийн жинхэнэ шалтгаан нь энэ дээ. Бусад нь гаднах шалтгаан. Тэр бэрх цагт олон хүнд иймэрхүү эвгүй зүйл учирч байсан юм. Гэвч энэ бол аль эрт улирч баларсан юм. Одоо амьдрал урагшилж байна. Краснухин надтай би Краснухинтай уралдаж байна. Энд ямар ч зохисгүй юм байхгүй. Үүнийг хуулиар гэсгээдэггүй.

Надад хариулах үг олдсонгүй. Энэ цуглуулагчидтай толгой эргэж гүйцэх юм!

— Таны зөв ч байж магадгүй. Гэвч би хувьд хүсэхгүй байна.

Миний үгийг хайхралгүй Веэн үргэлжлүүлж:

— Костяд хойд эцгийнх нь тухай битгий ярь гэж гуйсан маань зүгээр болгоомжилсон хэрэг. Би чамд итгэж байдаг, гэтэл чи худал хэлэх мэхлэх явдал руу түлхэж байна гэж намайг буруушааж байдаг. Манай нөхөрлөлд чамайг авсан нь учиртайг нуух юм алга. Би Костяг чам шиг найзтай болгох гэсэн юм. Костя хууртсаар байгаад дүнсгэр, зожиг түргэн ууртай болчихсон юм. Чамтай үерхвэл тайван төвшин болох байх гэж би найдсан юм. Костяг хүний дайтай байгаасай гэж би хүсдэг. Үүнийг би үүргээ гэж үзэж байна. Чамтай үерхвэл түүнд ашигтай мэт бодогдсон билээ. Костягийн ээдрээтэй хувь заяаны тухай дуулаад чамайг надад туслах байх гэж бодсон юм. Татгалзаж байгаа чинь тоогүй. Тун тоогүй! гэж хэлэх байна даа.

Веэний яриаг сонсонгоо би сэтгэл хоёрдох өвчин туссан байхаа гэж бодов. Ганцаараа байхад минь Веэн өөр хүн гэж бодогдон баримтаар түүний зальхай этгээд гэдэг нь нотлогдож байсан. Гэтэл Веэнийг ярихаар баримт өөрөөр эргэж, Веэн төлөв журамт хүн болчих юм. Үүний чацуу, сэтгэл хоёрдох гэдэг энэ дээ. Би эндээс гармагц Веэн миний нүдэнд зальхай амьтан болж харагдах болно гэдгийг мэдэж байлаа. Би ятгалгад нь орохгүй гэж бат шийдлээ.

Гэнэт инээд хүрчихлээ. Зүв зүгээр байж байтал хичээл дээр инээмээр болдог. Юу болсныг бүгдээрээ ойлгохгүй нүдээ бүлтийлгэж байхад элгээ хөштөл инээнэ. Ингэж болохгүй гэж мэдсээр байвч

инээдээ барьж үл болно. Ангиас хөөж байхад ч зогсохгүй. Одоо би яг тэглээ. Мэдрэлийн юм болов уу? Би эргүү юм шиг инээж байв. Нүднээсээ нулимс гартал инээлээ.

Энэ бол мэдрэлийн дайрлага гэдгийг би хожим нь ойлгов. Веэн намайг хүчээр дарах гэхэд миний хүсэл зориг түүнийг нь эсэргүүцэж, ингэж их хүч гаргаснаас мэдрэлийн дайрлага болж. Ичмээр юм! Ямар ч үед тайван, хэнэггүй, тэвчээртэй байх хэрэгтэй. Англичууд ямар нэг юм болбол хөмсгөө ч хөдөлгөхгүй гэж нүдэндээ өрөөсөн шил зүүж явдаг гэж нэг номоос уншсан юм. Англичууд яггүй бодож олжээ. Сайхан зуршил байна. Гэвч одоо үед өрөөсөн нүдэндээ өсгөдөг шил хийх нь бол ёстой мэдрэлийн согогтой хүн гэгдэнэ. Өөр юм сүвэгчилж, тайван хэнэггүй амгалан байж сурах хэрэгтэй бөгөөд тэгэхгүй бол Мавродакийн тухай миний асуухад Веэний биеэ илчилчихсэн шиг хэдийд ч гэнэ алдана. Цухал нь хүрээд, тэвчээр нь дутаг. Тэвчээр дутаагүй бол над итгүүлчхэж дөнгөх байсан биз.

Веэн миний инээхэд гайхсангүй, инээхээ болихыг минь хүлээн намайг ширтэнэ. Би гэнэт инээж эхэлсэн шигээ гэнэт инээхээ болив. Нүдээ арчаад л инээхээ байх нь тэр.

— Цаашид яая гэж байна? Костятай үерхсэнээрээ үерхэх үү?

— Тэгнэ ээ, харин нэцкэ цуглуулахгүй ээ.

Би үүнийг лав хатуу хэлсэн байх. Веэн намайг нүд салгалгүй ширтэх ажээ.

— Чи ингэж эргэлтгүй шийдээ юу?

— Тэгсээн

— Өөрөө мэд. Хулсан сийлбэр хаана байна вэ?

Би халаасаа уудалж хулс, соно хоёрыг гаргаж ирлээ. Краснухин намайг явуулах гэж яараад байсан учир би түүнийг нь эргүүлж өгөхөө таг мартчихаж.

— Аль вэ, чамд ямар юм байна, үзүүлээч

Веэн соныг гайгүй сайн үзлээ.

— Краснухин өгөв үү?

— Тэгсэн юм.

— Яах гэж?

— Өгсөн л юм.

— Сонин сийлбэр байна.

— Сонин.

— Чи үүнийг над орхих юм байгаа биз дээ.

— Яаж болох вэ.

Веэн шүүгээнээс одос унасан тариачны сийлбэр гаргаж ирэв. Үдэш болж тариалангийн талбай дээр ажил дуусаад тариачин одсоо унан хөл амарч дуу аялан харьж явна. Энэ бол сайхан сийлбэр байв. Түүнийг харахад, хийдэг ажлаа хийгээд санаа амарч сэтгэл тайвширсан налгар байдал мэдэгдэнэ.

— Түүнд одсыг өгчих.

— Солихгүй гэвэл яах вэ.

— Сольдгийгоо сольчихсон гээ.

Би соныг буцааж хармаалав.

— Үүнийг ч больё доо.

Веэн намайг баахан ширтлээ. Нээрээ шүү, одоохон ухасхийж надаас сийлбэрийг булааж авах нь уу гэж бодогдов. Энэ цуглуулагчид уу, яаж ч мэдэх улс. Цуглуулга гэхлээр ухаан алдчихдаг юм.

Веэн сийлбэрийг булаах гэж дайрсангүй. Хэсэг дуугүй зогссоноо,

— Чиний паспортаар хуучны юм худалддаг газар нэг сийлбэр өгсөн. Хөгжимчид шиг билээ дээ... Хэрэв зарагдсан бол мөнгийг авах хэрэгтэй.

— Тасалбарыг нь өгчих, би очоод авчихъя.

— Чамаас комисс түүнийг авсанд би гайхаж байсан юм. Мөнгө авахад чинь чамайг эцэг эхтэйгээ ир гэх байхаа даа.

— Аав ээж хоёр эзгүй байгаа.

— Ирнэ биз дээ.

Энэ тухай аав ээж хоёрыг мэдээсэй гэж би төдийлөн хүсэхгүй байв. Миний амьдралын санамсаргүй энэ тохиолдлыг мэдэх хэрэг тэдэнд юу байх вэ? Тэгээд л би Веэнтэй үүнээс хойш уулзахгүй юм чинь. Гэвч Веэн намайг далайлгаж, золигийн тасалбараар түрээ барьж байна. Тэгнэ ээ бас! Би хөгшдөдөө өөрөө хэлчихнэ. Би тэдний чихийг халууцуулахгүй юм сан гэж бодох нь боддог. Муу юм тэдэнд маань учралгүй надад л учирч байгаасай гэж дандаа боддог. Ямар ч аюултай юм боллоо, жишээлбэл дээрэмчид дайрах юм уу, байгалийн гамшиг тохиолдож үер болж, газар хөдөллөө гэж бодоход юуны урьд хөгшдийнхөө төлөө санаа зовдог юм. Аав минь надаас хавьгүй хүчтэй боловч би өөрөөсөө илүү түүнд сэтгэл зовоод байдаг юм. Энэ хэрэгт цааш орооцолдсоор байснаас эвгүй ч гэсэн, аав ээж хоёрт үнэнэ ярьсан маань дээр. Улам нэмэрлээд байсанд орвол муу юм хийснээ хэлчихсэн нь дээр.

— За яах вэ, хөгжимчдийн мөнгийг авах цагт тань би авч өгөмз
гэлээ.

Өглөө Игорь манайд ирэв.

— Өвгөөн, нойр авч байна уу?

— Ном уншиж хэвтэнэ.

Игорь номыг эргүүлж тойруулж

— Бальзак гэж... Балрын үеийн юм. Чи үүнийг яаж уншиж бардаг юм бэ?

— Бардаг л юм даа.

— Эх адаггүй нуршиж, хэнд ч хэрэггүй юм тоочин залхуу хүргээд бас, аль толгойд орсон бодлоо бичдэг юм билээ.

— Гэхдээ бодол нь сайхан!

— Зохиолч дотроо бодсоноо хэлж байх ёсгүй. Зохиолчийн өгүүлж байгаа уншигчдын бодоход саад болоод байдаг.

— Тархины бор бодисын хэмжээнээс л хамаг юм шалтгаална даа гэж би татгалзаад

— Надад бол Бальзакийн санаа бодол гайхмаар ултай байдаг. Хэчнээн цогтой гээч! Дүр нь ямар гэж санана аа! Растиньяк байна! Эсвэл Вотрен ч гэсэн лут хүн!

Игорь ихэмсэг инээмсэглэж

— Дуутай жүжиг, хөдөөгийн театр, хошин жүжиг, марзан ший.. Угтаа бол Бальзакийн цорын ганц сэдэв нь мөнгө л дөө. Мөнгө яаж олох тухай л юм!

— Мөнгөөр зогсохгүй нийгэмд мөнгө сүйтгэх хүчтэй байдгийг бас тэр нийгэм бол... гэсэнд Игорь миний хэлсэн биеийг нь өвтгөсөн мэг үрчийж, энд нийгэм падгүй! Ямар ч нийгэмд мөнгө гол хүч, үүнийг үл мэдэгч болж өнгөрөөд яах вэ. Мөнгө гэснээс Везн авлагаа аваад ир гэсэн шүү.

— Юун авлага гээч вэ?

— Арван таван цаас.

— Ямар арван таван цаас?

— Хоёр рубль тавин копейк гуанзанд орсных. Санаж байна уу? Бас хоёр рубль тавин копейк нь тээврийн зардал. Костя чиний орноос төлсөн. Арван рубль зугаалгынх. Нийлээд арван тав.

— Чи чинь зугаалгад тав тавыг авна гээгүй юу гэж арайхийж хэллээ.

— Нэг хүнээс тэр. Чиний хатагтайн орноос хэн төлөх юм бэ?

— Гэхдээ одоо авдаг нь юу вэ?

— Өвгөөн, чамайг боож хаасан хүн алга. Чамайг ч, чиний хонгорыг ч хавчин шахсан хүн алга. Вээн рүү очоод тохиролцчих, чамайг цаашаа гэхгүй ээ.

Би мөнгө гаргаад, арван таван рубль дуугүйхэн тоолж өглөө. Ойлгомжтой байна! Эд надаар гуйлгах гэж! Гайгүй ч байгаа даа!

— Аргагүй хичээнгүй нь харагдаж байна гэж Игорь ярвайн хэлэв. Намайг луу унжина гэж бодож.

Санаа муутай нь мэдэгдэж байна гэж би хариулав.

— Чи хэнийг хэлж байна.

— Вээнийг.

— Тэгж дэндүүлэхийн хэрэг байна уу?

— Чиний төлөөнөө ч баярлаж байна. Чи сая л нэг юм жинхэнэ мэргэжлээ олж авч. Чи татвар гайгүй сайн цуглуулагч болно доо.

— Өвгөөн, хоншоор руу нь татахгүй бол болохгүй юм байдаг.

— Уухай тийм бий! Чи нөгөө авлагаа авах гээ юу? гэж би дуу алдлаа.

Номынхоо эхэнд Шмаков Игорийг яагаад эрүү рүү нь нэг тавьсан тухай дурдаад өнгөрснийг энд ярих хэрэгтэй байна. Би түрүүлж түнших байсан юм. Гэтэл Шмаков ойрхон зогсож байсан болоод надаас урьдчихсан юм. Цахилгаан шатны хаалгыг хаасангүй гэж Игорь тавиулсан юм. Наймдугаар давхрын чөлөөнд зогсож Норатай шаан паан хийн, цахилгаан шатыг хүлээлгээд болдоггүй. Байрынхан уурлацгааж байлаа. Цахилгаан шат сар ажилгүй байж байж сая нэг юм ажиллахчаа болсон боловч ингээд явж болдоггүй, Игорийг Норатай шаан паан хийж дуусахыг хүлээх хэрэгтэй байдаг. Шмаков Петр бид хоёр, доор энэ балай явдал яаж дуусахыг хүлээж зогслоо. Сайн юм болж дуусахгүй гэдэг нь тодорхой. Тэгж тэгж Игорийг нэг юм бууж ирэхэд нь бид түүнийг хар амиа бүү бодож бай гэсэн юм. Тэр өөдөөс цор цор гэж байж, Шмаков Петрт эрүүндээ тавиулсан нь тэр. Вээн хажуугаас оролцоогүй бол надад ч дэлсүүлэх байсан юм. Үүнийг нь би сая санууллаа л даа.

— Ингэж ярьчихаад чи бид хоёр найзална гэнэ ээ гэж Игорь ихэрхэг хэлэнгээ нэг алхам ухрав.

Би хаалга нээж

— Саёнара! гэлээ.

Японоор энэ, нь «Баяртай» гэж байгаа юм. Гэтэл миний хэлсэн нь «Та гарч хайрлана уу?» гэсэн шиг боллоо.

Би Игорийг «Та гарч хайрлана уу» гэж үүд рүү лут зааж, мундаг зангалаа шүү! Ёстой догио! Би тэдэнд таарсан хариуг нь өгсөн. Арчаагаа алдсан санаа муутай олхиогүй амьтад, заяагүй муусайн золигууд, намайг бас арван таван рублиэр худалдаж авах гэж!

Хамаг мөнгийг минь гүвчих нь гүвчихлээ. Ер нь хэдэн рублиэтэй үлдэж вэ? Тоолоход зүрх үхмээр, гэвч үнэн юм үнэнээрээ байх хэрэгтэй.

Би мангуурч хоцорлоо. Уртаашаа зургаахан рублиэтэй үлджээ. Юугаараа өл залгадаг билээ? Тийм их мөнгө юунд үрчих вэ?

Арван тавыг Веэнд өгсөн. Намайг хөөрхөн чадлаа даа. Өгдөггүй байж би түүний л даалгаврыг биелүүлж явсан юм чинь. Гэвч ингэж бодох оройтжээ, үнэн юм үнэнээрээ байх хэрэгтэй...

Ингэхээр Веэнд арван таван рубль өгч.. бөөн өгчихдөг нь ч юу билээ. Арга ядахад цувуулаад төлж болох байсан. Ээ халаг гэж! Веэн намайг ганцаараа байгаа, мөнгө олох газаргүй гэдгийг сайн мэдэж байгаа. Мөн ч хатуу сэтгэлтэй хүн юм. За яадаг юм. Үхэхгүй л байх. Үнэн юм үнэнээрээ байх хэрэгтэй.

Ингэхээр Веэнд арван таван рубль өгчихсөн... Хэрэв... За үүнийг больё. Бодохын ч хэрэг алга.. Арван тавыг Веэнд өгсөн, гурав тавиар шуудаг авсан, хоёр гучаар үс засуулсан, наян копейкаар Игорь, Костя хоёртой кафед орсон, кафед ордог нь ч юу билээ. Тэнд нэг ч шүлэгч, жүжигчинтэй тааралдаагүй. Ээжид цахилгаан явуулсан, энэ ч яах вэ, үрийн элбэрэл журам. Өчигдөр уржигдар, уржигдрын цаад өдөр хоол идсэн, нэг рублиэр Зоятай кино үзсэн. Бас нэг рублиэр Зоятай таксидсан, метрогоор явж, хийжүүлсэн ус ууж, зайрмаг авч идсэн.. Хямгатай зарахгүй бол горьгүй нь ээ!

Ингэхлээр төсөв гэдэг чангахан байна даа! Өглөө шүүрхий өндөг, тостой талх идэж, аяга цай ууж байя. Ээж бүтэн боодол цай, томоос том тос, хайрцаг ёотон ихээ давс орхисон. Арван өдөрт тааруулаад арван өндөг нэг амиар авчихъя. Үдэд таваг шөл уучаад орой нь хоосон туугаад байдаг хэрэг. Гучин мөнгө өлхөн хүрнэ, гуравтын дэвсгэр үлдэж байна. Зоятай гурван удаа кино үзчихнэ. Тэгэхдээ ер таксидахгүй. Харин Зоя яагаад таксигаар явах тийм дуртай юм бол?

Би тэр даруй дэлгүүрт очиж арваад өндөг аваад боодолтой нунтаг мах байгааг үзлээ. Үүнийг усанд буцалгачихвал хоёр таваг шөл

болчихно. Ёстой гоё! Гуанзанд орох хэрэггүй. Би таван боодлыг авлаа. Арван таваг шөл бэлэн гэсэн үг. Тэгээд таван хайлмаг, бяслаг авлаа. Арван оройн хоол бэлэн болох нь тэр. Ээжийг иртэл идэх юмтай болж авлаа.

Өлбөрч үхэх аюулаас мултрах нь энэ. Үлдсэн гурван рублийг чөлөөтэй зарж болно. Цөмийг нь зарж дуусахаараа Зояд «сохор зоос ч үгүй боллоо. Зүгээр ингээд явъя» гэж хэлнэ. Зоя сайн нөхөр гэдгийг ойд байхдаа мэдсэн. Өө ингэе, одоохон Зоя руу очоод «Надад гурван рубль байна. Одоо үүгээр наргия, хожим болох л байлгүй» гэж хэлье. Эр хүн байна. Мөнгөөр яадаг юм! Гурван рублиэ үгүй хийж санаа амаръя. Зарахын төстэй зарчихъя. Сувдаг шунахай, нарийндаа хатсан, хэнхэг туссан, гарынхаа салаагаар юм гаргаж үзээгүй муусайн юмнууд тонилтугай! Ашиг завшаан эрж, хонжоо харагчид цааш хартугай! Би ч эр хүн юм аа, Игорььт арван таван рубль чулуудчихаад сэтгэл санаа, ер нь юу юугаараа ч давуугаа харуулсан. Энэ гурван рублийг л өнөөдөр үрье.

Гэвч энэ орой гурван рублиэ зарж чадсангүй.

Нэгд дэлгүүрт Шмаков Петр эргэлдэж байлаа. Хоёрт өнөөдөр заводын цэцэрлэгт худалдааны залуучуудын үдэшлэгтэй гэсэн зарлал байв. Спортын барааны дэлгүүрийн худалдагчид эрэгтэй эмэгтэйгүй бултаараа тийш очно. Тэнд маргаан болж, дараа нь нийтийн бүжигтэй. Зоя ч очно. Шмаков бид хоёр очихоор болов.

Хурлын тэргүүлэгчид байгаагүй нь санаанд минь таарав. Хурлыг нэг залуу удирдаж байлаа. Өөрийгөө Володя гэдэг гэлээ. Үгийн далимд хэлэхэд гялалзтал удирдаж байв. Энэ ажлыг овсгоотой, зохион байгуулалттай шуурхай явуулж байлаа. Гол нь хурлын тэргүүлэгчдийн байранд суусангүй, танхимд сууж, заримдаа босож, эргэж, бүгдэд сайн харагдаж байв. Мань эр урьдаас боловсруулсан төлөвлөгөөний дагуу хөтөлж байсан нь гарцаагүй, ганц болдог зүйл! Гэвч гурван зуугаад хүн цугларсан байлаа. Тэднийг танхимаас удирдах гээд үз. Ухаан зарах хэрэгтэй. Энэ нь тэргүүлэгчдийн байраас хонх жингэнүүлэхтэй адилгүй.

Үг хэлэхэд мөн л байраасаа ярьж байлаа. Ямар ч албархсан байдалгүй биеэ барихгүй чөлөөтэй байв. Ийш тийш эргэсээр байтал хүзүү чилчихмээр боловч энэ нь тайзан дээр нуршаа амьтан цаас шагайн сунжирсан юм бувтнахыг алмайран харж сууснаас дээр ээ.

Сизов, Коротков хоёр л индэр дээр гарав. Тэр хоёр манай байшинд суудаг, багаж төхөөрөмжийн баазад ажилладаг юм. Манай гудамжинд багаж төхөөрөмжийн ерөнхий газар гэдэг бөөний худалдааны тийм бааз байдаг юм. Ердийн л хүүхдүүд, гэхдээ үсээ урт ургуулжээ. Урт үсний ашиг юу байгааг тэднээс Володя асуусан юм. Коротков, Сизов хоёр индэрт гараад чилийсэн гучин минут бөртгөнөв. Улс амьтны нүдэн дээр тэгж гозойж байх нь тэдэнд сайхан байж л дээ.

Тайзан дээр хавчиж бөвтнөнө.

— Өвөл болох гэж байна гэж Сизов бөвтнөв.

— Өвөл болох гэж байна гэж Коротков тоть шиг дуурайв.

Тэр хоёр өөр юу ч хэлж чадсангүй. Дах шиг гадуур цамц, шилбэ барьсан өмдтэй, шилээ дарсан үстэй инээдмийн юмнууд тайзан дээр зогсож «Өвөл болох гэж байна» гэж бавтнаж байлаа. Хүйтэн болохоос наана үс ургуулах хэрэгтэй гэнэ. Гадаа зуны эхэн сар болж халуу дүүгж байхад тэд тайзан дээр зогсчоод «Өвөл болж байна» гэж бавтнаж байдаг. Маргаан өөр сэдэвтэй болсон байхад Сизов, Коротков хоёр тайзан дээр холхисоор байсан учир хүүхдүүд тэднийг хөлдөж, тайзнаас чирч орууллаа.

Маргаан зохион байгуулалттай болж байв.

Бидэнтэй зугаалгад хамт явдаг нөгөө худалдагч Рая:

— Өөр юмаар тодорч чадахгүй хүн л сахал тавьдаг юм гэж хэлэв.

Судалтай цамц, хар хүрэмтэй усан цэрэг түүний хэлснийг эсэргүүцэв. Хаанаас гараад ирсэн нь мэдэгдэхгүй ийм усан цэрэг хурал цуглаан дээр зөндөө дайралддаг юм. Тэд цэцэрхэж, «Манай флотод» гэж ярьж, «Луужин» гэхийг «Луузан» гэж дуудна. Гэтэл өнөөдрийн усан цэрэг өвөг дээдэс, уугуул уламжлалыг их дурдав.

— Маркс, Энгельс, Калинин, Дзержинский, академич Курчатов нар цөм л сахалтай байсан. Сахал бол орос хүний өвөрмөц шинж юм. Хэн бидэнд сахал заяав? Байгаль, байгалиас бидэнд заяасан бүхэн сайхан. Түүнээс гадна би хувьдаа өргөн өмдийг дээр гэж боддог. Өргөн өмдтэй хүн цаанаа л догь харагддаг. Өргөн өмдтэй хүүхэд хатуу зан чанартай буурьтай болж харагддаг. Иван Поддубный өргөн өмдтэй байсан, гэтэл түүнтэй эгнэх бэх дэлхийд байгаагүй...

Усан цэрэг бүр донгосож гарсан тул Володя түүнийг бусад хүн үг хэлэх боломж олгооч гэж гуйв.

Тэгтэл нүдний шилтэй бүсгүй өндийж:

Сахал ургуулна уу байна уу хүний хувийн хэрэг, үүнийг улсын чухал холбогдолтой болгох ямар хэрэг байна вэ? Сахалтай тэмцсэнээс мөс муутай бэртэгчин үзэлтэй хүмүүстэй тэмцэх нь чухал гэв.

— Танхайчуултай тэмцэх хэрэгтэй! гэж ам амандаа хашхиралдав.

Хэрэг түвэг тарьж байгаагийн улыг олж, яавал зохихыг ярилцав. Нэг хэсэг нь хэрэг түвэг удагсдыг дахин хүмүүжүүлэх санал гаргаж, нөгөөдүүл нь шоронд хорьё, зарим нь дахин ч хүмүүжүүлье гэлцлээ. Усан цэрэг тэр ч байтугай буудан алах хэрэгтэй гэв. Тэгэхдээ бүгдийг биш л дээ, дээрэмчин, улайрсан амьтныг буудъя гэсэн юм.

— Бид фашист Германыг ялсан байж хулгайч дээрэмчдийг дийлэхгүй байдаг. Хөгтэй юм гэж усан цэрэг хэлэхэд өөр нэг залуу:

— Хамаг юм ууж хөлчүүрснээс болж байна. Үлбийсэн амьтан балга тагш юм уучхаад гудамжаар салгалж, хүн хүнийг очиж шөргөөнө. Хоншоор дундуур нь татаж болохгүй, өөрөө танхайрлаа гэж хэрэгт орно гэв.

Үүнийг энэ залуу ганц онож хэллээ. Нэг удаа хогийн амьтан манай гудамжинд байдаг гутал тослогчийг хоргоож гуйвж уначих гэж байгаа мөртөө шаахайгаа тосол гэж тулгав. Гутал тосолдог хүн түүнд «харьж унт!» гэвэл тэр «Муу армян» гэж доромжлов. Шмаков бид хоёр энэ арьсны үзэлтнийг шовгороос холдуулж агдалж барив. Агдлах гэж бид, хоёр талаас нь шахан хавирганы доор дарахыг хэлдэг юм. Тун

эвтэй эд дээ. Тэр золигийн хамраас нь цус гоожлоо. Нэг эгч биднийг хүн алж байна гэж хашхирдаг байна. Яах ийхийн зуургүй улс цугларч сэргийлэгч хүрч ирэв. Согтуу этгээдийг түрүүнд агсан тавихад хэн ч байгаагүй, гэтэл одоо цөмөөрөө гүйлдэж ирдэг байна. Бид хоёр энэ хэргээс сохор азаар мултарч гарч билээ.

Дахиад нүдний шилт бүсгүй босож:

— Түрүүчийн хүний хэлснийг зөвшөөрч байна. Хамаг юм архинаас болж байна. Зарим залуус яагаад мал болтлоо ууж байгааг бодох хэрэгтэй гэв.

Би хажуудаа суусан Шмаков Петрт

— Хэрвээ Зөвлөлт Холбоот Улсын иргэн бүр машин юм уу мотоциклтой байсан бол согтуурах явдал гарахгүй байх сан гэлээ.

Шмаков намайг нүднийхээ булангаар харж

— Яагаад? гэхэд нь

— Согтуугаараа тэрэг барьж болохгүй.

— Ингээд ч асуудлыг шийдвэрлэхгүй ээ. Биднийг завод барьж байхад согтуурах явдал зогсчихгүй шүү дээ.

— Авто машины үйлдвэр барих нь манай энэ зуунд тийм ч хэцүү биш ээ.

— Чи тэгвэл босоод хэлээч. Хэл л дээ хэл.

— Хэлээд яах вэ?

— Тэгвэл бүү пар пар гээд бай!

Уг нь хэлдэг байсан юм. Гэвч хурал дээр балмагдаад үг хэлж чаддаггүй юм. Нүүр хагараагүй гэх юм уу даа..

Энд Зоя байгаагүй бол хэлээд алдах л байлаа. Зоягийн дэргэд ч болих уу даа.

Энэ завсар хүний дур сонирхлын тухай яриа үүсэв.

— Дур сонирхол гэдэг бол гоё сайхныг ойлгож, ухамсартай тунгаан бодох чадвар мөн гэж Володя хэллээ.

Тэр өөрөө зохиов уу, эсвэл нэг юмнаас уншсан юм болов уу? Ямар ч гэлээ гэсэн догь! Сахлаас эхэлсэн мөртөө нухацтай асуудалд орлоо. Хурал удирдана гэдэг их эрдэм юм!

Сургууль дээр болдог маргаан яагаад залхуутай байдаг гээч! Хүүхдүүд илүү дутуу юм ярьчих вий гэж айгаад байдаг юм. Илүү юм ярьчихна гэж айхлаар яаж гол юмаа хэлэх вэ?

Тэтгэврийн насны өвгөн босов. Ийм өвгөчүүд залуучуудын хуралд усан цэргээс олон ирдэг юм.

— Бид элбэг дэлбэг аж төрөхийг эрмэлзэж байна. Манай залуус яагаад шилбээ барьсан, гуягаар татсан юм өмсөх ёстой юм? Хүй нэгдлийн үеийн хүмүүс л даавуу хүрэлцэхгүй байсан байх. Гэтэл манайд нэхмэлийн үйлдвэр урагш хөгжиж байна. Өрнөдийнхний тоорцог өмсдөгийг заавал дуурайдаг нь юу вэ? Гантигаар хийсэн заан хэнд гай болоод байна. Манай чинээлэг баян амьдралын бэлэг тэмдэг болон байж л байг. Бидэнд бахархах юм мундахгүй байна.

Өө харла! Чухал юмны тухай ярьж байхад өвгөн новшны тухай ярьж байдаг. Би тэсэж чадсангүй.

— Бид хиймэл дагуул, сансрын нисгэгч, авьяаслаг залуу яруу найрагч, уран зураачдаараа бахархахаас биш, гантиг заанаар бахархаад яана.

Намайг ингэж хэлэхэд алга ташсан гээч, нээрээ шүү. Би амжилтдаа урамшиж:

— Тоорцог малгайны тухайд гэвэл, толгой нь хоосон бол тоорцог тавьсан ч адил бүрх малгай тавьсан ч адил.

Би машиныг согтууралтай тэмцэх хүчирхэг хэрэгсэл гэж хэлэх гэсэн боловч өвгөн босон харайж минчийтлээ уурлан.

— Залуучуудыг ингэж хүмүүжүүлдэг юм уу?! гэж хашхираад толгойгоо заалаа. Өвгөн бүрх өмсөж явсан юм санж.

— Үг хэлэгч бүрх малгайг ер нь малгайны хувьд хэлсэн болохоос биш, нэг хүнийхийг цохож хэлээгүй гэж Володя хэлэв.

Будилааныг булзааруулахын тулд битүү ноосон цамцтай өндөр бүсгүйд үг хэлэх зөвшөөрөл олгов.

— Би барааны мэргэжилтэн. Хүний жинхэнэ гоо сайхан, хувцсанд биш сэтгэл оюундаа байдаг юм гэж би хэлмээр байна. Бид хувцас хунарын тухай их ярьж байгаа мөртөө адбиш зорилгын тухай бага ярьж байна. Адбиш зорилго бол гол нь юм...

Маргаан сая нэг юм зөв чигтэй боллоо. Адбиш зорилгын тухай юу хэлье дээ гэж би бодож байлаа. Гэтэл энэ үед Зоя эргэж харав. Би ч бас эргэвэл Зоягийн ах горзгор залуу зогсож байлаа. Зоя дорхноо босоод явчхав. Хүний урамд ганц үг хэлсэнгүй. Адаглаад баяртай ч гэсэнгүй гомдмоор юм! Би түүнийг л гэж энэ хуралд ирж, түүнтэй бүжиг хийнэ гэж горьдож байсан юм. Гэтэл Зоя ганц үг дуугаралгүй босоод явчихлаа.

Өглөө би цайгаа уугаад (ганц өндөг идээд) уншлагын танхимд очив. Сар, өдөр, өгүүллийн гарчиг, зохиогчийн нэрийг мэдэхгүй болохоор бүтэн жилийн үдээстэй сонин үзэх хэрэг гарав.

Гурван цаг үзээд дөнгөж зургаадугаар сарын дугаарт хүрлээ. Хэрэв Мавродакийн тухай өгүүлэл арван хоёрдугаар сард нийтлэгдсэн байвал үдшээс нааш салахгүй нь. Ганц өндгөөр өл дарсныг хэлэх үү. Ходоод хонхолзоод байлаа. Зуушны газар орно гэдэг нарийн төсөвтөө хүрнэ гэсэн үг. Хариад идье гэхлээр байдаг цаг авчихна. Тэгээд эхнийхийг нь сонгож авлаа.

Холимог ногоо, хоёр аяга цайгаар өлөө дараад танхимд буцаж оров. Зургаадугаар сарын эхний дугаараас л Мавродакийн тухай өгүүллийг оллоо. Ердийн л нэг муулсан өгүүлэл байлаа. Тэр үед ер нь сүрхий муулж зүхдэг байж шүү. Мавродаки самуурай нарын урлалыг самуурай нарыг өөрсдийг нь ер нь феодалыг товойлгож байсан гэнэ. Чухам яаж товойлгож байсныг нь би ойлгосонгүй гэвч товойлгож байсан гэж бичсэн байлаа. Зүгээр нэг товойлгоод зогсоогүй, насаараа самуурай нарыг дөвийлгөхөөс өөр юм хийж байгаагүй гэнэ. Шинжлэх ухаанд ямар ч ач тус болоогүй гэнэ. «Шинжлэх ухааны нэр зээлдсэн» гэж шулуухан бичсэн байлаа. Зохисгүй явдлаараа зөвлөлтийн хүний алдар нэрийг гутаасан гэнэ. Чухам ямар явдлаар гэдгийг нь бас хэлсэнгүй, Ер нь уг өгүүлэлд Мавродакийн эрдэмтэн, зөвлөлтийн хүн гэдгийг бүрэн үгүйсгэсэн ажээ. Үүнийг И. Максимов гэдэг хүн бичиж. Намайг вагоны цонхоор нулимдаг шиг олхиогүй амьтан байна. Мавродакийг тэр ч байтугай хүний шаар гэсэн байлаа. Намайг л ингэж хэлсэн бол би намалдгийг нь нээчихсэн, тэгэхэд ч нэг их буруудах юмгүй байх сан.

Би энэ өгүүллийг ухаад авчхаж болох байсан боловч хүн болгон өөртөө хэрэгтэй өгүүллийг тастаж аваад байвал сониноос зөвхөн нэр нь хоцрох биз ээ. Өгүүллийг хуулж авах гэж бас цаг хагас болов.

Номын сангаас буцаж явтал «Залуучуудын боксын хувийн ба багийн аварга шалгаруулах тэмцээнтэй» гэсэн зарлал байшингийн маань дэргэд байгаа харагдахад Костя ч энэ тэмцээнд оролцох байх гэж бодогдов. Костя надад утасдаж, тэмцээнд явлаа гэхэд нь гайхсангүй ганц надтай хамт явъя гэсэнд нь гайхсан юм л даа. Цайны газар

түнжин хагарсныхаа дараа Костяг надтай уулзахгүй байх гэж бодсон юм. Гэтэл өөрөө утасдаад тэмцээнд хамт явъя гэдэг байна. Би ингэж утасдсанд нь баярлалаа. Би хувьдаа хэрэлдье гэж бодоогүй ээ. Костя бид хоёр Ленинградын өргөн чөлөөнд байдаг «Зөвлөлүүдийн жигүүр» клубт очлоо.

Костя намайг билетгүй оруулав. Би билетгүй орох дургүй, баригдчихаад байдаг юм. Чамайг танхимаас гаргаж байхад хүн бүхэн чамайг луйварчин аятай харвал ёстой муухай гэж мэд. Гэвч танхимд сул суудал өдий төдий байхад билет авна гэдэг тэнэг хэрэг. Костя тэмцээнд оролцогчийн хувьд ганц хүнийг оруулчих эрхтэй аж.

Танхимд хүн цөөхөн байлаа. Эд нь жинхэнэ үзэгчид бус биеийн тамирын янз бүрийн зүтгэлтэн шиг л санагдав. Энд эгэл жирийн л байдалтай, тэмцээний үеэр нөгөө их хорхойтож байдаг нь алга байлаа. Хэнгэрэг дуугарахад боксчид дэвжээн дээр хөдөлж, дэвжээний шүүгч тэмдэглэсэн зүйлийг цуглуулж аваад хажуугийн шүүгчдэд дамжуулан өгч, цаадуул нь боксчдыг ч харсан юмгүй өөр хоорондоо ярилцан, дасгалжуулагчид нь тамирчдаа алчуураар сэвж, тэдэнд нэг юм зөвлөх бөгөөд цаадуул нь аахилсаар алхайн сууж, дасгалжуулагчдынхаа үгийг чагнаж байгаа дүр үзүүлнэ. Зарим боксчид сайн, зарим нь тааруу зодолдож байсан боловч онцгой гойд юм огт алга байлаа.

Би Жек Лондоны «Мексик хүнийг» санаад мексик хүний ганган Деннитэй тулалдсан нь яагаад сэтгэл догдлуулж байсан бэ гэвэл мексик залуу үзэл санааны төлөө үзэлцэж, түүний тэмцэл сортоотой, хүнлэг байсан, тэгээд л эрх чөлөөний төлөө үзэлцсэн учир ялсан юм гэж бодлоо. Энд бол ердөө л хэн нь хүчтэй, гавшгай, туршлагатайгаа сорьж байснаас өөр юмгүй байв.

Нэг хүн хажууд минь ирж суулаа. Эргэж харвал Костягийн хойд эцэг байв. Тэр бас намайг харж, хаана үзлээ гэж бодож байгаа бололтой. Тэгээд санаж инээмсэглэн.

— Харах гэж ирэв үү? гэхэд нь

— Костятай хамт ирсээн гэлээ.

Тэр дахин инээмсэглэснээ, тэгэхдээ зовсон самгардсан байртай инээмсэглэснээ эргэж дэвжээ рүү харж эхлэв.

Урьдын адил тэр надад маш сайн хүн шиг санагдлаа. Сайн хүн гэдэг нь хараажаар илт.

Костягийн нэрийг зарлалаа. Костя олсон доогуур шургаж ороод буландаа очив. Дараа нь түүнтэй өрсөлдөх хүн гарч ирлээ.

Костя итгэлтэй үзэж байлаа. Тэр солгой болохоороо буруу өрөх бөгөөд солгой зөвгүй хүчтэй цохих учир энэ нь өрсөлдөгчдөө аюултай. Өрсөлдөгч нь өндөр хүн байлаа. Гэвч Костя эхний ээлжийн тоглолтод түүнийг муужруулж, 2 дахь тоглолтод бас дахин муужруулав. Шүүгч тулалдааныг зогсоож Костя илт ааглуу байгаа учир яллаа гэв.

Костягийн хойд эцэг над руу эргэж:

— Сайхан тоглож байна гэв. Хойд эцэг нь үнэн голоосоо баярласан байна. Нэгнийхээ амжилтад баярлаж байгаа хүнийг харахад сайхан байдаг юм.

— Бид хоёрыг тэмцээнд ирэхэд Костя дургүй байдаг юм. Олон боксчид үүнд дургүй юм байх аа. Костяд бүү хэлээрэй....

— Бүү санаа зов.

— За баярлалаа гэснээ мөрий минь алгадаад шалавхан гарч явлаа. Костятай дайралдчих вий гэж зовсон байх.

Миний аав намайг харах гэж сэм ирэхгүй ээ. Аав ил ирэх байсан. Би Костя шиг сайн тоглодог байсан бол хөгшдөө өөрөө урих байсан. Тэд харж л байг. Би Костя шиг лут зодолддог сон бол одоо суудлаасаа Костяг нам цохимоор байлаа. Костягийн хойд эцгийг би туйлгүй өрөвдөв. Тэр хүн Костяд хайртай байдаг, гэтэл Костя түүнийг басамжилж байдаг.

Костя хүрч ирээд бид хоёр тэмцээнийг хамт дуустал үзэв. Дэвжээн дээр хүнд жингийнхэн гарч ирэхэд жаал сонин боллоо. Хүнд жингийнхэн цохихын төстэй цохидог юм. Өнөөдөр дөнгөж шөвгийн наймыг шалгаруулж байна. Үзүүр түрүү булаацалдах болоход танхимд хөл тавих зайгүй болно гэж Костя ярив. Бид хоёр клубээс гарлаа.

— Беларусын буудал хүрээд тэндээсээ метрогоор явъя гэж Костя хэлэв.

Цэцэрлэгт гудамж Ленинградын өргөн чөлөөний дундуур гардаг юм.

— Веэн та хоёр яагаа вэ? гэж Костя асуулаа.

Одоо л эхлэх нь! Дахиад л булзааруулах хэрэг гарах нь. Веэн бид хоёр Мавродакийн тухай ярьсан, гэтэл түүнийг ярихыг Костя хориглосон. Веэн надтай ярьснаа Костяд хэлээ биз дээ. Бүр залхаж гүйцлээ, нээрээ шүү. Нууц, нууц гэнэ. Тэсвэрлэхийн арга алга!

— Чамайг сийлбэр солиоч гэж гуйгаа юу?

Уухайс, сийлбэрийн тухай яриа юу. Тэгэхлээр Веэн Мавродакийн тухай надтай ярилцсанаа хэлсэнгүй байх нь. Жигтэй юм аа! Яасан юм бол?

— Тэгсээн

— Чамд оронд нь сайн сийлбэр өгнө гэсэн юм биш үү?

— Надад солих эрх байхгүй.

— Хэний юм?

— Зураач Краснухиных.

— Чамд ямар ялгаа байсан юм?

— Веэнтэй нийлэхээ больё.

— Надтай?

— Чамтай бол болохгүй яах вэ.

Костя чемоданаасаа нэг сийлбэр гаргаж ирлээ. Энд илд, жижигхэн саадагтай нум сум агссан морьтой баатрыг дүрсэлжээ.

Хүн нь мориноосоо ойчоогүй, тэр ч байтугай холбиороогүй, дэл рүү нь бөхийгөөгүй байсан боловч шархтаад хариугүй унах гэж байгаа нь тодорхой байлаа. Гайхалтай юмаа. Энэ сийлбэрт ямар нэг ухаан хүршгүй хөдөлгөөн гаргаж, морь эцсийн удаа харайж, ингээд морь хүн хоёр хоёул годройтон унах гэж байгаа хөдөлгөөн гаргасан байлаа.

— Энэ чиний соноос дээр.

— Чи Веэнд сольж өгөх гэж байна уу?

— Чамд ямар ялгаа байсан юм?

— Веэнд түүнийг өгөхгүй ээ. Чи Веэний төлөө тэгж санаа тавьдаг юм бол яагаад ном барьсан хүүхдээ өгөхгүй байгаа юм? Веэн тэр сийлбэрийг Москвагаар л нэг эрж байдаг, гэтэл тэр нь чамд байгаа.

— Чамд хамаагүй.

— Надад хамаагүй ээ?! Тэгвэл миний хэрэгт ч хөндлөнгөөс бүү ор. Сийлбэрийг чамд өгөхгүй! Өөр ярих юм алга.

— Ярих юм ч бий дээ гэж Костя шүд зууж хэлэв.

Дахиад сүрдүүлэх нь! Элэг авмаар юм.

— Костя чи дуулж бай. Өөр л хүнийг айлгаж, далайлга. Би үүнийг дээр чамд, хэлсэн, дахиад ч хэлчихье. Чиний тэр Веэн чинь зальхай этгээд, мэдэв үү. Чи үүнийг мэдэх цаг ирнэ, гайгүй. Харин хэт оройтож л таниузай. Тануус хүн мэхлэх, худал хэлэхээс өөр юм мэдэхээ байж. Би тэгэх дургүй. Чиний хойд эцэг элбэрэл журамт сайн хүн юм. Гэтэл чи түүнд хүний мөсгүй аашилж байдаг. Веэн зальхай амьтан байдаг, гэтэл чи түүний ганц нөхөр нь байдаг.

— Энэ чамд падгүй гэж Костя зандрав.

— Чиний хэрэг надад падгүй, минийх чамд хамаатай байдаг.

Ингэж таарахгүй дээ!

Миний хэрэг бол миний л юм. Чинийх бол бидний хамтын ажил. Бид энэ ажлыг хамт хийж байсан.

— Урьд тэгж байсан, одоо үгүй ээ. Чи Веэнээс мөнгө олох хэрэгтэй байгаа байж, над бол хэрэггүй. Чи биеэ тун хямдхан худалдаж байгаа юм биш биз. Залийн хөрөнгө Веэн чамайг хүмүүжүүлсэн хүнээс үнэ хүндтэй байдаг. Би дөнгөж сая хойд эцэгтэй чинь дайралдсан.

Костя намайг харав.

— Чи хаана тааралдав.

— Клубт. Чамайг ялсанд тэр хүн хэчнээн баясаж баярлаж байв. Гэтэл чамаас болоод аав чинь чамайг харах гэж сэм ирж байдаг. Өөртэйгөө уулзлаа гэж чамд битгий хэлээрэй гэж надаас гуйсан. Чи яаж хүнийг басамжилж байна даа. Чамд муу юм юу хийсэн юм бэ? Чи эцэг эхээ зовоож байна. Тэгэхдээ, хэнээс болж гээч? Зальхай Веэнээс болж шүү. Веэн чиний юу юм? Чи түүнд ном барьсан хүүхдээ өгөхгүй шүү дээ.

Энэ таавар толгойд гэнэт харван орж ирэв. Костя дуугарсангүй. Би яг ончийг нь онолоо. Амжилтаа лавшруулах хэрэгтэй.

Хүн болгоныг тэнэг гэж бүү бод. Хүний ярихыг хориглосноор түүнийг бодохыг болиулахгүй. Чи нэг нэрийг дурсахыг хориглосон, гэхдээ тааж бодохыг хориглож чадахгүй... Тэр хүний хамгийн урьдаа барьдаг сийлбэр чамд байгаа нь ямар учиртайг би мэдэхгүй. Гэхдээ Веэн хэний цуглуулгын хойноос хөөцөлдөж байгааг мэдэж байна. Чи ч үүнийг мэдэж байгаа. Веэн ямар хүн болохыг ч чи мэдэж байгаа. Дотуур тамиртай, итгэлгүй, бүхнийг будилаантуулж, бүгдийг хооронд нь хэрэлдүүлж бүгдийг мэхлэгч. Чамайг ч хуурч байна. Үүнийг чи мэдэх болно.

Костя дуугарсангүй. Царайд нь шаналсан байдал тодров. Бид хоёрын ярьсан юм түүний амьдралын хамгийн гол хамгийн чухал зүйл. Үүнийг л ярих хэрэгтэй, өөр юу ч ярих ёсгүй. Тэгээд би:

— Краснухин Мавродакийг сайн таньдаг байсан байна. Тэднийд очъё гэв.

Би Краснухинд дөнгөж гурав дахиа ирж байгаа боловч дандаа орж гарч байдаг юм шиг санагдаж, юм бүхэн нь нүдэнд дулаахан, танил дасал болжээ. Юм нь шавааралдсан давчуу хэвээр байна. Хоол ундны үнэр ханхалж, Галя Саша хоёр буйдан дээр тонгочин, утас хангинахад, Краснухин харилцуурыг аван хүнгэнэж байх бөгөөд Веэнийх шиг үнэтэй цайтай зураг, хуучны тавил, чамин чимэглэлийн зүйлс байхгүй боловч чухам энд ёстой урлагийн хүн ажиллаж суудаг нь илт байна.

Краснухины царай урьдынхтай адил санаа зовсон байдалгүй, амарлингуй тайван байв. Бүх ажил явдал нь бүтэмжтэй байгаа бололтой. Нэгэнт учраа ярилдаад, одоо айдаггүйгээ авдартаа хийсэн шиг байна.

Краснухин хар хөх костюм, цагаан цамц өмсөж, зангиа зүүжээ. Костюм нь элэгдэж хуучирсан, элбэгдүү байсан боловч Краснухин үүнтэйгээ булиа сайхан, буурьтай харагдах ажээ. Баяр болсон юм шиг хөхиүн байлаа. Гал тогооноос загас ч биш, сүү ч биш, нэг л амттай, хорхой хүргэсэн шарсан махны болов уу гэмээр үнэр гарч байлаа.... Краснухины авгай ажил ихтэй байсан боловч гийчин хүлээсэн эзэгтэйн хувьд урьдынхтайгаа адилгүй шалмаг хөдлөх ажээ.

— Би өнөөдөр мөнгөтэй байна, хүрээд ир гэж Краснухин утсаар нэгэн хүнд хэлж байв.

Цааш ярилцсанаас нь Краснухин яаралтай захиалга биелүүлж, хэвлэх үйлдвэрт нэг хүний номд зураг чимэг хийж өгөөд түүнийгээ мялаах гэж байгаа юм байна гэдгийг би ойлгов.

Аз таарах нь цөөхөн айлд нэн мэдэгдэхүйц байдаг аз дайрчээ. Үүнд нь би баярлалаа. Нэргүй зурагчид ч гэсэн аз таарах цаг байх шүү дээ?

Краснухин том нүдээрээ Костяг нэлээд удаан ширтэв. Намайг эртээд ч, түүний түрүүн ч ингэж хараагүй. Костяг бүр онцгой, би бол гайхаж мэлэрчээ гэж хэлэхээр харж байлаа. Энэ хоёрыг хоёулхны нь үлдээвэл хамгийн зөв юм. Би бослоо.

— Би ч явья даа. Костя чи сууж бай.

Костягийн гайхан харснаас үзэхэд миний нарийн ухааныг ойлгосонгүй.

Тэгэхэд би Краснухинд:

— Евгений Алексеевич аа, энэ миний найз Костя. Та үүнд профессор Мавродакийн тухай ярьж өгөхгүй юу? гэлээ.

Краснухин Костяг бас дахин нэг харснаа, бичиг цаас онгичиж, баахан хавтасны үдээсийг нэг тайлан нэг эргүүлж уясаар жаал болсноо, эрсэн юмаа олов бололтой хэсэг хүний том гэрэл зураг гаргаж ирээд,

— Манай төгсөлтийнхөн гэв.

Тэдний дунд инээмсэглэн сууж байгаа намхан бараан царайтай хүнийг шовх үзүүртэй харандаагаар заав. Энэ бол Мавродакий ажээ. Костятай адилхан гэхэд гайхалтай адилхан хүн байна. Костя зургийг цоо ширтлээ.

Би түүнд саад болохыг хүссэнгүй, хажуу тийш болж хананд өлгөөтэй байгаа гарын гөлтгөнөн баримлыг үзэв.

Краснухин ч гэсэн Костяг анхаараагүй царай гарган, өрөөн дотуураа явж, нэг юм авч үзсэнээ засаж тавьж, гал тогоо уруугаа орж, авгайтайгаа ярилцсанаа дахин буцаж ирж байв. Зүгээр сууж чаддаггүй нь, хар хөх костюмдаа дасаагүй, цагаан цамц, зангиа өөрт нь эвгүй оргиод байгаа нь илт.

— Та надад үүнийгээ өгчихгүй биз дээ? гэж Костяг гуйхад

— Бүр өгөхгүй ээ, буулгуулаад авбал ав гэв.

— Энэ Владимир Николаевич уу? гэж Костяг гэнэт асуухад

Краснухин гэрэл зураг руу тонгойгоод

— Тийм шиг байна... Тэгэхэд аспирантурт байсан юм гэв.

Энэ чинь сонин юм байна. Вээн бүр тэр үед Мавродакийг таньдаг байж. Яагаад үүнийг хэлдэггүй билээ?

— Та Максимов гэдэг нэрийг дуулсан уу?

— Ямар хүн юм бэ?

— Шүүмжлэгч л байх.

Тэднээс л холхон явъя.

— Владимир Николаевич таныг шүүмжилсэн гэсэн байхаа.

— Тэгсэн.

— Юу гэж бичсэн юм бол?

— Чамд сонин байна уу?

— Сонин байна.

Краснухин буланд хэвтэж байгаа бөөн сэтгүүл рүү дохиод

— Өнгөрсөн оны гуравдугаарыг үз гэлээ.

Сэтгүүлийг олоход тийм ч амаргүй ажээ. Краснухины хайнгуудыг би гайхаж хоцров. Өөрийн нь тухай өгүүлэл гарсан байдаг, гэтэл хааш нь хийснээ мэдэхгүй байдаг.

Би сэтгүүлийг Краснухины заасан бөөн сэтгүүл дотроос олсонгүй, харин огт өөр булангаас зорогч суурь машины араас олов.

Краснухины уран бүтээлийг бие даасан байдалгүй гол чиглэлгүй гэж өгүүлэлд бичсэн байлаа. Дараа нь «Урлаг бол өөрийг нь ард түмний хүртээл болгодог хүнийх байх ёстой» гэсэн өгүүлбэр байв. Зөв санаа. Гэвч Везн надад «Урлаг бол хайрлаж, ойлгож, хамгаалдаг хүнийх байх ёстой» гэж огт өөр юм ярьдаг. Тэр ч байтугай нэг удаа «Үзэсгэлэн үзэхээр хамаг юмыг чинь хулгайлж авчраад тавьчихсан шиг санагддаг» гэсэн юм. Урлагийг аминдаа өмчилж, шүүгээ, тавиураа дүүргэхийг санаархаж байгаа юм. Везний зальхай этгээд гэдгийг би тэртэй тэргүй мэдэж байгаа юм чинь, бодох нь нэг анги, бичих нь нэг анги байгаад хачирхах юмгүй. Максимовын өгүүлэлд энэ асуудлыг бас тайлбарласан байсанд учир нь байгаа юм. Тэр энэ байна. Урлаг нь эрхэлдэг хүндээ хамаардаггүй. Урлаг бол давын өмнө зэвсэг мөн... Санаа нь ондоо юм, гэвч үүнийг нэг л хүн хэлсэн, тэр нэг л зарчимгүй хүн хэлсэн гэдэг нь илт Максимовын өгүүлэлд харааж зүхсэн юм их, Везнийхэд бага байсан боловч нэг л гараар бичсэн гэдэг нь тодорхой!

— Та сэтгүүлээ хоёр хоног өгөхгүй юу.

— Хи.. Би оргүй хоцрох нь ээ? За яах вэ, ав. Эргүүлж л өгөөрэй...

Сул гартай сонин хүн шүү!

— Хоёр хоноод сэтгүүлийг тань авчирч өгнө өө.

Краснухин шүүгээнээс өндөр турьхан иштэй цэцгийн чийдсэн дугуй сийлбэр гарган ирэв. Амьдралын баяр баясгаланг түгээсэн булбарай гоё цэцэг наран зүг тэмүүлнэ. Эргэн тойронд амар түвшин налайж ногоо жигдрэн тэнгэрийн хаяанаа наран төөнөөд, цэцэг орь ганцаараа бардамхан дэлгэрч, дээш тэмүүлсэн эрчдээ ялихгүй бөхийжээ.

— Энэ нэцкэгийн юу нь гоё байна вэ? Үүнийг урласан хүнийг эзэмдсэн сайхан сэтгэл, зуу зуун жилийн өмнө ч хүн ард гоо үзэсгэлэнд хөхөн баясаж байсныг ухамсарласан сэтгэл нь гоё байна. Би л бол хүнд сайхан сэтгэл хэр зэрэг төрүүлж байгаагаар нь л урлагийн бүтээлийг үнэлнэ.

— Энэ зөв өө. Бүүр Пушкин «Уянгалаг найргаараа би уяхан сэтгэл төрүүлнэм» гэж хэлсэн шүү дээ...

Краснухин намайг нэг хараад, үг дуугарсангүй. Юу ч гэж хэлэх вэ дээ. Пушкинээс илүү яаж хэлэх вэ! Краснухин сийлбэрийг хайрцагт хийж Костяд өгөөд

— Май, энэ чиний эцгийн цуглуулгынх гэв.

Костя бид хоёр Краснухиныхаас гарлаа.

— Краснухин ёстой сайн хүн гэж би хэлэв.

Костя дуугарсангүй.

— Веэн түүнийг муучилсан өгүүлэл бичсэн байна гэж би үргэлжлүүлэв.

Костя дуугарсангүй.

— Сайн хүн тийм олиггүй юм бичихгүй гэж би дүгнэлт хийв.

Костя дуугарсангүй.

— Эцэг чинь яаж үхсэнийг чи мэдэх үү? гэхэд минь түүний царай хүрлийн,

— Мэднэ ээ гэв.

— Яагаад тэгснийг нь мэдэх үү?

— Ээж маань өөр хүнтэй суучихсан юм.

— Хэн чамд тэгж хэлсэн юм бэ?

— Энэ ямар хамаатай юм.

— Ингэж чамд хэлсэн хүн бол худалч, Мэхлэгч мөн.

— Бүү дуугар, чи юу мэддэг юм.

— Өөрөө дуугүй бай. Би чамаас илүү мэднэ. Чи үүнийг одоо мэдэх болно гайгүй. Аль вэ сууя.

Бид урт сандал дээр суув. Би түүнд Максимовын өгүүллийг өглөө. Костя түүнийг уншив. Царай нь огт хувирсангүй. Яриа байхгүй, сэтгэлээ сайн барьдаг залуу юм.

— Одоо бүгдийг мэдэв үү? гэж би асуулаа.

— Тэд яагаад үүнийг нуусан юм бол? гэж Костя хэлэв.

— Чи ингэж хэлж яаж болох вэ. Чи учир байдлыг мэдэхгүй шүү дээ. Чи ээжтэйгээ нэг ч удаа яриагүй байж түүнийг яаж зэмлэж болох вэ! Чи ер нь түүнийг зэмлэх ёсгүй, тэр бол эх чинь шүү дээ.

— Хэнийг ч зэмлэсэн юм алга, гэхдээ тэдэнтэй хамт байхгүй.

Үүнийг угийн мугуйд зангаараа хэллээ. Гэвч өгүүлэл уншаад сэтгэлд нь нэг юм орсон шиг байна. Энэ нь мэдэгдэж байв. Костя худал хэлдэг орчинд өсөж, муу зан сурчхаад, хэнд ч юунд ч итгэхээ больжээ. Хайран залуу, энэ муу занг нь яаж засах вэ?

— Цуглуулга яасан бэ?

— Бүү мэд.

— Чи ээжтэйгээ ярих уу?

Тэр дуугарсангүй.

— Чи ээжтэйгээ ярина биз?

— Бодож байж болно гэж Костя хариулав.

Спортын барааны дэлгүүрийн хашаанд охид мухлагт тэрэгнээс ачаа буулгаж байв.

Шмаков Петр тэднийг хөгжөөн баясгаж байна. Нэг балай юм хэлэхэд нь цаадуул нь инээлдэнэ. Шмаковыг ямар ч дэмий юм донгоссон, охид хөхрөлдөнө гээч. Хөл бөмбөг авч явааг харчхаад тэр бөмбөг гуайг ч оруулна даа» гэхэд нь цөмөөрөө л тас тас хөхөрнө. Гэтэл инээдэмтэй юу байна? Одон бөмбөгний цохиур авч явааг үзчихээд «Үүн дээр чинь суугаад сар руу нисчихье» гэнэ. Шал маанаг юм. Гэтэл цөм инээлдэнэ гээч.

— Ажил тараад яах вэ? гэж Шмаков Зоягаас шулуухан асуулаа.

— Чи яалгах гэсэн юм? гэж Зоя сэргэлэн хариулав.

— Надад гайхалтай пянз, Крошт сул байр байна. Нийлэхэд надад дургүйцэх юм байхгүй. Гэвч миний завтай эсэхийг урьтаад асуучхаж болмоор.

Цахилгаан пянз тоглуулагчаас гадна Шмаков олон шинэ пянзтай хайрцаг авчрав. Хаанаас олсныг нь асуухад

— Миний авсан газар одоо байхгүй болсон гэлээ.

Ялангуяа охидод сүрхий хүн болж гайхуулах дуртай. Тушааж захирах, мөн гудрах дуртай хүн дээ.

— Бүсгүйчүүд лав өлсөө биз? Крош оо, өндөг шараач.

— Би өөрөө шарья гэж Зоя хэллээ.

Светлана, Рая хоёр сав суулга угаав. Зоя өндөг шарж, би ширээ засан Шмаков пянз тоглуулагч дээр пянз тавьж байлаа.

Зугаалган дээрхээс дутахааргүй маш хөгжилтэй сайхан боллоо. Бид найман шарсан өндөг идэж (хоёрыг нь би урьд идчихсэн юм) бүх ээдмээ цохилоо. Шмаковыг боодолтой нунтаг махаар цөмөөр нь шөл хийхийг шаардаад байхлаар нь би түүнийг өөрөө хий гэсэнд мань эр залхуурав.

Дараа нь бултаараа зурагт радиогоор уран гимнастикийн тэмцээн үзлээ. Охид тэмцээнийг их таашаав. Тэд гимнастикчдын өмсөж байгаа шиг костюм, шаахай дэлгүүрт нь саяхан гарсан гэж ярьцаалаа.

Би, маргааш бүгдээрээ Химки рүү, гол дээр очъё гэлээ.

— Маргааш чадахгүй ээ гэж Зоя нэг л жоготой инээмсэглэн хариулахлаар нь

— Маргааш чинь Даваа гариг, дэлгүүр амардаг шүү дээ гэвэл

— Амардаг болоод л чадахгүй гэж байна гэв.

Охид хи хи гэлдэж, нүд ирмэлцэх нь нэг их нууц юм мэдэж байгаа царайтай.

— Тануус яав? гэж би гайхахдаа асуулаа.

Тэд гайхсаныг минь ч тоохгүй, асуусныг минь ч хайхрахгүй нүд ирмэлцэж, хи хи инээлдэн, жиг жуг гэлдэж Зояг тийм юм худалдаж ав, ийм ч юм худалдаж ав гэж байна.. Хи хи гэлцэн, нүд ирмэлцэж ирмэлцэж, тоомсоргүй царайлж царайлж, Зояг шинэ гэр бүл бологчдын дэлгүүрт очих гэж байгаа гэж ам алдав. Худалдааны ажилтны хувьд уу? Санал солилцох юм уу? Гэвэл огт үгүй гэнэ. Зоя хүнтэй суух гэж байгаа болохоор шинэ гэр бүл бологчдын дэлгүүрт очих гэж байгаа юм гэнэ. Ах нь гэж миний бодож байсан өнөөх гооногорттой суух юм байх.

— Энэ үнэн үү? гэж намайг бардам асуухад минь

— Энэ үнээн гэж Зоя мөн л бардам хариулахдаа нөгөө хараал хүрмээр инээмсэглэдгээрээ инээмсэглэв.

Петр Шмаков намайг харлаа. Тэгээд бас тавлаж байгаа шүү, эргүү амьтан чинь. Надад ямар хамаатай юм бэ. Би ямар түүн шиг Зояд дурласан биш. Бүсгүй нь хүнтэй суух болчихсон байхад жуумалзаад сууж байгааг нь.

— Крош битгий уруу царайл, Бид чамд өөр хүүхэн олж өгнө гээд Раяг инээхэд нь

— Үүнийг чинь мэдэж байсан юм аа. Нөхөр болох хүн нь таксины жолооч гэхэд минь.

— Чи яаж мэддэг юм гэж Зояг гайхахад

Дэлгүүрийн дэргэд ирж байхыг нь харсаан гэж Шмаков миний гярхайд атаархан хэлэв.

— Би дэндүү их юм мэддэг болохоороо амьд явах ч сонингүй болжээ гэж би Игорийн цэцэрхдэгийг давтав. Энд харин энэ үг хэрэг боллоо. Хамгийн гол нь нэрээ хугалахгүй байх хэрэгтэй. Зояг таксигаар хэн зөөж муу зан сургасныг тааж цөхөх юу байх вэ?

Харин тэгэхэд ойд үнсүүлдэг нь юу вэ. Ийм л улс даа.

Зояд тийм их дурлаагүй байжээ. Аятайхан нь аятайхан л охин. Зоя, Майка бид гурав галт онгоцоор аялж явтал онгоц живлээ гэж бодвол эхлээд Майка Зоя хоёрын чухам хэнд нь туслах гэж очихыгоо мэдэхгүй л байна. Лав Майкаг л эхлээд татаж гаргах байх: Майкаг татаж гаргасан хойноо Зояг аврахаар орох байх. Энэ завсар Зоя живчихийг байг гэхгүй. Гэвч живчихнэ гэж бодохгүй байна, Зоя чийрэг, махлаг охин. Махлаг улс усан дээр тогтохдоо сайн, тийм амархан живдэггүй.

Сайн бодоод үзвэл Зоя надад дурласан юмгүй, зүгээр л саваагүйтэж байж. Тэгнээ тэр, доогтой, зоригжуулсан, ялихгүй сониучирхсан үл мэдэг эргэлзсэн янзтай жуумалздаг нь нэг л сэтгэлд юм оруулаад байсан юм. Елизавета Степановнатай адилхан инээмсэглээд байсан юм. Ингэж инээдгийг чөтгөр аваасай. Угтаа бол хөнгөмсөг, сээхэлзүүр хүн л ингэж инээмсэглэдэг юм. Майка инээмсэглэнэ гэж байхгүй. Майка хэзээ ч хоёрын хооронд байдаггүй. Автобаз дээр үйлдвэрийн практик хийж байхад засварчин Лагутиныг яаж болгож тавилаа даа. Майкатай ярих юм олдоно. Заримдаа санал зөрөх удаа байвч энэ нь зүйн хэрэг, хүн хүн дандаа адил бодож байх гэж яах вэ? Гэтэл Зоятай юу ярихаа мэддэггүй юм. Бид хоёр бие биеэ ойлгодоггүй юм. Шмаков Петрийг болохоор ойлгоод намайг болохоор ойлгодоггүй. Хэнд ч ялгалгүй тал өгч явдаг охиныг эргүүлнэ гэдэг тийм ч сонин биш.

Би сэтгэлээ засаж байгаа нь энэ. Ямар ч гэсэн гомдмоор юм. Веэнд царай өгч байсан нь санаандгүй байж магад. Гэвч надад юу боллоо гэж тэгсэн юм бол? Инээмсэглэж, үнсүүлж, кинонд явж байсан гээч. Хөнгөмсөг охин юм. Тэр гооногор Зоятай гэрлэж, алд дэлэм алдаж байна даа.

Охид надаар наадам хийсэн байлаа ч гэсэн одоо больё оо. Зоятай ингээд больё. Гэвч тэд тоглоом хийгээгүй ээ. Шинээр гэр бүл бологчдод зориулсан танхимшуу юмнаасаа юу юу худалдаж авбал дээр вэ гэж ярилцаж байсныг бодоод үзсэн ч тэр дээ.

Гэсэн ч гомдолтой юм. Бодохоос гол харлаад байв. Энэ зун бишгүй л юм үзлээ. Нуруу хэрхэн хүйт даадаг, гол хэрхэн харладгийг

мэддэг боллоо. Өөрөөр хэлбэл, манай хүмүүжүүлэгчдийн ярьдгаар бол хашир танилаа. Ингэлээ гээд тус юу байгаа юм бэ?

Бүү мэд.

Би Зосяг хэргээр бодохгүй байв. Маргааш нь Костягийн утасдахыг хүлээж өнжив. Эзгүйд минь утасдах болуузай гэж болгоомжлоод гэрээс гаралгүй, боодолтой нүдсэн махнаасаа гурван боодлыг цохичхоод, байгаад байлаа.

Костя утасдахгүй болохоор би өөрөө тэднийд очив.

Костягийн ээж гунигтай харцтай туранхай эмэгтэй надад хаалга онгойлгож өгөөд Костяг өрөөндөө байгаа гэлээ. Костягийн дүүгийн төгөлдөр хуур дарж байгаа том өрөөгөөр дамжин, тагтанд оров. Костя эвхмэл орон дээр ном уншаад хэвтэж байлаа. Намайг нүднийхээ булангаар харсан боловч номоо тавьсангүй,

— Яагаад утасдсангүй вэ? гэж асуухад минь

— Ажилтай байсан гэж хариулав.

Би их тасалгаа өөд толгой дохиж

— Ярьсан уу гэвэл

— Ярьсаан гэлээ.

— Тэгээд яасан байна?

— Өгүүллээс хамаг юм болж.

— Тэгж таарна. Тэгвэл харьцуулаад үз гээд би түүнд Вээний өгүүлэлтэй сэтгүүлийг өгөв. Тэнд Максимовын өгүүллийг хуулж авснаа хавчуулсан юм.

Өөр ярих юм байсангүй. Костя учрыг ойлгохоор ухаантай хүүхэд.

— Ээж энэ явдал болсноос хэдэн жилийн дараа хойд эцэгтэй суужээ. Хойд эцэг маань намайг үрчилж авч. Миний аав яаж үхсэнийг хэлээгүй нь миний урмыг хугалахгүй гэсэндээ ч юм уу, надаас үнэнийг нуусан юм санж гэж Костяг хэлэхэд нь би

— За яах вэ, дүнг гаргах цаг яг болж гэвэл,

— Би өөрөө гаргая гэж Костяг хэлэхэд,

— Хоёул хамт гаргая гэж би хариуллаа.

Везн биднийг очиход хар авав. Намайг дахиж ирнэ, тэгэхдээ Костятай ирнэ гэж санасангүй.

Костя ном барьсан хүүхдийг ширээн дээр гаргаж тавив.

— Чи хаанаас авсан юм бэ? гэж Везнийг тайван асуухад нь

— Надад уулын байсан юм гэж Костяг хариулбал цаадах нь

— Өө гэлээ.

Везн тайван байх гэж оролдох боловч түгшиж байгаа нь илт ажээ.

— Краснухины тухай таны бичсэн өгүүллийг би уншиж үзлээ, сэтгэлд таарсангүй, гэж. Костяг хэлэхэд

— Надад өөрт минь ч гэсэн аятайхан болоогүй гэж бодогддог юм. Гэхдээ өөр хүн бичсэн бол түүнээс ч доор юм бичих байсан гэж Везн хариулав.

Костя дэндүү тойруу юмнаас эхэлж байна. Ингэвэл хэзээ гол зүйлдээ орох юм бэ.

— Та Максимов гэдэг хүнийг таних уу? гэж тас түс асуухад минь

— Юун Максимов? гэж Везн надаас эргүүлж асуулаа.

— Дөчин найман онд Костягийн аавын тухай өгүүлэл бичсэн юм байна.

Миний мэдэх түр зуурын шөвөгдсөн, үүний чацуу арчаагүй харц гялсхийв.

— Тийм ээ, тийм өгүүлэл гарсан, санаж байна.

— Максимов шударга бус хүн байна гэж Костяг хэлбэл

— Чи туйлын шударга хүн олоо юу? Хаана байна. Нэрийг нь хэлээрэй! гээд Везн нүдээ аньсхийв.

Костя намайг харлаа. Везн түүний намайг харахыг үзээд тоомсоргүй үрчийж

— Крош хоосон санаашрагч, хий зөгнөгч амьтан. Гэтэл чи амьдрах хэрэгтэй. Хаана гээч. Дорой нь хувь заяаныхаа эрхшээлд ордог ертөнцөд амьдрах болно. Толгой дааж явбал чи хаа ч газардахгүй. Тэгвэл би чамайг тийм байлгаж чадна.

Везний цогтой ярьж байгаад би гайхав. Костяд хайртай нь үнэн юм. Ингэж нээрэн яриад байхлаар би ч эргэлзэж хоцров. Дахиад л сэтгэл хоёрдож ирлээ. Биеэ барих хэрэгтэй. Костяд хайртай гээд ач тус

нь хаа байна вэ. Вотрен ч Люсьена де Рюбампред хайртай байсан шүү дээ.

— Профессор Мавродаки, зураач Краснухин хоёрын тухай өгүүллийг нэг л хүн бичсэн юм шиг бодогдоод байх юм гэж би хэлээд тавьчихлаа.

Ингээд дараа нь яах бол гэж огт бодоогүй юм. Везн над руу ухасхийж намайг заамдаж авлаа. Сууж байсан минь аз болж. Зогсож байсан бол лав унах байлаа. Намайг мөн ч ширүүн дайрлаа шүү. Костя гараас нь барьж аваагүй бол багалзуур шахах байсан байх юм. Нээрээ гэм!

— Өөдгүй новш! Яаж зүрхэлнэ ээ! Хог! гэж Везн уруулаа чичвэгнүүлэн бувтнав.

Би жаахан айсан байх аа. Багалзуурдаж байхад айлгүй яах вэ! Бодоод байхад ер нь үзэшгүй муухай юм боллоо. Везнийг зодох гэж дайрна гэж хэн санах вэ.

Везн сандал дээр лагхийтэл сууж, нүүрээ дарав. Өрөвдмөөр ч юм шиг, дотор минь нэг л эвгүй болов.

Костя үүнд огт сэтгэл хөдөлсөнгүй. Хайхрамжгүй хүйтэн царай нь харагдахад л илт.

Зөв!

Везн Костяд сайн байснаараа нүглээ цагаатгах гэжээ. Гэтэл Костяг яг өөр шигээ луйварчин болгох гэж байлаа шүү дээ. Ямар үхсэний нь цагаатгах вэ. Гэмээ хүндрүүлж байгаа хэрэг.

Везн нүүрээ дарсан чигээрээ бөглүү дуугаар:

Костя, бүх юм чиний бодож байгаа шиг ч биш ээ. Яваандаа чи цөмийг ойлгох болно... Надад л итгэж, миний хийж байгаа бүхэн зөвхөн чиний төлөө юм шүү. Чи үүнийг мэдэж байгаа.

— Максимов гэж та юу? хэмээн Костяг асуухад

— Биш ээ! гэж Везн хашхиран гараа авахад нь царай нь өтөлчихсөн юм шиг харагдахад би гайхав.

— Максимов гэж би биш, Максимов гэж цаг үе... гэв.

«Муу цаг гэж байдаггүй, муу хүн гэж л байдаг» гэж Везнд хэлбэл таарах байсныг сүүлд нь ухаарав. Ингэж хэлсэн бол доо. Далим гарвал хэлэхдээ л хэлнэ.

Гудамжинд гараад юу болсныг ярилцах гэлээ. Зарим нарийн ширийн юмыг тодруулах хэрэгтэй байв. Гэвч Костя ярих дургүйхэн байлаа. Намайг:

— Манайд очиж байх уу? гэж асуухад

— Очно оо гэв.

Костя халааснаасаа ном барьсан хүүхдийг гаргаж надад сарвайв.

— Май ав, цуглуулах ч юм билүү...

— Яах юм? Даанч үнэтэй эд. Цуглуулах эсэхээ мэдэхгүй л байна.

Үгүй нь л ортой болох байх. Тэгээд л энэ чинь...

Энэ сийлбэр эцгийн чинь дурсгал шүү дээ гэж би хэлэх гэсэн юм.

Гэтэл Костя үгийг минь гүйцэд хэлүүлсэнгүй.

— Надад бас нэг бий. Яагаа вэ, Краснухины өгдөг цэцэг бий...

гэхэд нь.

— Баярлалаа Манайд ирж байгаарай гэж би хэллээ.

— За тэгэмз гээд Костя эргэж гудамжаар цааш явав. Би түүний давжаахан боловч шөрмөслөг биеийг хэсэг харж зогстол тэр ч олон хүний дунд орж харагдахаа болилоо.

Гэртээ хариад ээж, хойд эцэгтэйгээ яаж ярихыг нь төсөөлөн бодлоо. Костягийн хойд эцгээр үзэхэд ертөнц дээр сайн хүн муугаасаа хавьгүй олон юм даа гэж бодогдов.

Тэгээд би хайрцгийг нээн Мавродакийн цуглуулгын шилдэг сийлбэр ном барьсан хүүхдийн сийлбэрийг дахин үзлээ.

«Хөвүүн алсыг ширтэнэ. Мэлмийд нь юу үзэгднэм бэ?

Жигүүртний донгодох дуун адил битүүлэг дүр хөвүүний хүслийн үзүүрт тодорно уу? Ер санасан бүхэн сэтгэлчлэн бүтдэг болгохын тулд бид юу хийв?» Бэлэгтэй сайхан үг байгаа биз, тийм ээ?

Тэмдэглэлээ үүгээр эхэлсэн, үүгээр бас дуусгая.

Б а я р т а й.

Уг номыг “[Болор дуран](#)” шалгуураар шүүсэн болно.

Программтай танилцах бол сурталчилгаа дээр товшиж холбоос руу орно уу.



БОЛОР ДУРАН 2.0
МЭДЭЭ ШАЛГУУР

"БОЛОР ДУРАН" ЗӨВ БИЧИГ ШАЛГАХ ПРОГРАМ

- ✓ 60 сая үеийн сантай.
- ✓ Алдаатай үесийг илрүүлж, зөв үесийг санал болгоно.
- ✓ Хэлзүйн тайлбар тольтой.
- ✓ Хувийн үеийн сан үүсгэх боломжтой.



1974 оны хэвлэлийн Хэвлэн нийтлэлийн мэдээлэл:

АНАТОЛИЙ РЫБАКОВ

КРОШИЙН ЗУНЫ ТЭМДЭГЛЭЛ

КАНИКУЛЫ КРОША

Сургуулийн дунд, ахлах насныханд

БНМАУ

АРДЫН БОЛОВСРОЛЫН ЯАМНЫ ХЭВЛЭЛ

УЛААНБААТАР 1974

Орчуулсан Г. Аким

Редактор П. Чойжил

Зураач А. Лүндэн

Уран сайхны редактор З. Нямжав

Техник редактор Б. Алтансаргай

Хянагч С. Норовсүрэн, Ц. Доржсүрэн

За № 270 Хэв газ № 158/73

Өрөлтөд 1973—9—5-нд.

Хэвлэлтэд 1974—1—10-нд

Цаасны хэмжээ 84X108/32

Хэв хууд. 4,0

Хэв нэгж хууд. 6,35,

Тооцооны хуудас 5,59

Хэвлэсэн тоо 5300

БНМАУ Ардын Боловсролын Яам

Барилгачдын талбай 15.

Д. Сүхбаатарын нэрэмжит Хэвлэлийн комбинатад хэвлэв.

Д. Сүхбаатарын талбай 2.

Заметки

[←1]

Ая, хорвоогийн алдар юутай амархан мөхнө вэ

[←2]

Амьдрал гэдэг энэ гэсэн франц үг.